**Үндэслэл:** ДЭМБ-ын тооцоолсноор жил бүр 2 сая жирэмсэн эмэгтэй тэмбүү өвчинтэй нь оношлогддог ба эмчлэгдээгүй, дутуу эмчлэгдсэн тэмбүүтэй эхээс төрсөн хүүхдийн 25%-д амьгүй буюу жин багатай төрөлт, 25-30%-д нярайн эндэгдэл, 5%-д гаж хөгжил, 40%-д төрөлхийн тэмбүү өвчин тус тус тохиолддог байна. Монгол улсад хийгдсэн харуулдан тандалтын судалгаагаар жирэмсэн эмэгтэйчүүдийн дундах тэмбүү өвчин 2002 онд 2,5% байсан бол 2004 онд 3,1%, 2009 онд 1,7% болж буурсан байна. Эрүүл мэндийн албан ёсны статистик мэдээ, мэдээллээр төрөлхийн тэмбүү өвчний тохиолдол 2005 онд 36, 2006 онд 51, 2007 онд 7, 2008 онд 17, 2009 онд 19 тохиолдол тус тус бүртгэгджээ.

**Зорилго:** Бид судалгаандаа 2005-2009 онд улсын хэмжээнд бүртгэгдсэн төрөлхийн тэмбүү өвчний тохиолдлуудын онош тохирч байгаа эсэх, бүртгэж мэдээлсэн байдал, тандалтын тогтолцоонд тохиолдож байгаа бэрхшээлийг тодруулах зорилго тавьсан.

**Материал, аргазүй:** 2005-2009 онд төрөлхийн тэмбүү оноштой бүртгэгдсэн нярайн болон эхийн төрөлтийн түүхийг 11 аймгийн нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын 3 амаржих газар, ЭНЭШТ-өөс цуглуулан бичиглэл судалгааг хийв.

Төрөлхийн тэмбүү өвчний тохиолдлыг “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээний удирдамж”-д заасан тодорхойлолт (нярайд илэрсэн эмнэлзүйн шинж тэмдэг, нэг лабораторид ижил аргаар шинжилсэн эхийн ба нярайн ийлдэс судлалын шинжилгээний титрийн харьцуулалт, биеийн шингэнээс авсан шинжлэгдэхүүнд дархан туяаралт бичил харуурын аргаар буюу бараан талбайд цайвар трепонемийг илрүүлсэн шинжилгээний дүн зэрэг)-ыг үндэслэн

оношилж, БЗДХ-ыг мэдээлэх хуудсаар аймгийн эрүүл мэндийн газарт мэдээлдэг зарчмыг баримталсан.

**Үр дүн:** 2005-2009 онд 11 аймаг, Улаанбаатар хотод төрөлхийн тэмбүүгийн нийт 130 тохиолдол мэдээлэгдсэн байна. 2005 онд улсын хэмжээнд төрөлхийн тэмбүүгийн өвчлөл 1000 амьд төрөлтөд 0.8 тохиолдол байсан бол 2006 онд 1.1, 2007 онд 0.1 байсан бол 2008, 2009 онд 0.3 тохиолдол байсан байна. Өөрөөр хэлбэл 2005 онд 36 тохиолдол, 2006 онд 51 болж нэмэгдсэнээ 2007 онд 7 тохиолдол болсон ч статистикийн өөрчлөлтгүй байлаа.

Бүртгэгдсэн 130 тохиолдлын түүхийг аймгийн нэгдсэн эмнэлэг, Улаанбаатар хотын амаржих газраас цуглуулахад 116 (89%) нь түүхтэй, 14 нь огт байхгүй, 4 тохиолдол нь буруу мэдээлэл гэсэн тайлбартай байсан.

Мэдээлэл бүхий нийт тохиолдлын 115 нь амьд төрсөн, нэг амьгүй төрөлт байсан ба тэдгээрээс 36 тохиолдол (31%) нь төрөлхийн тэмбүүгийн эмнэлзүйн шинж тэмдэгтэй байсан нь удирдамжид заасан төрөлхийн тэмбүүтэй байх магадлал өндөртэй тодорхойлолтод тохирч байв. Төрөлхийн тэмбүүгийн эмнэлзүйн шинж тэмдэг бүхий 5 нярайн RPR шинжилгээний дүн эхийн шинжилгээний титрээс 4 дахин их байсан боловч дархан туяаралт бичил харуурын аргаар буюу бараан талбайд *T.pallidum* илрүүлэх шинжилгээ хийгээгүй байв.

Нэг нярай (0.9%) төрөлхийн тэмбүүгийн улмаас нас барсан, 79 (74%) тохиолдол эмнэлзүйн шинж тэмдэггүй байсан. Эмнэлзүйн шинж тэмдэггүй 79 нярайн 5(6.3%)-ынх нь эх жирэмсний хяналтад огт хамрагдаагүй, 19 (25.7%) эх жирэмсэн үедээ тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээнд хамрагдаагүй, 8(10.8%) эх жирэмсний хяналтанд байсан

боловч тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн эсэх нь тодорхойгүй байв. Эх нь төрөхөөс өмнөх 30 хоногийн дотор, эсвэл төрсний дараа тэмбүүгийн халдвартай оношлогдсон учраас 23(48.9%) нярайд төрөлхийн тэмбүү онош тавьсан байна.

Жирэмсний хугацаанд хяналтад орж, төрөхөөс өмнө 30 хоногоос өмнөх хугацаанд оношлогдсон 24 эхийн 4 (16.7%) нь эмчилгээ огт хийлгээгүй, 5 (20.8%) нь эмчилгээ гүйцэд хийлгээгүй, 15 (62.5%) нь эмчилгээ хийлгэсэн эсэх нь тодорхойгүй байсан.

Мөн 37 тохиолдлын төрөлтийн болон нярайн түүх олдоогүй, эсвэл эхийн жирэмсний хяналтын хугацаанд хийсэн тэмбүү өвчин илрүүлэх шинжилгээний дүн, хийлгэсэн эмчилгээний талаар “Солилцох хуудас”-д тодорхой мэдээлэл байхгүй байлаа. Ихэнхи эхчүүд 20-29 настай, ажилгүй, гэрлэсэн байв. Мөн 69% (80/116) нь хөдөө орон нутгийн харъяалалтай, тэдгээрийн 55% (44/80) нь аймгийн төвд оршин суудаг байв.

#### Дүгнэлт

1. Судалгаанд хамрагдсан 116 тохиолдлоос 31%(36)-д нь “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээний удирдамж”-д заасан төрөлхийн

тэмбүүгийн эмнэлзүйн шинж тэмдэг илэрсэн, 5 нярайн RPR шинжилгээний дүн эхийн шинжилгээний титрээс 4 дахин их байв. Ихэнх тохиолдолд төрөлхийн тэмбүү өвчний оношийг батлагдсан удирдамжийн дагуу зөв тавихгүй, эхийн жирэмсэн үедээ тэмбүүтэй оношлогдож байсан тухай өгүүлэмж болон эхийн ийлдэс судлалын (RPR, TRHA) шинжилгээний хариу эерэг байсан зэрэгт тулгуурлан төрөлхийн тэмбүү гэсэн онош тавьсан байна.

2. Эмнэлзүйн шинж тэмдэггүй 79 нярайн 32(40.5%)-д эх нь жирэмсний хяналтад огт хамрагдаагүй буюу жирэмсэн үедээ тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгээгүй, эсвэл жирэмсний хяналтанд байсан боловч тэмбүүгийн халдвар илрүүлэх шинжилгээ хийлгэсэн эсэх нь тодорхойгүй байв.

3. Жирэмсний хугацаанд хяналтад орж, төрөхөөс өмнө 30 хоногоос өмнөх хугацаанд оношлогдсон 24 эхийн 9 (37.5%) нь эмчилгээ огт буюу гүйцэд хийлгээгүй, 15 (62.5%) нь эмчилгээ хийлгэсэн эсэх нь тодорхойгүй байв. Энэ нь жирэмсний хяналтын үйлчилгээ үзүүлж буй эмнэлэг жирэмсэн эмэгтэйд тэмбүү өвнийг эрт илрүүлж эмчлэх тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

## МОНГОЛ ДАХЬ ХДХВ/ДОХ-ЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Б.Оюунбалэг<sup>1</sup>, П.Үнэнчимэг<sup>1</sup>, В.Наранцэцэг<sup>2</sup>, К.А. Аитов<sup>4</sup>  
Ч.Байгалмаа<sup>1</sup>, Н.Хулан<sup>1</sup>, П.Нямдаваа<sup>3</sup>, Б. Хандсүрэн<sup>2</sup>

<sup>1</sup> Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup> Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль,

<sup>3</sup> Монголын анагаах ухааны академи,

<sup>4</sup> ОХУ-ын Эрхцүгийн Анагаах ухааны сургууль

**Зорилго:** Монгол улсад бүртгэгдсэн ХДХВ-ийн халдварын тархвар зүйн онцлогийг судлах

**Материал, арга зүй:** 1992 оноос 2012 оны 10-р сарын 20 хүртэлх хугацаанд Монгол Улсад албан ёсоор бүртгэгдсэн 115 тохиолдолд ретроспектив кохорт судалгааг хийлээ.

**Үр дүн:** 1992-2004 онд бүртгэгдсэн ХДХВ/ДОХ-ын 5 (4.3%) тохиолдолыг гаднаас зөөвөрлөгдөж ирсэн гэж үздэг. Харин 2005 оноос 2012 оны 10-р сарын 20-ныг хүртэл ХДХВ/ДОХ-ын 110 (95.7%) тохиолдол бүртгэгдсэн нь халдвар дотооддоо эрчимтэй тархах шатандаа шилжиж буйг харуулж байна.

Манай улсад ХДХВ-ийн халдвар 100% бэлгийн замаар тархсан, одоогоор цус, цусан бүтээгдэхүүн, эмнэлгээс шалтгаалсан халдвар байдлаар болон эхээс хүүхдэд дамжсан тохиолдол бүртгэгдээгүй.

ХДХВ/ДОХ-той бүртгэгдсэн хүмүүсийн 104 (90.4%) нь Улаанбаатар хотоос, 10 (8.7%) нь орон нутгаас оношлогдсон. Үүнээс гадна Монгол улсад түр оршин сууж байсан гадаадын 15 иргэнд ХДХВ-ийн халдвар илэрсэн.

ХДХВ/ДОХ-той хүмүүсийн 91 (79.1%) нь эрэгтэй, 23 (20%) нь эмэгтэй, тодорхойгүй 1 (0.9%) тохиолдол байгаа. Эрэгтэйчүүдийн 77 (84.6%) нь эрэгтэйтэй



бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн 10 (43%) нь биеэ үнэлэгч ба бэлгийн олон хавьтагчтай байв.

Оношлогдох үеийн насны байдлаар авч үзвэл 4.3% (5) нь 15-19, 16.6% (19) нь 20-24, 25.2% (29) нь 25-29, 20% (23) нь 30-34, 16.6% (19) нь 35-39, 13% (15) нь 40-44, 2.6% (3) нь 45-49, 1.7% (2) нь 50+ насныхан байна.

Боловсролын хувьд 38.3 % (44) нь дээд, 19.1% (22) нь мэргэжил техникийн, 30.4% (35) нь бүрэн дунд, 9.6% (11) нь бүрэн бус дунд, 1.7% (2) нь бага боловсролтой, 0.9% (1) нь боловсролгүй байв.

Халдвартай хүмүүсийн дотор тодорхой хаяггүй, орон гэргүй, ядуу, нэн ядуу амьдралтай, архи хэтрүүлэн хэрэглэдэг, ажилгүй, наймаа худалдаа хийх болон суралцахаар гадаад орнуудад

зорчдог, түр хугацаанд оршин суудаг, хоригдож байсан, сэтгэцийн эмгэгтэй зэрэг эмзэг бүлгийн хүмүүс байна.

Өнөөдрийн байдлаар нас барсан 16, ХДХВ-ийн халдварын шинж тэмдэггүй үедээ 35, ДОХ-ын үе шатандаа 63 хүн байна. Ретровирусийн эсрэг эмчилгээнд нийт 51 хүн хамрагдаад байна.

**Дүгнэлт:**

Эрсдэлт бүлгийн хүн амын дунд ХДХВ-ийн тархалт >5% болж Монгол улс ХДХВ-ийн халдварын бага тархалттай орон бус төвлөрсөн тархалттай оронд тооцогдох боллоо.

Эрчүүдтэй бэлгийн хавьталд ордог эрэгтэйчүүдийн дундах ХДХВ-ийн халдварын тархалт хамгийн өндөр байна. Нийт тохиолдолын 91.3% нь 20-44 насныхан байна.

ХДХВ-ийн халдварын 90.4% нь УБ хотод оношлогдож байна.

**ЭРЧҮҮДТЭЙ БЭЛГИЙН ХАВЬТАЛД ОРДОГ ЭРЧҮҮДИЙН БЭЛГИЙН ЗАН ҮЙЛИЙН ТАНДАЛТ СУДАЛГАА (2010, 2011 он)**

Сатоши Шионо<sup>1</sup>, Сэичи Ичикава<sup>1</sup>, Г.Эрдэнэтуяа<sup>2,5</sup>,  
Г.Нямтүрэв<sup>2</sup>, Шиничи Ока<sup>3</sup>, Ж.Даваалхам<sup>3</sup>, Д.Мягмардорж<sup>4</sup>,  
<sup>1</sup>Нагоягийн их сургууль,<sup>2</sup>“Хамтдаа төв” ТББ,  
<sup>3</sup>АСС, Япон, <sup>4</sup>“Залуус эрүүл мэнд” ТББ,  
<sup>5</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Монгол дахь эрчүүдтэй бэлгийн харьцаанд ордог эрчүүд (ЭБЭ)-ийн дунд бэлгийн эрсдэлтэй зан үйлийг тодорхойлох.

**Материал, арга зүй:** Судалгааг Улаанбаатар хотод байгаа ЭБЭ-ийн дунд явуулсан тодорхой үйл ажиллагааг ашиглан нэг агшны аргаар хийсэн. 2011-09-03-нд “Mr Beauty 2011” үйл ажиллагаанд ирсэн нийт 265 хүнээс судалгааг асуумжийн аргаар авсан. Оролцогчдын 232 нь монголчууд, 33 нь гадаадын иргэд байсан ба үүнээс судалгааны зорилтот бүлэг болох ЭБЭ 130(56%) байсан.

**Үр дүн:** 2010 болон 2011 оны “Mr Beauty” үйл ажиллагааг түшиглэн явуулсан судалгааг харьцуулан дүгнэсэн.

2011 онд судалгаанд оролцогчдын 33,1% нь анх удаа ЭБЭ нарын дунд зохион байгуулж буй үйл ажиллагаанд ирсэн шинэ олон нийт байв.

ЭБЭ нарын дунд тохиолдлын бэлгийн хавьталд орсон хүний тоо 2010 онд 92%(109) байсан бол 2011 онд 95,8%(130) болж нэмэгдсэн, сүүлийн 12 сарын хугацаанд ХДХВ-ийн халдвар илрүүлэх

шинжилгээнд орсон хүний тоо 2010 онд 95%(95) байсан бол 2011 онд 87,8%(101) болж буурсан, сүүлийн 6 сард бэлгэвч тогтмол хэрэглэсэн байдал нь 2010 онд 48,9%(88) байсан бол 2011 онд 51,4%(70) болж өссөн боловч шинэ олон нийтийн дунд 35,1%(37), сүүлийн 12 сарын хугацаанд “Хамтдаа төв”-д сайн дурын зөвлөгөө шинжилгээ (СДЗШ)-нд хамрагдсан ЭБЭ олон нийтийн тоо 2010 онд 64% байсан бол 2011 онд 72% болж нэмэгдсэн боловч шинэ олон нийтийн дунд 31% байна.

**Дүгнэлт:**

Mr Beauty 2011 үйл ажиллагаанд оролцогчдийн 33.1% нь шинэ олон нийт (ЭБЭ) байна.

Шинэ олон нийтийн дунд сүүлийн 6 сард бэлгэвч тогтмол хэрэглэсэн байдал 35,1%(37), сүүлийн 12 сарын хугацаанд СДЗШ-нд хамрагдсан тоо 31%-тай байгаа нь нуугдмал хүмүүс олон, тэдэнд хүрч ажиллах төсөл хөтөлбөрийг үргэлжлүүлэх хэрэгцээтэй болохыг харуулж байна.

Шулуун гэдсээр тохиолдлын бэлгийн хавьталд орсон хувь өндөр 95,8%, бэлгэвчийн тогтмол хэрэглээ төдийлөн нэмэгдээгүй (51,4%) байна.

## ХДХВ-ИЙН ХАЛДВАР ЭХЭЭС ХҮҮХДЭД ДАМЖИХААС СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН БАЙДАЛ

П.Үнэнчимэг<sup>1</sup>, Б.Оюунбэлэг<sup>1</sup>, В.Наранцэцэг<sup>2</sup>,  
К.А.Аитов<sup>3</sup>, Ч.Байгалмаа<sup>2</sup>, П.Нямдаваа<sup>4</sup>, В.Хандсүрэн<sup>2</sup>

<sup>1</sup> Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup> Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль,

<sup>3</sup> ОХУ-ын Эрхцүгийн Анагаах ухааны сургууль,

<sup>4</sup> Монголын ангаах ухааны академи

**Зорилго:** ХДХВ/ДОХ-той эмэгтэйчүүд болон тэнцвэртэй бус гэр бүлийн эмэгтэйчүүд, халдвартай эхээс төрсөн нярайд авсан ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх арга хэмжээг үнэлэх

**Материал, арга зүй:** ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны хяналтанд байгаа эмэгтэйчүүд болон тэнцвэртэй бус гэр бүлийн эмэгтэйчүүдэд ретроспектив судалгааг хийв.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан ХДХВ/ДОХ-той эмэгтэйчүүдийн 78.3% (18) нь 20-34 настай төрөх насны эмэгтэйчүүд байна. ХДХВ/ДОХ-той нийт 23 эмэгтэйгээс 69.6% (16) нь жирэмсэлж, тэдний 43.7% (7) нь үр хөндүүлж, 56.3% (9) төрсөн.

ХДХВ/ДОХ-той 8 эмэгтэйгээс 9 хүүхэд төрсний 8 (88.9%) нь ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх арга хэмжээнд хамрагдсан. Эх нь ХДХВ-ийн халдвартай болох нь оношлогдохоос өмнө төрсөн 1 (11.1%) хүүхэд ХДХВ-ийн халдваргүй болох нь батлагдсан. ХДХВ-ийн халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийн 37.5% (3) нь жирэмсний хяналтын явцад оношлогдсоноос 33.3% (1) нь жирэмсний эхний хагаст, 66.7% (2) нь жирэмсний сүүлийн хагаст оношлогджээ. ХӨСҮТ-ийн хяналтанд байсан ХДХВ-ийн халдвартай эмэгтэйчүүдийн 62.5% (5) нь жирэмсэлсэн.

Жирэмсэн эмэгтэйчүүдийн CD4 эсийн тоо төрөхийн өмнө  $546.6 \pm 113.7$  эс/мкл байсан бол төрсний дараа  $677.5 \pm 214$  эс/мкл болж өссөн.

Эмэгтэйчүүдэд жирэмсний 14-28 дахь долоо хоногоос ретровирусийн эсрэг эмчилгээг ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх зорилгоор зидовудин, ламивудинаар эхлүүлж төрний дараах 7 хоногийг дуустал хэрэглэсэн. ХДХВ-ийн халдвартай

эхээс төрсөн нярайд 24 цагийн дотор ретровирусийн эсрэг урьдчилан сэргийлэлтийг невирапины хөвмөлөөр 0.2 мг/кг-аар бодож 1 удаагийн тунгаар хийсэн.

БЗДХ/ХДХВ/ДОХ-ын тусламж үйлчилгээний удирдамжийн дагуу бүх төрөлтийг кесарь хагалгаагаар удирдаж, төрсөн нярайд дан сүү орлуулагчаар хооллох зарчмыг баримталсан.

ДОХ-той эхээс 1 (11.1%) хүүхэд гадаадад төрж тэндээ хянагдаж байгаа. ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх арга хэмжээ авагдсан 6 (85.7%) хүүхдэд ХДХВ-ийн нуклейн хүчил олшруулах шинжилгээгээр сөрөг гарч халдваргүй болох нь тогтоогдсон. 18 сарын хяналтын хугацаа нь дуусч хяналтаас хасагдсан 3 хүүхэд хяналтын хугацаа хараахан дуусаагүй байгаа 3 хүүхэд байна. 1 хүүхэд төрөөд удаагүй байгаа учир шинжилгээнд хамрагдаагүй байна.

Тэнцвэрт бус гэр бүлийн 1 эмэгтэйд ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх арга хэмжээг авч хүүхдийг кесарь хагалгаагаар төрүүлэн дан сүү орлуулагчаар хооллосоноор хүүхэд ХДХВ-ийн халдваргүй болох нь батлагдаж хяналтаас хасагдсан.

### Дүгнэлт:

ХДХВ-ийн халдвартай жирэмсэн эмэгтэйчүүдийг хяналтанд эрт авч ХДХВ-ийн халдвар эхээс хүүхдэд дамжихаас сэргийлэх арга хэмжээг цаг хугацаанд нь зөв хэрэгжүүлэх нь ХДХВ-ийн халдваргүй хүүхэд төрүүлэх боломжтой болохыг харуулж байна

ХДХВ-ийн халдвартай эхийн төрөлтийг зөв удирдах, нярайд дан сүү орлуулагчаар хооллох нь ХДХВ-ийн халдвар дамжих эрсдэлийг бууруулахад үр дүнтэй байгаа тул энэхүү үйл ажиллагааг цаашид өргөжүүлэхэд төр засгийн дэмжлэг шаардлагатай байна.

## МОНГОЛ ОРОНД БҮРТГЭГДСЭН ХАЧИГТ РИККЕТСИОЗЫН ТАРХВАР СУДЛАЛЫН ТӨРХ БАЙДАЛ (2006-2011)

Б. Уянга<sup>1</sup>, Б. Батзаяа<sup>2</sup>, Р. Оюунгэрэл<sup>3,4</sup>, Б. Байгальмаа<sup>1</sup>, А. Долгорханд<sup>1</sup>  
Б. Ундраа<sup>1</sup>, Д. Отгонбаатар<sup>1</sup>, К.А. Аитов<sup>2</sup>

<sup>1</sup>Зоонозын өвчин судлалын үндэсний төв ,

<sup>2</sup>ОХУ-ын , Эрхүүгийн Анагаах Ухааны Сургууль,

<sup>3</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>4</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

**Зорилго:** Монголд бүртгэгдэж буй хачигт риккетсиозын хүний өвчлөлийн тархвар судлалын төрх байдлыг судлах

**Материал, арга зүй:** 2006-2011 онд БГХӨСҮТ (одоогийн Зоонозын өвчин судлалын үндэсний төв - ЗӨСҮТ)-д бүртгэгдсэн хачигт риккетсиозын тохиолдолуудын тархвар судлалын хуудас, өвчний түүхэнд бичиглэл судалгаа хийв.

**Үр дүн:** 2006, 2008-2011 онд хачигт риккетсиозын нийт 239 тохиолдол бүртгэгдэж, 2 тохиолдол нас барж, нас баралтын хувь 0.8% байна. Хачигт риккетсиозын тохиолдол 2006 онд 17 бүртгэгдэж шинэ өвчлөл 100.000 хүн амд 0.7, 2008 онд 25 ба 1.0, 2009 онд 113 ба 4.2, 2010 онд 28 ба 1.0, 2011 онд 56 ба 2.1 бөгөөд 2007 онд өвчлөл бүртгэгдээгүй байна. Хачигт риккетсиозын хүний өвчлөлийн тохиолдол 15 аймаг, нийслэлийн 66 сум, 9 дүүрэгт бүртгэгдэснээс Улаанбаатар, Архангай, Говь-Алтай, Дорнод аймагт хамгийн өндөр байна

Насны хувьд 0-9 насны хүүхдүүд хамгийн их өвчилж AR=3.5 байхад 10-19 насанд AR=0.8, 20-29 насанд AR=1.3, 30-39 насанд AR=1.8, 40-49 насанд AR=2.2., 50-аас дээш насанд AR=1.6 ба хүйсийн хувьд нь эмэгтэйчүүд давамгайлж (эр:эм AR=1.2:2.4) байна. Дундаж нас 25, насны хязгаар 5 хоногоос 87 нас хүртэл байв. Нийгмийн байдлаар авч үзэхэд хачигт риккетсиозоор өвчлөгсөдийн 30.6%-ийг 0-5 насныхан, 21.4%-ийг малчин, 18%-ийг оюутан, сурагч, 9.7%-ийг хувиараа хөдөлмөр эрхлэгч, 9.2%-ийг

төрийн байгууллагын ажилтан, 5.3%-ийг тэтгэвэрийн, 5.8%-ийг ажилгүй хүмүүс тус тус эзэлж байна.

Улирлын хувьд хачигт риккетсиозын өвчлөл 3-8 сарын хооронд бүртгэгдэж, 4-5 сард хамгийн өндөр байна.

Хачигт риккетсиозоор өвчлөгсөдийн 64%-д халуурах, 55.6%-д толгой хүчтэй өвдөх, 46.9%-д булчирхай томрох, 41.8%-д хачиг хазсан газарт анхдагч үрэвслийн шинж илрэх, 37.7%-д бүх биеэр тууралт гарах зэрэг шинж тод ажиглагдаж ядрах сульдах (17.6%), нүдний салстын судас өргөсөх (14.2%), үе мөч өвдөх (7.5%), хоолны дуршил буурах (7.5%), булчин өвдөх (6.7%), бөөлжих (6.7%), дагз хөших (6.3%), ууц нуруу өвдөх (0.4%) зэрэг шинж харьцангуй цөөн хувьтай тэмдэглэгдсэн байна.

### Дүгнэлт:

1. Хачигт риккетсиозын шинэ өвчлөл 100000 хүн амд 0.7-4.2 байгаагаас Архангай, Говь-Алтай, Дорнод аймагт хамгийн өндөр байна. Хачигт риккетсиоз 2009 онд хамгийн өндөр байж цаашид өвчлөл нэмэгдэх хандлагатай байна.

2. Хачигт риккетсиозоор өвчлөгсөдөд ихэвчлэн халуурах, толгой өвдөх, булчирхай томрох, хачиг хазсан газарт анхдагч үрэвслийн шинж илрэх, бүх биеэр тууралт гарах зэрэг шинжүүд илэрч байна.

3. Хачигт риккетсиозоор насны хувьд 0-9, 40-49 насныхан, ажил мэргэжилийн хувьд малчид, хүйсийн хувьд эмэгтэйчүүд илүү өвчлөх эрсдэлтэй байна.

## ХӨСҮТ-ИЙН ЭМЧ АЖИЛТНУУДЫН ДУНД ЗҮҮ ХУРЦ ҮЗҮҮРТЭЙ ЭМНЭЛГИЙН БАГАЖ ХЭРЭГСЭЛД ХАТГАГДАХ ӨРТӨЛТИЙГ СУДАЛСАН ДҮН

Н.Норовжаргал<sup>1</sup>, Г.Тунгалаг<sup>1</sup>, Г.Нарантуяа<sup>1</sup>,  
Л. Нямсүрэн<sup>2</sup> Р. Оюунгэрэл<sup>1,3</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup>Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв

<sup>3</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

**Зорилго:** ХӨСҮТ-ийн эмч ажилтнуудын дундах цусаар дамжих халдварыг зүү хурц үзүүртэй эмнэлгийн багаж хэрэгсэл (ЗХҮЭБХ)- д хатгагдах өртөлтийн байдалтай холбон судалж үнэлгээ, дүгнэлт өгөх.

**Материал, арга зүй:** Агшингийн судалгааны загвараар тоон болон чанарын судалгааг ретроспектив хийж гүйцэтгэлээ. Судалгаанд ХӨСҮТ-ийн халдвартын, сүрьеэгийн клиникийн нийт 185 эмч эмнэлгийн мэргэжилтэнг хамруулав. Тусгайлан боловсруулсан асуумжийг ашиглаж үр дүнг статистик боловсруулалтыг EXCEL, OpenEPI программыг ашиглан тооцлоо.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан 185 эмч, эмнэлгийн мэргэжилтэний дундаж нас 42.5, 93.5 % нь эмэгтэй байсан. Дунджаар 19.5 жил ажилласан байв. Эмч эмнэлэгийн мэргэжилтэнүүд нь өдөрт дунджаар 24 хүнд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлж, 7 хоногт дунджаар 44.5 цаг ажилладаг байна. Судалгаанд хамрагдсан мэргэжилтнүүдийн 68.1% нь ЗХҮЭБХ-д хатгуулсан, тэдний 51% (64) халдвартын клиникийн, 49% (62) сүрьеэгийн клиникийн ажилтнууд байсан. ЗХҮЭБХ-д өртөлтийг мэргэжлээр нь ялган тодруулахад их эмчийн 58%, сувилагчийн 77,8%, асрагчийн 55,8%, эмгэг анатомийн ажилтаны 50% тус тус өртсөн байна. 65.8% нь эмнэлгийн гаралтай хог хаягдлыг устгах явцад, 11.3% нь мээ ажилбарын үед, 3,2% нь мээ заслын багаж угааж ариутгах үед, 3,2% нь эмгэг анатомийн хутга зүүнд 2,4% нь дуслын тариурыг хураах явцад, 6,5% нь зүү эргэж таглах үед 7,3% нь ампул хагалах үед ЗХҮЭБХ-ийн хатгалтанд давхардсан тоогоор тус тус өртсөн байна.

Судалгаанд хамрагдагсадын 16% нь вирүст гепатит В-ээс сэргийлэх вакцин тариулсанаас 26% нь ажилд орохын өмнө, 74% нь ажилд орсны дараа бөгөөд 55% нь ХӨСҮТ-д анх ажилд орохдоо цусаар дамжих халдварын (В,С гепатит,

ХДХВ) шинжилгээнд хамрагдаагүй байна. Нийт судалгаанд хамрагдагсдын 30% нь вирүст гепатит В, С, Д – ээр өвдсөн ба 18% нь ажилд орохын өмнө, 82% нь ажилд орсны дараа гэж хариулжээ.

Нийт судалгаанд хамрагдагсадын дунд вирүст гепатит С 23.8% -д, вирүст гепатит В 5.4%-д, вирүст гепатит В,С хавсарсан халдвар 0.5%, вирүст гепатит В, Д хавсарсан халдвар 0.5%-д тус тус тодорхойлогдсон. ЗХҮЭБХ-ийн хатгалтанд өртсөн эмнэлгийн мэргэжилтэний 81% нь, өртөөгүй хэсгийн 19% нь вирүст гепатитаар өвчилсөн байна.

ЗХҮЭБХ-ийн хатгалтанд өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг судалгаанд оролцогсдын 72% нь авдаг. Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг яагаад авдаггүй вэ гэхэд өртөлтийг бүртгүүлээд ямар нэг арга хэмжээ авдаггүй учраас гэж 43% нь хариулсан байна. Өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээ авдаг гэсэн хүмүүсийн 45.9% нь усаар угааж спирт иодоор арчдаг гэсэн. Нийт судалгаанд оролцсон ажилтнуудын 55% нь өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээг мэддэг, 73% нь ЗХҮЭБХ-д өртөлтийн дараах сэргийлэлтийн арга хэмжээний талаар манай эмнэлэг ямар бодлого баримталдагийг мэддэггүй гэжээ. Судалгаанд хамрагдагсдын 65% нь цусаар дамжих халдвараас сэргийлэх, өртсний дараах урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх сургалтанд хамрагдаагүй байна. Судалгаанд хамрагдагсдын 15.6% нь вирүст гепатит В,С болон ХДХВ-ийн халдвар тээгч хүнээс багажаар халдвар дамжих боломжгүй гэж хариулсан байна. Тэдний 10.3% нь их эмч, 48.3% нь сувилагч, 38% нь асрагч, 3.4% нь ариутгагч нар байв.

### Дүгнэлт:

1. ХӨСҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэний дунд ЗХҮЭБХ-д хатгуулах нь өндөр (68.1%) бөгөөд сувилагч нар илүүтэй (77.8%) өртөж



байна.

2. ХӨСҮТ-дажилдшинээр орогсодын маш бага хувь (16%) вирүст хепатит В-ээс сэргийлэх дархлаажуулалтанд хамрагдаж, ажилд орохоос өмнө цусаар дамжих халдвар (вирүст хепатит В,С болон ХДХВ)-ын шинжилгээнд хамрагдах нь (55%) хангалтгүй байна.

3. ХӨСҮТ-ийн судалгаанд

хамрагдсан ажилтнуудын дунд вирүст хепатит В, С, Д-ийн халдвар өндөр (30%) бөгөөд тэдний дийлэнх нь ажил үүргээ гүйцэтгэх явцад халдварт өртсөн (82% нь ажилд орсон дараа гэсэн өгүүлэмжтэй) байх магадлал өндөр байна

4. ХӨСҮТ-ийн эмч, эмнэлгийн мэргэжилтэний дундах ЗХҮЭБХ-ийн хатгалтанд өртөлтийн талаарх мэдлэг, хандлага, дадал дунд зэрэг байна.

## УЛААНУУД ӨВЧНИЙ ЭМНЭЛЗҮЙ, ОНОШЛОГОО, ЭМЧИЛГЭЭ

С.Ундармаа, П.Дэлгэрмаа, Б.Бурмаа, Г.Ариунжаргал, Р. Туул  
Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** ХӨСҮТ-ийн Агаар дуслын халдварын 1-р тасагт 2012 оны эхний 9 сард улаанууд өвчнөөр хэвтэн эмчлүүлэгсдийн эмнэлзүйн онцлогийг судлан оношийг вирус судлал, дархлал судлалын шинжилгээгээр баталгаажуулсан дүнтэй харьцуулах

**Материал, арга зүй:** Судалгаанд 2012 оны эхний 9 сард ХӨСҮТ-д “Улаанууд” оношоор хэвтэн эмчлүүлсэн 0–34 насны 91 хүний өвчний түүхэнд эргэмж судалгаа хийж, дүнг ердийн статистикийн аргаар тооцоолов.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан нийт өвчтөний 6,6% нь 0–1 насны, 3,3% нь 1–4 насны, 42,8% нь 5–9 насны, 28,6% нь 10–14 насны, 12,1% нь 15–19 насны, 5,5% нь 20–24 насны, 1,1% нь 30–34 насны хүмүүс тус тус эзэлж байв. Нийт өвчтөний 95,6% нь халуурсан, 84,6% нь шигүү тууралттай, 48,4% нь амьсгалын дээд замын улайлттай, 30,8% нь нүдний салст улайсан, 1,1% нь нусгайрах шинж тэмдэг илэрсэн, бүх өвчтөний хүзүүний арын булчирхай томорсон байсан бол 4,4% нь халуураагүй, 15,4% нь таруу тууралттай, 51,6% нь амьсгалын дээд замын улайлтгүй, 69,2% нь нүдний салст улайгаагүй байв. Улаанууд өвчнийг эмнэлзүйн явцаар нь ангилж үзвэл, нийт өвчлөгсдийн 1,2% нь хүнд, 56% нь

хүндэвтэр, 42,8% нь дунд зэргийн явцтай байлаа.

Эмнэлзүйн оношийг баталгаажуулах зорилгоор улаануудын вирүсийн эсрэг IgM тодорхойлох шинжилгээг Герман улсад үйлдвэрлэсэн Siemens пүүсийн оношлуураар үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийхэд 91,2%-д нь эерэг тодорхойлогдов. Мөн клиник лабораторийн шинжилгээний дүнгээс үзвэл нийт өвчтөний 9,8%-д нь цагаан эсийн тоо багассан, 8,7%-д нь цагаан эсийн тоо ихэссэн, 71,4%-д нь цагаан эсийн тоо хэвийн байсан бол улаан эсийн тунах хурд 20,8%-д нь ихсэж 79,2%-д нь хэвийн байжээ. Хэвтэн эмчлүүлэгчдээс 3 өвчтөнд гроприносин, 1 өвчтөнд циклоферон зэрэг дархлаа зүгшрүүлэх эм бэлдмэл хэрэглэсэн байна.

**Дүгнэлт:** Улаанууд өвчнөөр 5-14 насны хүүхдүүд голчлон (71,3%) өвчилж, өвчлөгсдийн дийлэнх хувь нь хүндэвтэр явцтай байна. Эмнэлзүйн оношийн үндэслэлд халууралт 95,6%, гүвдрүүт шигүү улаан тууралт 84,6%, шигүү биш 15,4%, нийт өвчтөний дагзны, хүзүүний арын булчирхай томорсон, 48,4%-д амьсгалын дээд замын үрэвслийн шинж тус тус илрэв. Фермент Холбоот Урвалын аргаар улаануудын вирүсийн эсрэг өвөрмөц IgM 92,2%-д илэрч эмнэлзүйн онош лабораториор баталгаажсан болно.

## ГАХАЙН ХАВДАР ӨВЧНИЙ ЭМНЭЛЗҮЙН ОНЦЛОГ

С.Ундармаа, П.Дэлгэрмаа, Р.Туул

Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** 2009 ба 2012 оны гахайн хавдарын эмнэлзүйн онцлогийг харьцуулах

**Материал, арга зүй:** ХӨСҮТ-ийн Улаанбурханы Үндэсний лабораторит хийгдсэн гахай хавдрын вирусийн эсрэг IgM илрүүлэх шинжилгээгээр 2009 онд эерэг тодорхойлогдсон 60 өвчтөний өвчний түүхийг эргэмж судалгаагаар судлан 2012 оны дэгдэлтийн үед тус төвийн 1-р тасагт хэвтэж эмчлүүлсэн 60 өвчтөний эмнэлзүйн шинж тэмдэгтэй харьцуулан судлаж статистик аргаар боловсруулалт хийлээ.

**Үр дүн:** 2009 онд гахай хавдараар өвдсөн өвчтөнүүдээс ялгасан гахай хавдрын вирус нь НЗ генотипийн омог байсан. Эдгээр өвчтөний 55% нь хүндэвтэр, 45% нь дунд зэргийн явцтай өвчилж байсан бол 2012 онд өвчлөгчдийн 95,2% нь хүндэвтэр, 4,1% нь дунд зэргийн явцтай өвчилжээ. Гахай хавдар өвчнийг хүндрэлээр нь авч үзвэл, 2009 оны өвчтөнүүдийн 45% нь панкреатитаар, 15% нь менингитээр, 20% нь орхитоор, 10% нь хавсарсан хэлбэрээр хүндэрч байсан. 2012 онд гахай хавдарын дэгдэлтийг

үүсгэгч нь гахай хавдрын вирусийн F генотип болох нь батлагдсан юм. 2012 оны дэгдэлтийн үеэр өвчлөгсдийн 66,5% нь панкреатитаар, 23,9% нь орхитоор, 6,2% нь менингитээр тус тус хүндэрснээс гадна олон булчирхайлаг эрхтэнг хамарсан хавсарсан хэлбэрийн эмгэг оношлогдсон байна. Тухайлбал, субмаксалит (71,5%), мастит (0,3%), өндгөвчийн үрэвсэл, түрүү булчирхайн үрэвсэл (0,3%) зэрэг оношлогджээ. Жирэмсэн эхчүүд гахай хавдраар өвчлөх үед умайн чангарал үүсэх, улмаар үр зулбах тохиолдол бүртгэгдэж байв.

**Дүгнэлт:** 2009 онд гахай хавдраар өвчлөгсдийн өвчний эмнэлзүйн явцыг 2012 онд уг халдвараар өвчилсөн хүмүүсийнхтэй харьцуулахад 2012 оны өвчтөнүүдэд хүндрэх хандлага их байгаа нь ажиглагдав. Хүндрэл нь панкреатит давамгайлсан олон булчирхайлаг эрхтэнг хамарсан хавсарсан хэлбэрийн эмгэг (субмаксалит, менингит, орхит, мастит, өндгөвчийн үрэвсэл, түрүү булчирхайн үрэвсэл)-үүд байв. Жирэмсэн эхчүүд гахай хавдраар өвчилбөл үр зулбах эрсдэлтэй байна.

## ЖИРЭМСЭН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТОХИОЛДСОН ГАХАЙН ХАВДАР ӨВЧНИЙ ЭМНЭЛЗҮЙ

С.Ундармаа, Б.Бурмаа, Г.Ариунжаргал, Б.Болорцэцэг

Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Жирэмсэн эмэгтэйчүүдэд тохиолдох гахай хавдар өвчний эмнэлзүйг судлах

**Материал, арга зүй:** Сүүлийн 5 жилд гахай хавдар өвчнөөр өвдөж ХӨСҮТ-д эмчлүүлсэн 26 жирэмсэн эмэгтэйн өвчний түүхэнд эргэмж судалгаа хийв.

**Үр дүн:** Өвчлөгсөдийн 61,5% нь 18-24 насныхан, жирэмсний хугацаагаар үзэхэд 11 нь жирэмсэний 5-15 долоо хоногтой, тус бүр 5 нь 16-24, 25-32, 33-39 долоо хоногтой байв. Жирэмсэн эмэгтэйчүүдийн 61,5%-д умайн булчингийн чангарал илэрч, 11,5%-д үр зулбалт ажиглагдсан.

Жирэмсэн эмэгтэйчүүдэд халуурах шинж 80,7% (21), хоолонд дургүйлхэх 73% (19), бөөлжих 38,5% (10), чихээр өвдөх 100% (26), толгой өвдөх 46% (12) тус тус ажиглагдсан. Бүх тохиолдолд Мурсу, Филатовын шинж илэрч байсан. Нас баралт тохиолдоогүй.

**Дүгнэлт:** Гахай хавдараар өвдсөн жирэмсэн эмэгтэйчүүдийн дийлэнх нь 18-24 (61,5%) насныхан байв.

Гахай хавдараар өвдсөн жирэмсэн эмэгтэйчүүдэд умайн булчин чангарах шинж (61,5%) элбэг ажиглагдаж, зулбалт (11,5%) тохиолдож байна.

## ДОХ УЯЛДААТ КАПОШИЙН САРКОМ БОЛОН КАПОШИЙН САРКОМ, ЛИМФОСАРКОМТОЙ ХАВСАРСАН ТОХИОЛДОЛД ХИЙСЭН АЖИГЛАЛТ

В.Наранцэцэг<sup>1</sup>, Б.Оюунбэлэг<sup>2</sup>, П.Үнэнчимэг<sup>2</sup>, К.А Аитов<sup>4</sup>, Ч.Байгалмаа<sup>2</sup>,  
Л.Одгэрэл<sup>2</sup>, П.Нямдаваа<sup>3</sup>, В.Хандсүрэн<sup>2</sup>, Л.Мөнгөнцэцэг<sup>5</sup>

<sup>1</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль,

<sup>2</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>3</sup>Монголын анагаах ухааны академи,

<sup>4</sup>ОХУ-ын Эрхүүгийн Анагаах ухааны сургууль

<sup>5</sup>Хавдар судлалын үндэсний төв

**Зорилго:** ДОХ-той өвчтөнд Капошийн сарком болон Капошийн сарком, лимфосаркомийн хавсарсан тохиолдолд ажиглалт хийж, эмнэлзүйн явц, эмчилгээний үр дүнг үнэлэх

**Материал, арга зүй:** ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны хяналтанд орсон ДОХ-той өвчтөнүүдэд илэрсэн Капошийн сарком болон Капошийн сарком, лимфосаркомийн хавсарсан тохиолдолд эмнэлзүйн ажиглалт хийх

**Үр дүн:** ДОХ-той өвчтөнд 2004 онд оношлогдсон Капошийн сарком, 2010 онд оношлогдсон Капошийн сарком, лимфосаркомийн хавсарсан тохиолдолд эмнэлзүйн ажиглалт хийлээ.

2003 оны 1-р сараас хяналтанд байсан ДОХ-той эхний өвчтөнд 2004 оны 6 сарын 15-нд Капошийн саркомийг анх оношлож эмнэлзүйн ажиглалтыг хийсэн. Үзлэгээр зүүн хөхний баруун дээд хэсэг, зүүн хөхний товчны харалдаа баруун талд, баруун хөхний гадна хажуу, их биеийн зүүн доод хажууд орчны эдээс тод зааглагдсан, өвчин эмзэглэлгүй, бараан улаан өнгийн 0.2-2.1 см хэмжээтэй толбо, гүвдрүү, товруу, зангилаа гарсан байв. Тууралтууд богино хугацаанд хэмжээгээр томрон, шинээр нэмэгдэн, морфолог элементүүд шилжин өөрчлөгдөж байсан нь хавдрын явц их хурдацтай болохыг харуулсан.

2003 оны 11-р сарын 11-нээс ретровирусийн эсрэг эмчилгээг ламивудин, ставудинаар эхлүүлж, 2004 оны 6-р сарын 15-наас невирапин нэмж хэрэглэсэн боловч анхнаасаа өвчтөний дархлал хэт дарангуйлагдсан (CD4=1-4 эс/мкл), биеийн байдал хүнд байсаар 2005 оны 5-р сарын 3-нд Капошийн саркомийн хүндрэлээр эмчилгээнд засал авалгүй нас барсан.

2010 оны 9-р сарын 2-ны өдөр оношлогдон хяналтанд орсон ДОХ-той

хоёр дахь өвчтөнд Капошийн сарком, лимфосарком хавсран илэрсэн. Үзлэгээр баруун нүдний доод зовхи, хоёр шанаа, хүзүү, цээжний дээд хэсэг, баруун суга, нурууны дээд хэсэгт ганц нэгээр байрласан бараан улаан өнгийн 0.7-1.0 см хэмжээтэй, орчны эдээс тод зааглагдсан эмзэглэлгүй, хөдөлгөөнгүй, хатуувтар тогтоцтой гүвдрүүт, товруут тууралт гарсан байв. Амны хөндийд хатуу тагнай нилэнхүйдээ хавагнаж, зангилаат тууралт гарч идээрхэг өнгөр тогтсон, дээд доод буйлны арын хэсгийн дотор, гадна талд, урд дээд буйланд бараан улаан өнгөтэй 1.0-2.0 см хэмжээтэй, хөдөлгөөнгүй, эмзэглэлгүй зангилаат тууралттай, их биеэр тархмал нөсөөт толбон тууралттай байлаа. Мөн хүзүүний 2 талд, чихний ард тунгалгийн булчирхай томорч хоорондоо наалдсан, эмзэглэлгүй, хөдөлгөөнгүй байв. Цавины тунгалгийн булчирхай 2 талд ижил хэмтэй томорсон, хөдөлгөөнгүй, гадаргуу нь гөлгөр, эмзэглэлгүй байв. Бэлэг эрхтэнд шамрангийн арьсны дотор талд тагтааны өндөгний хэмжээтэй зөөлөвтөр, гөлгөр гадаргуутай, тэмтрэхэд эмзэглэлгүй зангилаат тууралттай байлаа.

2010 оны 10-р сарын 4-нөөс хими эмчилгээ мэс заслын эмчилгээтэй хавсран хийгдсэн. Ретровирусийн эсрэг эмчилгээг тенофовир, ламивудин, эфавиренцээр өвчтөний CD4=282 эс/мкл, вирусийн ачаалал 210000 хуулбар/мл байхад 2010 оны 10-р сарын 22-нд эхэлсэн. Эмчилгээний үр дүнд Капошийн сарком болон лимфосаркомийн тууралтууд шимэгдэн арилж, 2012 оны 8-р сарын 31-д өвчтөний CD4=535 эс/мкл болж өссөн.

### Дүгнэлт:

Эхний тохиолдолд өвчтөн хожуу үедээ оношлогдсон, CD4 эсийн тоо нь хэт бага байсан тул РВЭЭ Капошийн саркомийн явцад нөлөөлөөгүй. Энэ нь CD4 эсийн

тоо бага байх тусам оносон зөв эмчилгээ хийсэн ч эмчилгээний үр муу байдаг талаар АНУ-д хийгдсэн судалгааны дүнтэй (Von Roenn 2003) тохирч байна.

Нас залуу, CD4 эсийн тоо хэт цөөрөөгүй, өөр дагалдах халдваргүй тохиолдолд эмчилгээ үр дүнтэй болох нь хоёр дахь тохиолдолд харагдлаа

РВЭЭ эмчилгээг хими, мэс засал

болон шаардлагатай бусад эмчилгээтэй хавсрах нь үр дүнтэй байна

Монгол Улсад ДОХ уялдаат Капошийн сарком болон бусад хавдрыг эрт илрүүлэх, үе шатыг тодорхойлон, үр дүнтэй эмчлэхэд хавдар судлалын эмч нартай хамтран ажиллах, өвөрмөц шинжилгээний аргуудыг (СТ, punch biopsy, occult blood testing, дурангийн г.м) хэрэглэх нь зүйтэй.

## ХДХВ-ИЙН ХАЛДВАР ТЭЭГЧДИЙН ДУНДАХ АМНЫ САЛСТЫН ЭМГЭГИЙГ СУДАЛСАН ДҮН

М. Батсуурь<sup>1</sup>, Ж. Үржинлхам<sup>1</sup>, Ж. Даваалхам<sup>2</sup>

<sup>1</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны сургууль

<sup>2</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Үндэслэл:** ХДХВ/ДОХ-ын үед CD4 эс 1mm<sup>3</sup>-д 200-гаас доош болсон үед үйлчлүүлэгчийн амны салстад өөрчлөлт гардаг болохыг судлаачид тэмдэглэсэн байдаг. 2005 онд Венесуэлд хийсэн судалгаанаас харахад ХДХВ/ДОХ-ын халдвар тээгч 75 хүний 85%-д амны салстын эмгэг илэрсний 61%-д мөөгөнцөрийн үрэвсэл, 53%-д үсэрхэг хавтгай цагаан үлд, 34%-д нь хавтгай цагаан үлд, 38%-д хэт нөсөөжилт, 13%-д папиллома, 8%-д буйлны улайлтат үрэвсэл, 5%-д амны салстын дахилтат афт үрэвсэл, 5%-д саркома Капоши тохиолдсон байна (Bravo IM 2005).

Манай оронд ХДХВ-ын тархвар судлалын судалгаа шинжилгээнүүд хийгдсэн боловч ХДХВ/ДОХ-ын эмнэл зүйн тухайлбал халдвар тээгчдийн амны салстад гарсан эмгэгийг судалсан судалгаа хараахан хийгдээгүй байна.

**Зорилго:** ХДХВ/ДОХ-ын үеийн амны салстын эмгэгийн тохиолдлыг дархлааны үзүүлэлттэй харьцуулан судлах.

**Материал, аргазүй:** **ХӨСҮТ-ийн** ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны хяналтанд байгаа үйлчлүүлэгчдээс нийт 30 хүнийг сонгон авч энэхүү судалгааг хийлээ. ХДХВ/ДОХ-ын халдвар тээгчээр бүртгэгдэн хяналтанд буй үйлчлүүлэгчдээс тусгайлан боловсруулсан 13 бүлэгтэй асуумж судалгааг авч, карт хөтлөн мэдээлэл

цуглуулсан. Мөн үзлэгийн өрөөнд үзлэгийн сандал дээр үйлчлүүлэгчээ суулган байгалийн гэрэлд 1 удаагийн үзлэгийн багаж, шпателийн тусламжтай үзлэгээ хийн зургийн аппаратаар зөвхөн амны салстад гарсан эмгэгийн зургийг авч баталгаажуулсан.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан ХДХВ/ДОХ-ын халдвартай нийт 30 хүний 83,3%

( 25/30) нь амны салстын ямар нэгэн эмгэгтэй үүнээс хамгийн түгээмэл тохиолдож буй амны салстын эмгэг нь амны салстын мөөгөнцөрт үрэвсэл 43,3% (13/30), амны салстын хавтгай цагаан үлд 10% (3/30), буйлны ирмэгийн улайлтат үрэвсэл 16,6% (5/30), амны салстын дахилтат афт үрэвсэл 13,3% (4/30), саркома капоши 3,3% (1/30) тохиолдсон. ХДХВ/ДОХ-ын халдвар тээгчдийн CD4-н хэмжээ хэвийн болон 1 mm<sup>3</sup>-д 200-гаас доош болсон үед үйлчлүүлэгчийн амны салстад эмгэг өөрчлөлт илэрхий гарч байна.

**Дүгнэлт:**

ХДХВ/ДОХ-ын халдвартай хүний амны салстад амны салстын мөөгөнцөрт үрэвсэл, амны салстын хавтгай цагаан үлд, буйлны ирмэгийн улайлтат үрэвсэл, амны салстын дахилтат афт үрэвсэл, саркома капоши тохиолдож байна. ХДХВ-ийн ачаалал болон CD4-ийн хэмжээ нь амны салстад гарах эмгэг өөрчлөлтийн тохиолдолтой шууд хамааралтай байлаа.



## ЁЛОМ ӨВЧНИЙ ЭМНЭЛЗҮЙ-ТАРХВАР СУДЛАЛЫН ЗАРИМ ШИНЖ ТӨРХ

Б.Батсүх, М.Оюунгэрэл, О.Сумъяа  
Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Ёлом өвчний эмнэлзүй, лабораторийн зарим шинж төрхийг судлах

**Материал, арга зүй:** Сүүлийн 5 жилд ХӨСҮТ-д ёлом өвчний улмаас эмчлэгдсэн 106 өвчтөний өвчний түүхэнд эргэмж судалгааг хийж, үр дүнг Excel программд боловсруулав.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдагсдын дундаж нас  $56.33 \pm 23.4$ . Хүйсийн хувьд эмэгтэйчүүд давамгайлан (71.6% эм, 28.4% эр) өвчилсөн байна.

Өвчний давтамжийн байдлаар 9.4% нь дахилтат, 2.8% нь 1 жилийн дотор сэдрэлт өгсөн, 87.7% нь анхдагч хэлбэрээр өвчилсөн байв.

**Ажил мэргэжлийн хувьд:** 34% нь тэтгэвэрт, 10.4% нь групптэй, 15% нь ажилгүй, 34% нь тодорхой ажил эрхэлдэг, 3.8% нь оюутан, сурагч байв. Эдгээр эмчлүүлэгсдийн 63.2% нь хавсарсан эмгэгтэй байсан ба 55.2% нь зүрх судасны ямар нэгэн эмгэгтэй байсан. Эмнэлзүйн шинж тэмдгүүдээс шарх орчим хөндүүрлэх (93.4%), халуурах(84.9%), хоолонд дургүй болох (32%), толгой өвдөх (50%) шинжүүд давамгайлан илэрсэн.

**Өвчний явцаараа:** 56.6% нь дунд, 5.6% нь хүнд 37.7% хөнгөн байсан бол эмнэлзүйн хэлбэрүүдээс улаймал 31%, улаймал цэврүүт 62.3%, цусархаг улаймал 1.8%, үхжилт хэлбэр 3.8% тус тус байлаа. Шархны байрлалаараа 64% нүүрэнд, 27.4% нь хөлөнд, 0.9% нь

баруун эгэмэнд, 8.5% нь гаранд тус тус байрласан байлаа.

Цусны ерөнхий шинжилгээнд цагаан эсийн тоо олшрох(31.1%), улаан эсийн тунах хурд(66.1%) нэмэгддэг нь ажиглагдсан.

Ёлом өвчний үүсгэгч илрүүлэх нян судлалын шинжилгээнд 5 (4.7%)-д 6 (5.6%) *S.aureus*, *S.epidermitis* тус тус илэрсэн. Ёлом оношоор хэвтэн эмчлүүлэгчид 100% антибиотик эмчилгээ хийгдсэн ба үүнээс цефазолин 48%, пенициллины бүлэг 40.5%, 8.5%д антибиотикийг хавсруулан хэрэглэсэн байна.

### Дүгнэлт:

Ёлом өвчнөөр өвчлөгсдийн дундаж нас  $56.33 \pm 23.4$ , хүйсийн хувьд эмэгтэйчүүд давамгайлан (71.6%) өвдсөн байв.

Өвчлөгсдийн 87,7% нь анхдагч хэлбэрээр өвдсөн хэдий ч 2,8-9,4% нь дахилтат, сэдрэлтэт хэлбэрээр өвдсөн байна.

Эмнэлзүйн хэлбэрүүдээс улаймал хэлбэр 31%, улаймал цэврүүт хэлбэр 62.3% , шархны байршлын хувьд нүүрний хэсэгт голлон байрласан байна. Эмнэлзүйн гол шинж тэмдэг нь халууралт, шарх орчим хөндүүрлэх шинж байна.

Цусны ерөнхий шинжилгээнд цагаан эсийн тоо олшрох, улаан эсийн тунах хурд ихэссэн байлаа.

Нян судлалын шинжилгээнд 4.7% (5)-д нь *S.pyogenes* илэрсэн нь уг өвчний оношлогоог сайжруулах шаардлагатай байгааг илтгэж байна.

## МОНГОЛ ДАХЬ ХҮНИЙ БРУЦЕЛЛЭЗЫН ЭМНЭЛЗҮЙН ЗАРИМ ОНЦЛОГ

С. Гамуу<sup>1</sup>, Я. Дагвадорж<sup>2</sup>, Ж.Батаа<sup>1</sup>, Б.Энхтуяа<sup>1</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

<sup>2</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

**Үндэслэл:** Хүний бруцеллез өвчний өндөр тархалттай дэлхийн 25 улсаас өвчлөлийн тохиолдолын тоогоор Монгол улс хоёрдугаарт орж байна. (Georgios Pappas at all 2006) Мал, амьтад, хүний бруцеллезын халдварын тархалт, халдвар авах эрсдэл өндөр байгаагийн (Ц.Балдандорж 1972, Т.Голмбосүрэн 1982, Ц.Сэлэнгэ 2011) зэрэгцээ бага насны хүүхдүүдийн дунд бруцеллезын өвчлөлийн тохиолдол буурахгүй, бруцеллезтой өвчтөний эмчилгээний үр дүн хангалтгүй байгаа нь тулгамдсан асуудал болсоор байна. (Agalar C et al, 1999)

**Зорилго:** Монгол дахь хүний бруцеллезын эмнэлзүйн зарим онцлогийг судлах, үүсгэгчийн өсгөвөрт антибиотик мэдрэг чанарыг тодорхойлох

**Материал, арга зүй:** Зорилтот бүлгийг сонгохдоо ХӨСҮТ-ийн Зооноз бруцеллезын тасагт 2006-2010 онуудад хүний бруцеллез өвчний оношлогоо, эмчилгээний стандарт MNS A.23-ын дагуу эмчлэгдсэн 168 өвчтний өвчний түүхээс дескриптив судалгааны аргаар (тархвар судлалын хуудас) түүвэрлэн авч, SPSS17.0 программ дээр боловсруулалт хийлээ. ХӨСҮТ-ийн Зоонозын халдварын болон бруцеллезын тасагт хандсан:

- хурц, ужиг бруцеллез өвчний эмнэлзүйн шинж тэмдэгтэй (халуурч байгаа),
- ийлдэс судлалын шинжилгээгээр онош батлагдсан,
- антибиотик эмчилгээ хийлгээгүй 19 өвчтөнд судалгааны зорилгыг танилцуулан зөвшөөрөл авч, судалгаанд хамруулж, нян судлал, нянгийн будагдалт, ПГУ-аар баталгаажуулан бруцеллезын үүсгэгчийг ялган авлаа. Нян судлал, будагдалт, ПГУ-аар эерэг үр дүнтэй эдгээр 9 өсгөвөрт 12 төрлийн антибиотикаар мэдрэг чанарыг дискийн аргаар тодорхойлж дүгнэсэн.

**Үр дүн:** ХӨСҮТ-д 2006-2010 онуудад хэвтэж эмчлэгдсэн 20 аймаг, 6 дүүргийн 168 өвчтөний өвчний түүхэнд хийсэн

судалгаанаас 25,6%-ийг 30-39 насны хүмүүс буюу ид хөдөлмөрийн насны хүмүүсийн өвчлөл эзэлж байгаа ба хүйсийн хувьд ялгаагүй (P-утга- 0.290), 14,6%-ийг 15-19 насны хүүхдүүд үүний дотроос 0-4 насны хүүхдийн өвчлөл 2,4%-ийг эзэлж байлаа. Мөн эмнэлзүйн хэлбэрүүдийг насны онцлогтой харьцуулан судлахад бруцеллез өвчний архаг хэлбэр(шинж тэмдэг илэрч эхэлснээс хойш 6 сараас дээш хугацаа өнгөрсөн) 30-39 нас (24.20%), 40-49 нас (26.60%) –д илэрсэн бол өвчний хурц хэлбэр (шинж тэмдэг илэрч эхэлсэнээс хойш 3 сар хүртэл хугацаа өнгөрсөн) 5-9 нас (17,6%) 15-19 насанд (17,6%) 20-29 насанд (47,1%)–д, ужиг хэлбэр (шинж тэмдэг илэрч эхэлсэнээс хойш 3-6 сарын хугацаа өнгөрсөн) нь 10-14 нас, 30-39 насанд (26,1) тус тус илэрч эмнэлзүйн хэлбэр наснаас хамааралтай болох нь батлагдаж байна. (P-утга-0.0001) Бруцеллез өвчний бүх хэлбэрүүдийн хувьд халуурах(63.1%), хөлрөх(58.3%), ядрах(56.5%), толгой өвдөх(44.0%), нойр муудах (31.5%), үеэр өвдөх (89.3%), үений хэлбэр алдагдах (32.9%) шинжүүд давамгайлан илэрч байна. 19 өвчтний сорьцоос H1, H2, H3, H4, H5, H6, H7, H8, H9 нэр бүхий нийт 9 өсгөвөр гарган авч, multiplex PCR (AMOSPCR) – аар шалгахад бүх өсгөвөр 731 х.н –ийн ДНХ-ийн хэсгийг олшруулж бүгд *B. melitensis* зүйл болох нь батлагдаж байна. Эдгээр өсгөвөрт 12 төрлийн антибиотикоор мэдрэг чанарыг тодорхойлоход доксациллин, ципрофлоксацин, окситетрациклин, сульфаметаоказол, ланакол зэрэг антибиотикт өндөр мэдрэг байгаа нь тодорхойлогдов.

### Дүгнэлт:

Монгол дахь бруцеллезийн өвчлөл идэр насны хөдөлмөрийн чадвартай хүмүүсийн дунд зонхилон тохиолдохын зэрэгцээ 0-4 бага насны хүүхдүүдийн дунд өвчлөл ихсэх хандлагатай, хүйсийн хувьд ялгаагүй байна. (P-утга- 0.290)

Бруцеллез өвчний эмнэлзүйн хэлбэрүүд насны хувьд ялгаатай оношлогдож байна. (P-утга 0.0001) Бруцеллез өвчний бүх хэлбэрүүдийн

хувьд халуурах (63.1%), хөлрөх (58.3%), ядрах (56.5%), толгой өвдөх (44.0%), нойр муудах (31.5%), үеэр өвдөх (89.3%), үений хэлбэр алдагдах (32.9%) шинжүүд давамгайлсан илэрч, оношийн хувьд ач холбогдолтой байна.

ДЭМБ-ын зөвлөмжийн дагуу бруцеллээс өвчний эмчилгээнд тетрациклины бүлэг,

цефалоспорины III бүлэг, аминогликозид, сульфонамид, кьюнолины бүлгийн антибиотикүүдийг хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ. Цаашид нийлэг аргаар гарган авсан, антибиотикийн III-IV эгнээний ланакол зэрэг эсийн дотор үрждэг нянд сонгомлоор үйлчлэх антибиотикийг эмчилгээний практикт хэрэглэж болох юм.

## БООМ ӨВЧНӨӨР ӨВЧЛӨГСДИЙН ЭМНЭЛЗҮЙ, ТАРХВАР СУДЛАЛЫН ЗАРИМ ШИНЖ ТӨРХ

Б.Батсүх, М.Оюунгэрэл, О.Сумъяа  
Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Боом өвчний эмнэлзүй болон халдвар судлалын зарим шинж төрхийг тогтоох

**Материал, арга зүй:** Сүүлийн 5 жилд ХӨСҮТ-д боом өвчний улмаас эмчилэгдсэн 25 өвчний өвчний түүхэнд эргэмж судалгааг хийж боловсруулалтыг Excel программ дээр хийлээ.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдагсдын дундаж нас  $44.8 \pm 18.9$ . Өвчин эхэлснээс хойш эмнэлэгт хандсан дундаж хоног  $5.8 \pm 4$ . Хүйсийн хувьд эрэгтэйчүүд давамгайлсан өвчилсөн (72% эр, 28% эм).

Ажил мэргэжлийн байдлаар нь авч үзэхэд 24% нь тэтгэвэрт, 16% нь малчин, 12% нь оюутан байсан.

Нийт өвчилсөн хүмүүсийн халдвар судлалын асуумжаар 56% нь малын мах, түүхий эдтэй харьцсан, газар шорооны ажил хийсэн гэсэн байхад 24% нь гэр бүлд нь тухайн өвчнөөр хэн нэгэн нь өвдсөн байлаа.

Өвчний явцыг нь авч үзэхэд 36% нь хүндэвтэр, 32% нь хүнд, 16% нь тус тус дунд, маш хүнд явцтай байсан.

Эмнэлзүйн хэлбэрүүдээс арьсны хэлбэр давамгайлсан илэрсэн, үжил хэлбэрээр 3 буюу 12% нь өвчилсөн, 1 тохиолдолд гэдэсний хэлбэрээр өвчилжээ.

Эмнэлзүйн шинж тэмдгүүдээс шархаар өвдөх (92%), халуурах (72%), хоолонд дургүй болох (60%), толгой өвдөх (40%) шинжүүд давамгайлсан илэрсэн. Гэдэсний хэлбэрийн үед хэвлийгээр өвдөх шинж илэрсэн.

Шархны байдлыг авч үзвэл улайлт 100%, шархны эргэн тойронд хавантай 84%, хар тав тогтсон 84%, цэврүү үүссэн 68%, 16%д нь шарх нь идээлсэн, шарх нь

үхжил үүсгэсэн байдалтай байсан.

Цусны ерөнхий болон биохимийн шинжилгээнээс үзэхэд цагаан эсийн тоо олшрох (44%), улаан эсийн тунах хурд (40%) нэмэгддэг нь ажиглагдсан.

Боомын үүсгэгчийг өсгөврийн (32%), болон генетикийн (76%) шинжилгээгээр баталсан.

Боом өвчний үед антибиотик 100%, судсаар хордлого тайлах эмчилгээ 80%, гормон эмчилгээ 40%, ийлдэс эмчилгээ 36%д хийсэн бол 2 өвчтөн арьс нөхүүлэх мэс засалд орсон, 1 өвчтөн уг өвчний улмаас хөлөө тайруулсан, 2 өвчтөний шарханд зүсэлт хийсэн байна.

### Дүгнэлт:

1. Боом өвчнөөр өвчлөгсдийн дундаж нас  $44.8 \pm 18.9$ , хүйсний хувьд эрчүүд давамгайлсан өвчилсөн (72%) байна.
2. Халдвар судлалын хувьд голчлон мах махан бүтээгдэхүүн, малын түүхий эдтэй харьцсан (56%) тохиолдол давамгайлж байна.
3. Эмнэлзүйн хувьд арьсны хэлбэрээр давамгайлж байсан ба 68% д нь өвчний явц хүндэвтэр, хүнд явцтай байлаа. Эмнэлзүйн шинж тэмдгүүдээс шарх шархаар өвдөх (92%), халуурах (72%), хоолонд дургүй болох (60%), толгой өвдөх (40%) шинжүүд голлон илэрч байна. Шархны байдлыг авч үзэхэд 100% д улайлт, 84% д шархны эргэн тойронд хавантай, 84%д хар тав тогтсон, 68%д цэврүү үүссэн.
4. Цусны ерөнхий шинжилгээнд цагаан эсийн тоо олшрох, улаан эсийн тунах хурд ихэссэн байлаа.
5. Боом өвчний үүсгэгчийг өсгөврийн шинжилгээгээр (32%), генетикийн шинжилгээгээр (76%) оношлосон.

## ПЕГИНТЕРФЕРОН РИБАВИРИН ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Ц. Оюунчимэг, В.Энхжаргал, Н. Сарангуа, Ч. Батжаргал, Г.Гантуяа  
Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Пегинтерферон альфа 2 а, рибавирины хавсарсан эмчилгээний үр дүнг хянах.

**Материал, арга зүй:** Санамсаргүй түүвэрлэлтийн аргаар ХСВ-ийн архаг халдвартай болох нь лабораторийн шинжилгээгээр батлагдсан 22-40 насны 9 хүнд пегинтерферон альфа 2а-г 180 мкг (0,5 мл) –р 7 хоногт 1 удаа хүйс орчмын арьсан дор тарьж, рибавирин 200 мг шахмалаар биеийн жингээс хамааруулан 800-1200мг-р 22-48 долоо хоногийн турш хэрэглэсэн. Эмчилгээний явцад сар тутам захын цусанд улаан, цагаан, ялтаст эс, нейтрофиль эс, гемоглобиний хэмжээ, биохимид АлАТ, АсАТ, сахар, шүлтлэг фосфатазаг, 3 сар тутамд вирүсийн ачаалал тодорхойлж, бамбай булчирхайн үйл ажиллагаа Т3, Т4-г тус тус үзэж байв. Мөн эмчилгээний явцад илэрч буй зовиур, гаж нөлөөг хянасан.

**Үр дүн:** Эмчилгээнд 5 эрэгтэй, 4 эмэгтэй 9 хүн хамрагдсаны дөрөв нь 1998, 2004, 2005, 2007 онд, гурав нь 2006 онд, хоёр нь 2010 онд С вирүс илэрсэн. Пегинтерферон ба рибавирины хавсарсан эмчилгээг нэг тохиолдол нь 22 долоо хоног, дөрөв нь 24 долоо хоног, дөрөв нь 48 долоо хоногийн турш хийлгэсэн. Эмчилгээний эхэнд вирүсийн ачаалал дунджаар 878,458 IU/ML байснаа эмчилгээний 12-13 долоо хоногт вирүсийн ачаалал тодорхойлогдохгүй болсон (early viral responder). Эмчилгээний үр дүнд эмчилгээ дуусаннаас хойш 6 дахь сараас 6 хүнд вирүсийн тогтвортой хариу урвал илэрч вирүсийн ачаалал тодорхойлогдохгүй болсон (sustained viral responder). Харин 3 хүнд вирүсийн ачаалал дахин тодорхойлогдсон (relapse

responder). АлАТ-ын дундаж үзүүлэлт эмчилгээний эхэнд 162.7, АсАТ 85.4 байснаа эмчилгээний 4-6 долоо хоногоос буурсаар 22-48 долоо хоногт АлАТ-71.34, АсАТ- 45.23 болж тус тус буурсан байна. Цусны ерөнхий шинжилгээнд эмчилгээний 4-5 дахь долоо хоногоос цагаан эс болон ялтаст эсийн тоо цөөрч байсан ч эмчилгээ дуусаны хэвийн хэмжээнд орсон. Судалгаанд хамрагсдад эмчилгээний 4 дэх долоо хоногоос дараахь шинжүүд илэрч эхэлсэн. Үүнд: Ядрах шинж-100%, бие зарайх 88.80%, жин буурах 86.30%, нойронд муудах 77.80%, үе мөч өвдөх ба арьс хуурайших шинж 77.70%, бухимдах шинж 66.60%, ам хатах 44.40%, хоолны дуршил буурах 33.30%, арьс загатнах, хамраас цус гарах толгой өвдөх шинжүүд 22.20%, хамар битүүрэх 11.10%-д тохиолдож байсан.

### Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагсдад эмчилгээний 12-13 долоо хоногт вирүсийн ачаалал тодорхойлогдохгүй болж ирсэн. Эмчилгээний дараах 6 дахь сараас вирүсийн ачаалал 3 хүнд тодорхойлогдсон.
2. Биохимийн шинжилгээний үзүүлэлтүүд эмчилгээний 6 сарын дараа 7 хүнд нь тогтвортой хэвийн хэмжээнд орсон.
3. Эмчилгээний явцад ядрах, жин буурах, бие зарайх, нойронд муудах, арьс хуурайших болон сэтгэл санаатай холбоотой өөрчлөлтүүд зонхилон тохиолдсон бөгөөд бүх хамрагсдад ядарч сульдах зовиур илэрч байсан. Эмчилгээний дараа эдгээр бүх зовиурууд арилсан.



## СҮРЬЕЭГИЙН 2-Р БҮЛГИЙН ЭМЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН: БИЧИГЛЭЛ СУДАЛГАА

Ж.Эрдэнэбилэг, Б.Цолмон

Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Сүрьеэгийн хоёрдугаар бүлгийн эмчилгээний үр дүнг бусад бүлгийн эмчилгээтэй харьцуулан судалж, зөвлөмж боловсруулах

**Материал, арга зүй:** 2007-2011 онд бүртгэгдсэн мэдрэг болон олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн бүртгэлийн, эмчилгээний үр дүнгийн тайланд бичиглэл судалгааг хийв. Эмчилгээний үр дүн, амжилтыг хувиар илэрхийлж, тэдгээрийн дундажийг үл хамаарах хоёр түүврийн t-test ашиглан харьцуулсан.

**Үр дүн:** 2007-2011 онд эмчилгээнд хамрагдсан уушгины түрхэц эерэг шинээр илэрсэн сүрьеэгийн 84.1%(7957/9460), давтан эмчлүүлэгчдийн 54.7% (1055/1928), олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн 67.1% (206/307) нь эдгэрсэн байна ( $p < 0.001$ ). Харин эмчилгээний дундаж амжилт шинээр илэрсэн уушгины түрхэц эерэг сүрьеэтэй эмчлүүлэгчдийн дунд 87.8%,

давтан тохиолдлуудын дунд 71.9% болон олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн тохиолдлын дунд 74.9% байлаа ( $p < 0.01$ ). Хоёрдугаар бүлгийн эмчилгээнд хамрагдсан тохиолдлуудын 15.6%-д эмчилгээ үр дүнгүй болсон бол шинэ түрхэц эерэг ба олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн зөвхөн 7.2% нь эмчилгээ үр дүнгүй болсон ( $p < 0.001$ ) байна.

**Дүгнэлт:** Сүрьеэгийн 2-р бүлгийн эмчилгээний эдгэрэлтийн түвшин, эмчилгээний амжилт нь 1-р бүлгийн болон ОЭТС-ийн эмчилгээний эдгэрэлтийн түвшин, эмчилгээний амжилтаас харьцангуй бага байна. Мөн 2-р бүлгийн эмчилгээний үр дүнгүй болсон тохиолдлын тоо өндөр байгаа нь 2-р бүлгийн эмчилгээний одоо хэрэглэгдэж буй стратегийг цаашид судалж, зөв эмчилгээний стратеги боловсруулах шаардлага буйг харуулж байна.

## СҮРЬЕЭГИЙН ЭСРЭГ ЭМЧИЛГЭЭ ҮР ДҮНГҮЙ БОЛСОН БАЙДАЛ БА ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛС (2009-2010)

Б.Цолмон<sup>1</sup>, М.Энхтуяа<sup>2</sup>

<sup>1</sup>Монголын талбарын тархвар судлалын хөтөлбөр,

<sup>2</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Үндэслэл:** Монголд сүрьеэгийн эмчилгээ үр дүнгүй болох түвшин 2000 онд 3.3% байсан бол 2009 онд 7.1% болж нэмэгдсэн байна. Манай улсад сүрьеэгийн эмчилгээ үр дүнгүй болоход нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйл тодорхойгүй байна.

**Зорилго:** Сүрьеэгийн эмчилгээ үр дүнгүй болох, түүнд нөлөөлж буй эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлж, түүнээс сэргийлэх арга замыг боловсруулах

**Материал, аргазүй:** Бид 2009-2010 онуудад эмчилгээнд хамрагдсан сүрьеэгийн тохиолдлын эмчилгээний хуудсуудыг ашиглан бичиглэл болон тохиолдол хяналтын судалгаа хийсэн. Нэг болон олон хүчин зүйлийн дүн шинжилгээг эмчилгээ үр дүнгүй болсон байдал ба үйлчлүүлэгчийн шинж чанар хоорондын хамаарлыг судлахад ашигласан.

**Үр дүн:** Судалгаанд нийт 7422 тохиолдол хамрагдсаны 263 (3.5%)-д нь эмчилгээ үр дүнгүй болсон байлаа.

Тэдгээрийн 195 (74.1%) нь шинээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлууд байв. Эмчилгээ үр дүнгүй болсон 101 (38.4%) тохиолдолд олон эмэнд тэсвэртэй сүрьеэ илэрсэн. Эмчилгээ үр дүнгүй болсон тохиолдлыг эдгэрсэн тохиолдолтой харьцуулан олон хүчин зүйлийн шинжилгээд эмчилгээний хоёрдугаар бүлгээр эмчлэгдэж байгаа ( $OR = 5.2$ ; [95% C.I. 1.2-22.8]), цэрний түрхэцийн шинжилгээ нь эмчилгээний хоёр дахь ( $OR = 3.5$ ; [95% C.I. 2.5-5.0]) болон гурав дахь сард ( $OR = 8.6$ ; [95% C.I. 6.1-12.1]) эерэг байх нь сүрьеэгийн эсрэг эмчилгээ үр дүнгүй болох магадлалтайг батлах үзүүлэлт болж байна. Мөн Улаанбаатар хотын эмчлүүлэгчдийн дунд эмчилгээ үр дүнгүй болох нь харьцангуй ( $OR = 1.5$ ; [95% C.I. 1.1-2.1]) өндөр байгаа нь ажиглагдлаа.

**Дүгнэлт:**

1. Давтан эмчилгээнд хамрагдаж байгаа тохиолдлуудын дунд эмчилгээ үр

дүнгүй болох нь шинээр илэрсэн сүрьеэтэй харьцуулахад өндөр байна.  
2. Сүрьеэгийн эмчилгээ үр дүнгүй болсон тохиолдолын “сүрьеэгийн дахилт өгсөн”, “бусад” гэсэн тодорхойлолт

бүхий тохиолдол, мөн эмчилгээний хоёр дахь сарын цэрний түрхэцийн шинжилгээ эерэг байгаа эмчлүүлэгч бүрээс эмийн мэдрэг чанарын шинжилгээ авч байх нь зүйтэй.

## НҮДНИЙ САЛСТ БА ЭВЭРЛЭГ БҮРХҮҮЛИЙН ҮРЭВСЭЛТ ӨВЧНИЙ ҮЕД АДЕНОВИРУС ИЛРҮҮЛСЭН ДҮН

Н. Баясгалан<sup>1</sup>, Б.Мөнгөншүр<sup>2</sup>, Б. Дармаа<sup>1</sup>, М.Алтанхүү<sup>1</sup>, Э.Санжаа<sup>2</sup>, П.Нямдаваа<sup>1</sup>

<sup>1</sup>Халдварт Өвчин Судлалын Үндэсний Төв,

<sup>2</sup> “Орбита” эмнэлэг

**Зорилго:** Монгол улсад нүдний үрэвсэл үүсгэн эргэлтэнд байгаа аденовирусийн генетик хэвшинжийг тодорхойлж, эмнэл зүйн шинжийг харьцуулан дүгнэлт хийх

**Материал, арга зүй:** 2011 оны 5-р сараас 2012 оны 5-р сарын хооронд Орбита эмнэлэгт нүдний үрэвсэлт өвчний улмаас ирж үйлчлүүлсэн 56 хүнээс зовхины арчдас сорьц авч Аденовирус илрүүлэх полимерадын гинжин урвал(ПГУ)-ын шинжилгээ хийж, гексон генийн секвенсинг шинжилгээгээр удмын шинжийг тогтоов.

Эмнэл зүйн сорьцноос QIAamp DNA mini Kit (QIAGEN) цомог аденовирусийн ДНХ-ийг ялгаж, Katara PCR цомог, Праймер /Forward 5'-CACATCGCCGGACAGGATGCTTC GGAGTA-3', Reverse 5'-GTGTTGTGAG CCATGGGGAAGGTGGC-3' 1886bp/, Primus-96 plus термосайклер машин ашиглан ПГУ-ын шинжилгээ хийж, Applied Bio system BigDye TermionatorV3.1 cycle Sequencing цомог, ABI 3130x1 Genetic analyzer ашиглан гексон генийн нуклеотидын дараалал

тогтоох шинжилгээг тус тус хийв.

### Үр дүн, дүгнэлт:

Шинжилгээгээр 32(56% сорьцонд аденовирусийн ДНХ эерэг тодорхойлогдлоо. Аденовирусийн гексон генийн нуклеотидын дараалал тогтоох шинжилгээгээр 20(62,5%) нь HAdV D8, 5(16%) нь HAdV B6, 7(21,5%) нь HAdV B7 ийлдэст дэд хэв шинжид тус тус хамаарч байгаа нь тогтоогдлоо. Аденовирусийн халдвараар өвчилсөн хүмүүст конъюнктивит, кератоконъюнктивит, толгой өвдөх шинжүүд давамгайлан илэрсэн байна. Аденовирусийн халдвараар өвчлөгсөд нь 18-35 насны идэр залуучууд байж, шинж тэмдгийн эмчилгээ хийснээс хойш 13-28 хоногийн дараа халдварын шинж тэмдэг арилж байсан нь HAdV сөрөг өвчтөнүүдтэй харьцуулахад эдгэрэлт удаан байгаа нь ажиглагдлаа. Аденовирусийн халдвар нь монгол хүн амын дунд жилийн турш эргэлтэнд байдаг боловч 4,5,10 ба 11 дүгээр сард идэвхжил ихтэй байгаа хөдлөл зүй ажиглагдлаа. Нарийвчилсан судалгааг үргэлжлүүлэн хийх шаардлагатай.

## 2010-2012 ОНД БҮРТГЭГДСЭН УЛААНУУДЫН ХАЛДВАРЫН ВИРУС СУДЛАЛ, ДАРХЛАЛ СУДЛАЛЫН ОНОШЛОГОО

Р.Туул, У. Наранчимэг, Д. Отгонбаяр  
Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** 2010 оноос хойшхи хугацаанд бүртгэгдэж буй тууралтат халдварын дотор улаануудын вирусийн халдварыг вирус судлал, дархлал судлалын аргаар оношлон баталгаажуулж үүсгэгчийн генотипийг тогтоох

**Материал, арга зүй:** 2010-2012 онд эмнэлзүйгээр тууралтат халдвар оноштой ХӨСҮТ болон аймгуудад эмчлүүлсэн 1-40-өөс дээш насны 896

өвчтний цусны ийлдсэнд улаануудын вирусийн эсрэг IgM илрүүлэх шинжилгээ хийлээ. Шинжлэх цусыг хураагуур судаснаас авч ийлдсийг нь ердийн аргаар ялган шинжилгээ хийх хүртэлх хугацаанд -20°C хэмтэй гүн хөлдөөгчид хадгалж байв. Улаануудын вирусийн эсрэг өвөрмөц IgM эсрэгбиеийг илрүүлэх шинжилгээг Германы Siemens пүүсийн оношлуураар ашиглан ФХУ-ын аргаар

үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийж гүйцэтгэв. Мөн өвчтөнөөс вирүс ялгах шинжилгээг VeroSLAM эсийг ашиглан хийсэн ба генотипийг тогтоох молекул биологийн шинжилгээг Хонг Конгийн нийгмийн эрүүл мэндийн төв лаборатори болон ХӨСҮТ-ийн лабораторит хийсэн болно.

**Үр дүн:** Улаануудын вирүсийн эсрэг өвөрмөц IgM-ийг тодорхойлоход шинжилсэн бүх сорьцны 38,5%-д эерэг тодорхойлогдлоо. Насны бүлгээр авч үзвэл 0-11 сартай хүүхдүүдийн 9,1%-д, 1-4 насанд 9,4%, 5-9 насанд 54,0%, 10-14 насанд 49,1%, 15-19 насанд 31,9%,

20-24 насанд 19,4%, 25-29 насанд 13,0%, 30-34 насанд 8,3%, 34-39 насанд 14,3%, 40-өөс дээш насанд эерэг тодорхойлогдсон өвчтөн байсангүй. 2010-2012 онд шинжилсэн 6 өвчтөнөөс тууралт гарсны дараах 1-2 хоногт багтаан цуглуулсан ийлдсүүдэд улаануудын вирүсийн 1E генотип оношлогдов (сорьцын дугаар: 10-20, 10-40, 12-28, 12-38, 12-68, 12-104).

**Дүгнэлт:** 2010-2012 онд бүртгэгдэж буй тууралтат халдварын вирүс судлал, дархлал судлалын шинжилгээгээр 38,5% нь улаануудын халдвар болох нь батлагдав. Сүүлийн гурван жилд манай хүн амын дунд улаануудын вирүсийн 1E генотип идэвхтэй эргэлдэж байна.

## МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ДУНД 2008-2012 ОНД ОНОШЛОГДСОН ГАХАЙН ХАВДРЫН ВИРҮСИЙН ГЕНОТИПУУД

*Р. Туул, Д.Энхсайхан, У. Наранчимэг, Д. Отгонбаяр  
Халдварт өвчин судлалын үндэсний төв*

**Зорилго:** 2008-2012 онд бүртгэгдсэн гахай хавдар өвчний эмнэлзүйн оношийг лабораторийн аргаар баталгаажуулж, үүсгэгчийн генотипийг молекул биологийн аргаар тогтоох

**Материал, арга зүй:** 2008-2012 онуудад ХӨСҮТ-д хэвтэж эмчлүүлсэн 820 өвчтний ийлдсэнд гахай хавдрын вирусийн эсрэг өвөрмөц IgM илрүүлэх шинжилгээ хийлээ. Өвчтөнүүдээс цуглуулсан ийлдэс, хоолойн арчдас, VERO/SLAM эсэд халдварлуулан ялгаж хураасан, гахай хавдрын зэрлэг вирүсийн өсгөвөр зэргийг -20°C-ийн хэмээс -70°C-ийн хэмтэй гүн хөлдөөгчид хадгалж байв. Гахай хавдрын эсрэг өвөрмөц IgM эсрэгбиеийг илрүүлэх шинжилгээг Германы Novatech пүүсийн ФХУ-ын оношлуур ашиглан, үйлдвэрлэгчийн зааврын дагуу хийлээ. Өвчтөнөөс вирүс ялгах шинжилгээг VeroSLAM эсийг ашиглан хийсэн ба генотипийг тогтоох молекул биологийн шинжилгээг Японы Халдварт Өвчний Үндэсний Хүрээлэн болон ХӨСҮТ-ийн вирүс судлалын лабораторит хийсэн болно.

**Үр дүн:** Шинжилсэн бүх сорьцын 60,8%-д нь гахай хавдрын вирүсийн эсрэг өвөрмөц IgM тодорхойлогдлоо. Насны бүлгээр авч үзвэл, 0-11 сартай хүүхдүүдийн 33,3%-д, 1-4 насанд 58%,

5-9 насанд 66,1%, 10-14 насанд 64,7%, 15-19 насанд 67%, 20-24 насанд 64%, 25-29 насанд 60%, 30-34 насанд 36%, 34-39 насанд 39,1%, 40-өөс дээш насанд 20,6%-д IgM эерэг байв. Улаанбаатар хотод 2008-2009 онд бүртгэгдсэн гахай хавдрын үед цуглуулсан сорьцонд (өвчтөнөөс ялгасан гахай хавдрын вирүсийн өсгөвөр, хоолойн арчдас, ийлдэс) хийсэн генотипийн судалгаагаар гахай хавдрын НЗ шинэ төрлийн генотип тодорхойлогдож, улмаар 2012 онд ДЭМБ-ын лавлагаа омгийн жагсаалтанд шинээр бүртгэгдсэн юм. Түүнчлэн, 2011 оны гуравдугаар сард Өмнөговь аймгийн Гурван тэс суманд бүртгэгдсэн гахай хавдрын дэгдэлтийн үүсгэгч нь F генотип байсан бол 2011 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод бүртгэгдсэн өвчлөлийн үүсгэгч нь НЗ генотипийн вирүс байсан нь дахин батлагдав. Дараа нь 2012 онд бүртгэгдсэн гахай хавдрын дэгдэлтийн үүсгэгч нь F генотипийн вирүс байв.

**Дүгнэлт:** Гахай хавдар өвчний эмнэлзүйн оношийг баталгаажуулахад вирус судлал, дархлал судлалын шинжилгээ чухал ач холбогдолтой байна. Манай улсад 2008-2012 онд бүртгэгдсэн гахай хавдар өвчний үүсгэгч нь өөр өөр байгаа нь ГХВ-ийн НЗ болон F генотипийн вирүс оношлогдсоноор батлагдаж байна.

## 2009-2011 ОНД БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН НЯН СУДЛАЛЫН ЛАБОРАТОРИД ЯЛГАСАН НЯНГИЙН АНТИБИОТИКТ МЭДРЭГ ЧАНАРЫГ СУДАЛСАН ДҮН

Ш.Оюунцэцэг<sup>1</sup>, Д.Алтанцэцэг<sup>2</sup>

<sup>1</sup>Баян-Өлгий аймгийн нэгдсэн эмнэлгийн нян судлаач эмч,

<sup>2</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Антибиотикт тэсвэртэй нянгийн халдварыг илрүүлэн олон эмэнд тэсвэртэй нянгийн тэсвэржилтийн судалгаа гаргаж дүн шинжилгээ хийх

**Материал, арга зүй:** 2009-2011 онд Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн Нян судлалын лабораторид хийгдсэн цус, шээс, өтгөн, шархны арчдас, хамар залгиур, умайн хүзүүний арчдас зэрэг нийт 9939 сорьцоос ялгасан (бичил биетнүүдээс) антибиотикт тэсвэртэй 618 сорьцыг судалгааны материал болгон авлаа. Нянгийн антибиотикт мэдрэмжийг уламжлалт дискийн диффузын аргаар тодорхойллоо.

**Үр дүн:** Судалгаанд нийт 618 сорьц авсаны 350 (56,6%) нь шээсний, 7 (1,1%) нь цусны, 22 (3,5%) нь цэрний, 228 буюу 36,8% нь шархны идээ, 11 (1,7%) нь умайн хүзүүний арчдасын сорьц эзлэж байв. Судалгаанд нянгийн тэсвэржилтийг хамгийн өргөн хэрэглэгддэг 10 антибиотикийн дискэнд тодорхойлов. Нийт сорьцын 511 (82,6%) нь Penicillini-д, 422 (68,4%) нь Gentamycin-д, 517 (83,6%) нь Охасиллини-д, 433 (86,4%) нь Erythromycin-д тэсвэржсэн байлаа. Chloramphenicol-д 174 өсгөвөр тодорхойлсоны 113 (65,4%) нь тэсвэржсэн байлаа. Эдгээр нянгуудын 96,0% нь Cephotaxime-д, 99,7% нь Ciprofloxazin-д мэдрэг байлаа. Харин Penicillin-д

тэсвэржсэн нянгууд нь Gentamycin, Erythromycin, Охасиллин зэрэг антибиотикт тэсвэржих нь элбэг байна. Penicillin-д тэсвэржих гол шалтгаан нь зарим нян пенициллинийг задлагч β лактамаза фермент ялгаруулдагтай холбоотой. β лактамазад тэсвэртэй антибиотиктаар нянгийн тэсвэржилт ямар байгааг Охасиллин-д мэдрэг байдлаар судлаж үзэхэд нянгуудын 70-80% нь тэсвэржсэн байсан нь Эритромицин, Гентамицинд давхар тэсвэржсэн ба нэгэн зэрэг олон эмэнд дасах нь эдгээр нянгийн түгээмэл шинж болж байна. Судалгаагаар хамгийн өргөн хэрэглэдэг Пенициллин, Оксациллин, Гентамицин-д тэсвэртэй болсон нянгийн төрөл нь *S. Aureus*, *Enterobacter*, *S. pyogenes* байлаа. Шээс, шархны идээнээс ялгасан нян антибиотикт тэсвэржих явдал илүү байгаа нь байна. Антибиотик эмчилгээ шаардлагагүй байхад өвчтөний хүсэл сонирхолд нийцүүлэхээр антибиотикийг ихээр хэрэглэж явдал түгээмэл байгаа нь нянгийн антибиотикт тэсвэржих явдлыг ихэсгэдэг байна.

**Дүгнэлт:** Нийт антибиотикт тэсвэртэй өсгөврийн 82,6% нь пенициллин-д, 60,9% нь Gentamycin-д, 82,2% нь Охасиллин-д тэсвэржсэн байгаа нь эмнэлгээс шалтгаалах халдварыг үүсгэх нөхцөлийг бий болгож байна.

## БАКТЕРТ МЕНИНГИТИЙН ҮҮСГЭГЧИЙН ИЙЛДЭСТ ХЭВ ШИНЖИЙГ ТОДОРХОЙЛСОН НЬ

Д.Алтанцэцэг<sup>1</sup>, Н.Цэнд<sup>1</sup>, Д.Булган<sup>2</sup>, Д.Содбаяр<sup>3</sup>, Д.Ану<sup>1</sup>, М.Алтанхүү<sup>1</sup>,

Ч.Уртнасан<sup>1</sup>, Т.Одгэрэл<sup>1</sup>, С.Бүжинлхам<sup>1</sup>, Г.Сүрэнханд<sup>1</sup>,

Б.Лхагвасүх<sup>1</sup>, Д.Амар Ж.Сарантуяа<sup>2</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль,

<sup>3</sup>Дэлхийн эрүүл мэндийн байгууллага

**Зорилго:** Тав хүртлэх насны хүүхдийн дунд бактерит менингитийг үүсгэгч *N.meningitidis*, *H.influenzae*, *S.pneumonia*

нянгуудын ийлдэст хэв шинжийг тодорхойлж, тэдгээрийн өвөрмөц онцлог байдлыг илрүүлэх



**Материал, арга зүй:** 2002-2010 онд ЭХЭМҮТ, ХӨСҮТ, 4 дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхэд, сэхээн амьдруулах тасгаас эмнэлзүйн шинжээр бактерт менингитийн тохиолдлын тодорхойлолтыг хангасан 0-5 насны хүүхдээс тархи нугасны шингэн (ТНШ) 463, цусны сорьц 114-ийг авч нян судлал, латекс наалдуулах шинжилгээ хийж илэрсэн үүсгэгчийн ийлдэст хүрээг тодорхойлов. Илэрсэн үүсгэгчийн ийлдэс хүрээг мультиплекс ПГУ-аар тодорхойлсон ба уг шинжилгээг ХӨСҮТ болон АНУ-ийн ӨХСТӨв (CDC)-ийн бактерт менингитийн судалгааны лабораторийг түшиглэн хийлээ.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан нийт тохиолдлыг клиникийн урьдчилсан оношоор ангилбал 399 (69.1%) нь мэнэн, 100 (17.3%) менингококкцеми, 24 (4.1%) менингоэнцефалит, 8 (1.4%) татах хам шинж, 46 (8.0%) мэнэнгийн бус оноштой байлаа. Улаанбаатар хотын 0-5 насны оролцогчдын 577 сорьцоос тохиолдлын тодорхойлолтоор боломжтой тохиолдол 126(21.8%)-аас 80(63.5%)-д, магадгүй тохиолдол 249(43.2%)-аас 174(69.9%)-д, шүүдэст мэнэн 88(15.3%)-аас 25(28.4%)-д, менингококкцеми 114(19.8%)-аас 58(50.9%)-д оношийг тогтоон, бактерит мэнэн өвчний шалтгааныг тодруулж баталгаажууллаа. *H.influenzae type b* 84(14.5%), *N.meningitidis* 107(18.5%), *S.pneumoniae* 109(19.1%) – ийг тус тус эзэлж байна. Бактерит мэнэнгийн

тохиолдлыг үүсгэгчийн бүрэлдхүүнээр нь авч үзвэл 2002- 2005 онд *Hib*-ийн, 2006-2008 онд *N.meningitidis* болон *S.pneumoniae*-ийн, 2009, 2010 2011 онд *S.pneumoniae*-ийн мэнэнгийн өвчлөл давамгайлж байна.

Судалгаанд хамруулсан сорьцын 29,5%-д нян өсгөвөрлөхөөр, 36,1%-д латекс наалдуулах урвалаар *N.meningitidis*, *H.influenzae*, *S.pneumoniae* эерэг үр дүнтэй байлаа. Өсгөврийн шинжилгээ болон латекс наалдуулах урвалаар бактерит мэнэн батлагдсан 225 ТНШ болон цусны сорьцонд бх-ПГУ –ын шинжилгээгээр *H.influenzae*-100%, *N.meningitidis* - 92.6%, *S.pneumoniae* - 100% эерэг илэрсэн байна. Өсгөвөр сөрөг сорьцны 39(23.8%)-д бх-ПГУ-аар үүсгэгч илэрсэн.

Илэрсэн үүсгэгчийн өвөрмөц ийлдэс хүрээг тодорхойлоход 42.9% нь *N. Meningitides*-ийн А- хүрээ, 35.8% нь В-хүрээ, харин *H.influenzae type b* ийлдэс хүрээ нь 96.3% , *S. pneumoniae* - ийн 14.5% нь 6А/В/С, 8.2% нь 2 ийлдэст хүрээ хэвшинж давамгайлсан тодорхойлогдлоо.

**Дүгнэлт:** Улаанбаатар хотын бага насны хүүхдүүдийн бактерт менингитийн шалтгаан нь *N.Meningitides*, *H.Influenza*, *S.pneumoniae* болох нь тогтоогдсон ба энэ нь Азийн бусад орныхтой харьцуулбал өвчлөлийн түвшин өндөр байна. Түүнчлэн *N. meningitides* -ийн А, *H. Influenzae*-ийн b, *S. pneumoniae* 6А/В/С,2,14,7F-р хэвшинжүүдээр үүсгэгдсэн бактерийн менингит давамгайлж байна.

## ОЛОН ЭМЭНД ТЭСВЭРТЭЙ СҮРЬЕЭТЭЙ ҮЙЛЧЛҮҮЛЭГЧДИЙН СОРЬЦОНД ХОЁРДУГААР ЭГНЭЭНИЙ ЭМЭНД МЭДРЭГ ЧАНАР ТОДОРХОЙЛСОН ДҮН

Б.Буянхишиг<sup>1</sup>, Т.Оюунтуяа<sup>1</sup> Ж.Сарантуяа<sup>2</sup>, Я.Дагвадорж<sup>2</sup>, Н.Наранбат<sup>3</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

<sup>2</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль,

<sup>3</sup>Монголын сүрьеэтэй тэмцэх холбоо

**Зорилго:** Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэг илрүүлэх

**Материал, арга зүй:** ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн лавлах лабораторийн шинжилгээгээр илэрсэн олон эмэнд тэсвэртэй сүрьеэ, түүний дотроос хоёрдугаар эгнээний эмийн эмчилгээнд 2006-2009 онд орсон 154 хүний ялгасан өсгөвөрт маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэг илрүүлэх зорилгоор эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ хийлээ.

**Үр дүн:** Судалгаанд оролцогчдын 88 (57.1%) эрэгтэйчүүд дундаж нас 34.5±23.3 , 68 (44.8%) дундаж 31.4±23.6 байна. Сүрьеэгийн эсрэг хоёрдугаар эгнээний эмэнд мэдрэг чанар тодорхойлоход 70.8% (CI 61.5-76.4) нь мэдрэг, 29.2% (CI 61.5-76.4) нь аль нэгэн эмэнд тэсвэртэй сүрьеэ байгаа нь тогтоогдсон маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ 12.3 % (CI (9.1-20.5) байна. Эм тус бүрээр авч үзвэл тарьж хэрэглэдэг амикацин, канамицин,

капреомицин зэрэг эмүүдэд 26.0-26.5 хувийн тэсвэртэй байна. Харин офлаксадинд тэсвэржилт 13% байгаа нь ажиглагдлаа. Нэг эмэнд тэсвэртэй сүрьеэ харьцангуй бага 1-2 тохиолдол буюу 0.65-1.3 %-тай байна. Маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэ (МОЭТС) 19 (12.3%)

байгааг шинээр тодорхойллоо. МОЭТС-гийн дотор 17 тохиолдол буюу нийт тохиолдлын 11.0% нь 4 эмэнд тэсвэртэй хэлбэр байна.

**Дүгнэлт:** Монгол Улсад 2009-2011 оны хооронд маш олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн омог 19 бүртгэгдлээ.

## СУУЛГАЛТ ХАЛДВАРЫН ҮҮСГЭГЧИЙГ ПГУ-ЫН АРГААР СУДАЛСАН ДҮН

Ц. Гэрэлмаа, Ц. Мөнх-Од, Э. Цацрал, Т. Одгэрэл,  
Н. Оюун-Эрдэнэ, Д. Энхсайхан

Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Зорилго:** Суулгалт халдварын үүсгэгчийг ПГУ-ын аргаар илрүүлэх.

**Материал, арга зүй:** ХӨСҮТ-д Нян судлалын лабораторит 2012 оны 6 дугаар сараас 8 дугаар сар хүртэлх хугацаанд суулгалт халдварын шинж тэмдэгтэй 73 өвчтөнөөс авсан шулуун гэдэсний арчдаст гэдэсний халдварт өвчин үүсгэгч илрүүлэх шинжилгээ хийв. Сорьцноос ДНХ-г ялгахдаа Солонгосын Bioneer компаний цомог болон автомат аппаратыг ашиглав. *Shigella spp*, *Salmonella spp*, *Campylobacter spp*, *Vibro spp*, *Clostridium difficile* эмгэгтөрөгч нянгуудыг илрүүлэх шинжилгээг ПГУ-ын аргаар Seegene компаний суулгалт халдварт өвчин үүсгэгч илрүүлэх Мультиплекс ПГУ-ын цомгийг ашиглан хийж гүйцэтгэв. ПГУ-ын бүтээгдэхүүнийг 2%-ын агарозын гельд электрофорез гүйлгэж зургийг авч баталгаажуулав.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан 73 өвчтөний сорьцонд мультиплекс ПГУ-ын аргаар шинжилгээг хийхэд 54,8 хувьд нь (40/73) эмгэгтөрөгч нян илрээгүй, 45,2 хувьд нь (33/73) эмгэгтөрөгч нян илэрсэн. Үүнээс 21 (29%) нь *Shigella spp*, 7(9%) нь *Campylobacter spp*, 5 (7%) нь *Salmonella*

*spp* нян илэрсэн байна. Нийт сорьцонд *Vibro spp*, *Clostridium difficile* эмгэгтөрөгч нян илрээгүй байна. Эмгэгтөрөгч нян илэрсэн 33 өвчтөнийг насны байдлаар авч үзвэл бага насны хүүхдүүд зонхилж байна.

**Дүгнэлт:**

ХӨСҮТ-ийн Нян судлалын лабораторид анх удаа *Shigella spp*, *Salmonella spp*, *Campylobacter spp*, *Vibro spp*, *Yersinia spp*, *Clostridium difficile* эмгэгтөрөгч нянгуудыг мультиплекс-ПГУ-ын аргаар илрүүлэх шинжилгээг нэвтрүүлж байна.

Гэдэсний суулгалт халдварт өвчнөөр 0-4 насны хүүхдүүд зонхилон өвчилж байна.

ПГУ аргаар гэдэсний суулгалт халдварт өвчний үүсгэгчдийг илрүүлэх шинжилгээг хийх нь нян судлалын уламжлалт аргатай харьцуулахад мэдрэг чанар өндөртэй, цаг хугацаа хэмнэсэн арга юм.

Энэхүү шинжилгээний арга нь манайд анхлан хийгдэж байгаа бөгөөд үр дүнг нь өсгөвөрлөх шинжилгээ болон клиник шинж тэмдэгтэй холбож цаашид үргэлжлүүлэн судлах шаардлагатай.

## САЛМОНЕЛЛА НЯНГИЙН ТӨРЛҮҮДЭД СҮҮН ХҮЧЛИЙН БАКТЕРИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨГ СУДАЛСАН ДҮН

Э.Баттөмөр<sup>1</sup>, Б.Мандхай<sup>2</sup>, Ж.Сарантуяа<sup>3</sup>, Н.Бира<sup>3</sup>,

Ш.Дэмбэрэл<sup>4</sup>, Ж.Дүгэрсүрэн<sup>4</sup>, Л.Цогтбаатар<sup>4</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup>“Ач” АУДЭС, <sup>3</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль,

<sup>4</sup>Мал эмнэлгийн хүрээлэн

**Зорилго:** Монгол орны айраг цагаанаас гарган авсан сүүн хүчлийн бактерийн нутгийн омог нь салмонелла нянгийн төрлүүдэд хэрхэн нөлөөлж байгааг тогтоох  
**Материал, арга зүй:** Мал Эмнэлгийн Хүрээлэнгээс авсан, сүүн хүчлийн бактерийн LBO1, LBO2, LBO3, LBO4, LBO6, LBO7 дугаартай өсгөвөрүүдийг судалгаанд ашиглаж, Rogos-ийн шингэн шөлөнд 24 цаг өсгөвөрлөв. ХӨСҮТ-өөс авсан *Sal. Enteritidis*, *Sal. typhimurium*, *Sal. Bovismorbificans*, *Sal. spp*, *Sal. glostry* өсгөвөрүүдийг мах пептоны агарт ургуулан 37°C-г 24 цаг өсгөвөрлөлөө. Сүүн хүчлийн бактерийн өсгөвөрүүдийг туршилтанд хэрэглэхийн өмнө 2 хэсэгт хувааж, 1-ийг нь 15000g хурдтайгаар 10 минут хурилдуурдсаны дараа дахин 5 минут 4°C-д центрифугдэн, 0.22 μм-ийн нүх бүхийн шүүлтүүрээр шүүж эсгүй супернатант бэлдмэл гарган авав. Нөгөө өсгөвөрийн рН=5 байхаар NaOH-аар тохируулав. *Salmonella*-ийн өсгөвөрүүдээс MacFarland-ийн 0.5-тай тэнцүүлсэн булинга бэлдэж үүнийгээ TSA агар бүхий Петрийн аяганд битүү тараана. Дээрх аргачлалаар гаргасан сүүн хүчлийн бактерийн өсгөвөрүүдийн эстэй болон эсгүй супернатантийг 6 см-ийн цаасан дискэнд шингээж ариун хямсаа ашиглан байрлуулж 37°C-г 48 цаг өсгөвөрлөн дарангуйлах хүрээ үүсгэсэн байдлаар нь үр дүнг тооцсон бөгөөд 8 мм түүнээс том хүрээ үүсгэсэн тохиолдолд дарангуйлж байна гэж үзэв. Хүрээ нь 8-12 мм бол бага мэдрэг, 13-18 мм бол дунд зэргийн мэдрэг, 19-24 мм бол мэдрэмтгий, 25 мм-ээс том бол маш их мэдрэг гэж тооцлоо. Антибиотик мэдрэг чанарыг амоксациллин, цефазолины

дискгийг ашиглан АНУ-ын эмнэлзүйн хорооноос зөвлөсөн NCCLS стандартаар тус тус тодорхойлов.

**Үр дүн:** Сүүн хүчлийн бактерийн өсгөвөрүүдээс LBO-4, LBO-6 дугаартай өсгөвөрүүд салмонелла нанд ямар ч нөлөө үзүүлээгүй, Сүүн хүчлийн бактерийн өсгөвөрүүдээс хамгийн идэвх сайн өсгөвөр нь LBO2 байлаа. Сүүн хүчлийн бактерийн LBO2 өсгөвөрийн эс болон эсээс ялгарч байгаа метаолитуудын аль аль нь салмонелла нянгийн төрлүүдийг дарангуйлж байна. Сүүн хүчлийн бактераас ялгарч байгаа бодисын солилцооны бүтээгдэхүүнүүд нь эсээ бодвол илүү дарангуйлах хүрээ үүсгэж байна. Сальмонелла нянгийн төрлүүдээс *Sal. typhimurium* амоксациллин болон цефазолинд, *Sal. bovismorbificans* цефазолинд тэсвэртэй байна. Салмонеллагийн бусад төрлүүд нь дээрх антибиотикүүдэд мэдрэг байлаа. Сүүн хүчлийн бактерийн ургалт саатуулах бүс нь антибиотикийн дарангуйлах бүстэй харьцуулбал бага, ургалт саатсан бүсэд эсийн колон бага зэрэг байгаа нь бидний сонгон авсан салмонеллагийн өсгөвөрүүд гэдэсний халдвар үүсгэх хоруу чанар өндөртэй байсанд оршино.

**Дүгнэлт:** Сүүн хүчлийн бактер нь сальмонелла нянгийн ургалтыг дарангуйлж байгаа ч антибиотикийн адил хүчтэй дарангуйлахгүй байгаа нь тогтоогдов. Иймд сүүн хүчлийн бактерийг сальмонелла нянгийн халдварын эсрэг антибиотик эмчилгээтэй хавсрах болон эмчилгээний дараа тунг нь тохируулан хэрэглэх нь эмчилгээний үр дүнг нь сайжруулахын зэрэгцээ антибиотикийн гаж нөлөөг багасгах давуу талтай.

## ЭГЭЛ БИЕТНИЙ ЭСРЭГ ЭМЭНД *TRICHOMONAS VAGINALIS* –ИЙН МЭДРЭГ ЧАНАРЫГ IN VITRO ОРЧИНД ТОДОРХОЙЛСОН ДҮН

Ц.Уранцэцэг<sup>1</sup>, Д.Нармандах<sup>1</sup>, Э.Цацрал<sup>1</sup>, Э.Саруул<sup>2</sup>,  
Н.Гиймаа<sup>2</sup>, Д.Оюунгэрэл<sup>2</sup>, А.Гүрбадам<sup>2</sup>, Im Kyung il<sup>2</sup>, Д.Тэмцүлэн<sup>2</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

**Зорилго:** *Trichomonas vaginalis*-ийг In vitro орчинд цэврээр өсгөвөрлөн, түүний эсрэг өргөн хэрэглэгддэг эмийн мэдрэг чанарыг шингэрүүлэлтийн аргаар тодорхойлох.

**Материал, арга зүй** БЗДХ-ын шинж тэмдэг илрэн ХӨСҮТ-ийн “Улаан тууз” эмнэлэгээр үйлчлүүлсэн 17-49 насны 20 эрэгтэй, 109 эмэгтэй нийт 129 хүний бэлгийн ялгарлыг шинжилгээний сорьц болгон ашиглав.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан 129 хүний клиник сорьцонд *Trichomonas vaginalis* илрүүлэх шинжилгээг оношлогооны зориулалттай Feinberg-Whittington тэжээлт орчин (HiMedia-India)-д өсгөвөрлөх аргаар явуулж, 48 цагийн дараа хянахад 60 (37.7%) сорьц эерэг дүнтэй байв. Feinberg-Whittington тэжээлт орчин (HiMedia-India)-дах *Trichomonas vaginalis*-ийн бүх өсгөвөр (100%)-г нян, 31 өсгөвөр (51.7%)-г нян, мөөгөнцөр (*Candida spp*) давхар ургасан байлаа. *Trichomonas vaginalis*-ийн 60 өсгөвөрүүд дэх нян, мөөгөнцрийн бохирдолт хэвээр байсан тул тэжээлт орчин дах нян, мөөгөнцрийн шинж чанарыг тодорхойлох зорилгоор цустай тэжээлт орчинд тарив. Туршилтын дүнгээс үзэхэд *Trichomonas vaginalis*-ийн өсгөвөрийн 46/60 (76.7%) Грам сөрөг савханцар, 12/60 (20%) Грам эерэг кокк, 3/60 (5%) Грам сөрөг савханцар болон мөөгөнцрөөр бохирлогдсон байсан. Грам эерэг кокк болон мөөгөнцрөөр бохирлогдсон 1/60 (1.7%), дан мөөгөнцрөөр бохирлогдсон 2/60 (3.3%) өсгөвөр байв. Дээрх судалгаанаас үзэхэд *Trichomonas vaginalis*-ийн өсгөвөрийг үтрээний болзолт болон болзолт бус нян, мөөгөнцөр бохирдуулсан байна.

*Trichomonas vaginalis*-ийн бохирлогдсон өсгөвөрүүд дэх нян, мөөгөнцрийн антибиотикт мэдрэг чанарыг диск нэвчүүлэх аргаар тодохойлов. *Trichomonas vaginalis*-ийн өсгөвөр дэх Грам эерэг кокк, Грам сөрөг савханцрын 73.3% пенициллинд тэсвэртэй байхад, 26.6% дунд мэдрэг байлаа. Харин стрептомицинд 11.6% тэсвэртэй, 48.3%

дунд мэдрэг байлаа. Тэжээлт орчин нян, мөөгөнцрийн эсрэг антибиотик агуулдаг ч үтрээнд байх болзолт болон болзолт бус эмгэгтөрөгч нян, мөөгөнцөр зэрэг нь тэжээлт орчны антибиоткийн тун (пенициллин 100 мкг/мл, стрептомицин 100 мкг/мл)-д ихэнх нь (96.6%) дасалтай байсан тул *T. vaginalis*-ийн цэвэр өсгөвөр гаргаж авахад ихээхэн бэрхшээлтэй байв. Ийм учраас 60 эерэг өсгөврөөс 30 өсгөврийг цааш үргэжлүүлэн өсгөвөрлөх боломжгүй болов.

*Trichomonas vaginalis*-ийн үлдсэн 30 өсгөвөр дэх нян мөөгөнцрийн өсөлтийг дарангуйлах антибиотик, антимицотикийг зохистой тунг тодорхойлоход пенициллин/стрептомицины 200 мкг/мл, гентамицины 100 мкг/мл, амфотерицин Б-гийн 0.5 мкг/мл тунд нянгийн ургалт саарч, *T. vaginalis*-ийн ургалт хэвийн явагдаж байв. Эгэл биетний эсрэг эмэнд *Trichomonas vaginalis*-ийн мэдрэг чанарыг 24 цагийн дараа хянахад *Trichomonas vaginalis*-ийн өсөлтийг саатуулах метронидазолын хамгийн бага тун  $17.14 \pm 15.7$  мкг/мл, тинидазолын хамгийн бага тун  $5.5 \pm 6.5$  мкг/мл дээр тодорхойлдсон. Дараа нь эмгүй тэжээлт орчинд сэлгүүлж, дахин 48 цаг өсгөвөрлөн метронидазолын *Trichomonas vaginalis*-ийг үхүүлэх хамгийн бага тунг тодорхойлоход  $21.43 \pm 15.77$  мкг/мл, харин тинидазолын үхүүлэх хамгийн бага тун  $10 \pm 13.46$  мкг/мл байв.

**Дүгнэлт:** *T. vaginalis*-ийн цэвэр өсгөвөр бэлтгэхэд пенциллин/стрептомициний 200 мкг/мл, гентамицин 100 мкг/мл, амфотерицин Б 0.5 мкг/мл тун зохистой байж, 30 цэвэр өсгөвөр бэлтгэв. *T. vaginalis*-ийн цэвэр өсгөвөр тус бүрт  $10^7$  трофозоит/мл агуулагдаж байв.

*Trichomonas vaginalis*-ын өсөлтийг саатуулах метронидазол хамгийн бага тун  $17.14 \pm 15.7$  мкг/мл, тинидазолын хамгийн бага тун  $5.5 \pm 6.5$  мкг/мл байна.

*Trichomonas vaginalis*-ын үхүүлэх метронидазол хамгийн бага тун  $21.43 \pm 15.77$  мкг/мл, тинидазолын үхүүлэх хамгийн бага тун  $10 \pm 13.46$  мкг/мл байна.



## ҮРГҮЙДЭЛ БОЛОН ҮТРЭЭНИЙ ҮРЭВСЭЛТЭЙ ЭМЭГТЭЙЧҮҮДЭД МИКОПЛАЗМ, УРЕАПЛАЗМ ИЛРҮҮЛСЭН НЬ

Ц.Уранцэцэг<sup>1</sup>, Д.Нармандах<sup>1</sup>, Я. Дашпагма<sup>2</sup>,

Т.Баярчимэг<sup>2</sup> Д. Алтанцэцэг<sup>1</sup>,

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>2</sup> Улсын 2-р төв эмнэлэг

**Зорилго:** Үргүйдэлтэй болон үтрээний үрэвсэлтэй эмэгтэйчүүдэд микоплазм, уреоплазмыг илрүүлэх

**Материал, арга зүй:** Судалгаанд ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ы “Улаан тууз” эмнэлэг, Улсын 2-р төв эмнэлгийн эмэгтэйчүүдийн кабинет, “Жинст” хувийн эмнэлэгээр үйлчлүүлсэн үргүйдэл болон үтрээний үрэвсэлт өвчтэй 93 эмэгтэйчүүдийг хамрууллаа.

**Үр дүн:** Судалгаанд хамрагдсан нийт 93 эмэгтэй үйлчлүүлэгчдээс уреоплазм, микоплазм илрээгүй 27 (29.1%), илэрсэн 66 (70.9%) байна. Насны байдлаар нь үзвэл 20-оос доош насанд 4 (4.3%), 20-30 насанд 41 (44.1%), 31-40 насанд 33 (35.5%), 41-50 насанд 12 (12.9%), 51-с дээш насанд 3 (3.2%) байна. Үргүйдэлтэй гэсэн 8 үйлчлүүлэгчээс микоплазм, уреоплазм илрээгүй 1 (12.5%), микоплазм дангаараа илэрсэн 2 (25%), уреоплазм илэрсэн 4 (50%), микоплазм, уреоплазм хавсарч илэрсэн 1 (12.5%) байлаа. Микоплазм болон уреоплазмын халдварын үед доксициклин 80.3%, жосамицин 68.1%, тетрациклин 68.1%

зэрэг антибиотикүүдэд мэдрэг гарсан бол офлоксацин 44%, эритромицин 74.2%, азитромицин 62.1%, цифрофлоксацин 84.8%, пристионамицин 72.7% зэрэг антибиотикүүдэд харьцангуй дасалтай гарчээ.

### Дүгнэлт

1. Шинжилгээнд уреоплазм нь микоплазмаас илүү буюу өвчтөний 65.2%-д илэрч байна.
2. Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдэд түлхүү буюу 20-30 насныхны 44.1%, 31-40 насныхны 35.5%-д тус тус микоплазм, уреоплазм илэрч байгаа нь анхаарвал зохих асуудлын нэг гэдгийг харуулж байна.
3. Үргүйдэлтэй эмэгтэйчүүдийн 87.5% нь ямар нэг хэлбэрээр эдгээр үүсгэгчид илэрч байгаа нь анхаарал татаж байна.
4. Судалгаанд хамрагдагсадын антибиотик мэдрэг чанарын шинжилгээнд 9 антибиотикийн 5-д харьцангуй дасалтай байгаа нь энэ талын оношлогоо, судалгаа бага мөн эмийн зохисгүй хэрэглээ түгээмэл байгаатай холбоотой байж болох талтай.

## ХАЧИГТ РИККЕТСИОЗЫГ СУДАЛСАН ДҮН

Д.Абмэд<sup>1</sup>, Ж.Батаа<sup>1</sup>, М.А.Хаснатинов<sup>2</sup>,

Г.А.Данчинова<sup>2</sup>, Д.Ану<sup>1</sup>, Б.Оюунбилэг<sup>1</sup>,

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

<sup>2</sup>ОХУ-ын Анагаах ухааны академийн Сибирын салбарын

Эрхүүгийн халдвар нян судлалын хүрээлэн

**Үндэслэл:** Хачигт риккетсиоз (ХР) нь зөөвөрлөгчөөр дамжин халдварладаг зооноз өвчин юм. Одоогоор риккетсийн 30 гаруй хэвшинж бүртгэгдээд байгаа боловч тэдгээрээс цөөн хэвшинж нь хүнд өвчин үүсгэдэг бөгөөд хачиг, бөөс зэрэг цус сорогч үе хөлтнөөр зөөвөрлөгддөг байна (CDC, 2004). *R.rikettsii* хойт, өмнөд болон төв Америк-т уулын толбот халуурал өвчний үүсгэгч болдог байхад, *R.sibirica* Европ болон Азид энэ

халдварын үүсгэгч болдог. *R.australis* Авсрали улсад, *R.japonica* Япон улсад тус тус ХР-ын үүсгэгч болдог. Ихэнх тохиолдолд *R.sibirica*, *R.rikettsii*, *R.conori*, *R.mongoltimone* өвчлөл үүсгэдэг. Манай улсад ХР 2006 онд халдварт өвчний бүртгэлд орсон. Сүүлийн жилүүдэд хачигт риккетсийн өвчлөл ихсэх хандлагатай байгаатай холбогдуулан бид энэ судлагааны ажлыг хийлээ.

**Зорилго.** Хачигт риккетсиозоор

өвчлөгсдийн эмнэлзүй, уг халдварын үүсгэгчид, тэдгээрийн зөөвөрлөгчдыг судлах.

**Материал арга зүй.** ХӨСҮТ-д ХР оноштой хэвтэж эмчлүүлсэн өвчтнүүдийн өвчний түүхэнд эргэмж судалгааг хийж, хачгийг дарцгийн аргаар түүвэрлэж, хачгаас вирүс ялгахдаа эсийн өсгөвөр, ПГУ-д риккетсийн I6S rRNA генийн ApIF (5' -TCCTGGCTC AG A ACG AACG-3') ба ApIR (5'-CCTACAGCTACSTTGTTCAG-3') праймерыг ашиглаж, сиквенсыг Beckman Coulter Genetic Sequencing System 1800 (АНУ) багажаар хийв. Фелогенетикийн анализд Tamura-Nei модель, Neighbour-joining аргыг хэрэглэв.

**Үр дүн.** Өвчний нууц үе дунджаар 4 хоног байв. Улирчлал нь 4-р сард 30.0%, 5-р сард 59.1%, 6-р сард 10.9% тохиолдож байна. Эмнэлзүйн хэлбэр нь хачиг хазсан газарт үүсэх анхдагч бүрдэл, ойролцоох тунгалагийн булчирхай үрэвсэх, арьсаар тууралт гарах зэрэг үндсэн 3 шинж тэмдэг илэрсэн хэлбэр 20.0%, анхдагч бүрдэл, ойролцоох тунгалагийн булчирхай үрэвсэх үндсэн 2 шинж тэмдэгтэй хэлбэр 80.0% тус тус байв. Сэлэнгэ, Булган, Орхон аймгаас түүвэрлэсэн хачгуудын төрөл зүйлийг тодорхойлоход *Dermacentor sp.* (142), *I. persulcatus* (174) байв. Хачигнаас ялгасан риккетсид хийсэн молекул биологийн шинжилгээгээр: 29

*Dermacentor sp* хачгийн 28-д *R.raoulti*, 1-д *R.sibirica*; 20 *I.persulcatus* хачигны бүгдэд *R.canadensis* төст риккетси; 17 *I.persulcatus* хачигны 7-д *R.tarasevichia* тус тус тодорхойлогдов. Билчээрийн хачиг *Dermacentor* нь ойн хачиг *I.persulcatus*-аас илүү риккетсээр халдварлагдсан байв (*Dermacentor sp.*-78%, *I.persulcatus*-46%).

**Дүгнэлт.**

1. Бэлчээрийн хачгийн идэвхижилтийн оргил үе болох 4,5-р саруудад хүмүүс хачигт хазуулж өвдөх их байна.
2. Хачгуудаас риккетси ялгаж фелогенетикийн анализ хийхэд *R.raoulti*, *R.sibirica*, *R.tarasevichia* ба *R.canadensis* төст риккетси тодорхойлогдов. Манай оронд хамгийн өргөн тархсан *Dermacentor* төрлийн хачгууд риккетсээр илүү халдварлагдсан байсан ба энэ төрлийн хачигт хазуулж хүмүүс голчлон риккетсиозоор өвчилдөг.
3. Ойн хачгаар ззөөвөрлөгдөн халдварлагддаг хачигт энцефалит, хачигт боррелиоз зэрэг өвчнүүдийг нилээд сайн судалж, тэдгээр халдваруудыг оношлох, эмчлэх, сэргийлэх арга хэмжээнүүд боловсрогдож амжилттай хэрэгжсэн бөгөөд билчээрийн хачгаар зөөвөрлөгддөг олон төрлийн риккетсиозуудын талаарх судалгааг хийж эхлэж байна

**ТОХОР *PLASMA GONDII*-ИЙН ИЙЛДЭС-ТАРХАЛТ ХОТ, ХӨДӨӨГИЙН ХҮН АМД**

Д.Ану<sup>1</sup>, Сун Хи Хонг<sup>2</sup>, Сан Ун Ли<sup>2</sup>, Уон Жа Ли<sup>2</sup>, Д.Абмэд<sup>1</sup>

<sup>1</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

<sup>2</sup>БНСУ-ын Өвчний Хяналт Сэргийлэлтийн Төвийн Хумхаа, Шимэгчийн Алба

**Үндэслэл.** *T. gondii* нь бараг бүх сүүн тэжээлтэнд халдварлах боломжтой эсийн доторхи шимэгч бөгөөд халдварын эх уурхай нь муур юм. Дэлхийн хүн амын гуравны нэг нь *T.gondii*-р халдварлагдаж, дэлхийн бөмбөрцгийн 10-70%-д уг халдвар нутагшмал байдаг. Уг халдварын өвчлөл дархлаа тогтолцоо хэвийн хүмүүст ихэнхдээ шинж тэмдэггүй явагдах хэдий ч дархлаа суларсан өвчтөнүүдэд хүнд хэлбэрийн өвчлөлийг үүсгэнэ. Сүүлийн үеийн судалгаагаар *T.gondii* тархины эсэд халдварлахад шизофрения, сэтгэцийн хямрал, хувь хүний араншин өөрчлөгдөх зэрэг зан

төлвийн өөрчлөлтүүд болон оюун ухаан муудах шинжүүд илэрдгийг тогтоожээ. Мөн жирэмсэн эмэгтэй халдвар авснаар ураг зулбах, хараагүй, дүлий, оюун ухааны хомсдол, микроцефали, гидроцефали болон бусад мэдрэлийн өвчтэй хүүхэд төрдөг. Манай оронд ураг зулбадаг, хүүхэд нь дутуу ба гажигтай төрдөг эмэгтэйчүүдэд (Д.Абмэд нар 1988) болон ХДХВ-ийн халдвартай өвчтөнүүдэд *T. gondii*-г илрүүлэх судалгаа хийгдэж байсан хэдий ч нийт хүн амын дунд халдварлалтын түвшинг тогтоох судалгаа хийгдээгүй байсан нь бидний ажлын үндэслэл болсон.

**Зорилго.** Хот хөдөөгийн хүн амын дунд *T. gondii*-н халдварын тархалтыг тогтоож, харьцуулан судлах.

**Мгтериал, арга зүй.** 2010 оны 9 сараас 2010 оны 12 сар хүртэл Улаанбаатар хот, Баянхонгор аймгийн төвийн гэртээ нохой, муур тэжээдэг, дээрх халдваруудын эрсдэл бүхий нийт 500 хүний ийлдэст ФХУ-ыг үйлдвэрлэлчийн заавраар явуулав.

**Үр дүн.** Бидний судалгаанд хамрагдсан хүн амын дунд *T. gondii*-ийн халдварлалт 3.2%, үүнээс Улаанбаатар хотод 5.2%, Баянхонгор аймагт 1.2% байв.

*T.gondii*-н эсрэг IgG эрэгтэйчүүдэд 0.8%, эмэгтэйчүүдэд 2.4% тус тус тодорхойлогдсон.

*T. gondii*-н эсрэг IgG илэрсэн хүмүүсийн насыг 5 бүлэгт хувааж үзэхэд: Улаанбаатар хотод *T. gondii*-н халдварлалт 20-с доош насанд 0%, 20-

29-д 15.38%, 30-39-д 15.38%, 40-49-д 23%, 50-с дээш насанд 46.1% байсан бол Баянхонгор аймагт 0%, 0%, 66.66%, 33.33%, 0% тус тус байв.

**Дүгнэлт.** Бидний судалгаанд *T. gondii*-ийн халдварлалт бусад орныхтой харьцуулахад бага байгаа нь гэртээ муур тэжээх нь Монголчуудын дунд харьцангуй ховор, хүн амын дунд махыг түүхий, шүүрхийгээр хэрэглэх явдал түгээмэл биштэй холбоотой байж болох юм. Халдварлалт хотын хүн амд хөдөөтэй харьцуулахад өндөр байна. *T. gondii*-ийн эсрэг IgG-ийн ийлдэс тархалт эмэгтэйчүүдэд илүү өндөр байгаа нь нийгмийн эрүүл мэндэд чухал ач холбогдолтой. Эмэгтэйчүүд уламжлалын дагуу хооллох, эрхлүүлэх зэргээр тэжээвэр амьтадтайгаа ойр байдаг, мөн хоол бэлтгэхэд түүхий махтай үргэлж харьцдагаараа *T. gondii*-ийн халдвар авах эрсдэл эрэгтэйчүүдээс илүү байдаг.

## ”ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭГ БАГЦ”-ААР ХҮРГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ АНАГААХЫН ЧИГЛЭЛИЙН СУРГУУЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАСАН БАЙДЛЫГ ҮНЭЛСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН

Н.Дондог<sup>1</sup>, С.Наряд<sup>1</sup>, Р.Оюунгэрэл<sup>2,3</sup>, Ц.Бадамсүрэн<sup>4</sup>,  
Н.Сувдмаа<sup>1</sup>, Б.Энхтуяа<sup>5</sup> Ч.Мөнхцэцэг<sup>6</sup>, М.Цолмон<sup>1</sup>,  
Л.Дашицэрэн<sup>1</sup>, О.Оюунтуяа<sup>1</sup>, А. Номин<sup>3</sup>

<sup>1</sup> Эрүүл мэнд-дархлаажуулалт ТББ,

<sup>2</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв,

<sup>3</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль,

<sup>4</sup>Хавдар судлалын үндэсний төв,

<sup>5</sup>Зоонозын өвчин судлалын үндэсний төв,

<sup>6</sup>Эрүүл мэндийн яам

**Зорилго:** Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг багцаар нь хүргэх үйл ажиллагааны үндсэн хөшүүргийн нэг Монгол Улсын Эрүүл Мэндийн Сайдын 2011 оны 154 тоот тушаалаар батлагдсан “Сум дүүрэг бүрт хүрч үйлчилье” стратегийг улс, хувийн хэвшлийн анагаахын чиглэлийн сургуулиудын сургалтын хөтөлбөрт тусгасан байдлыг үнэлэх

**Материал, арга зүй:** Судалгааг нэг агшингийн аргаар Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны их сургууль (ЭМШУИС), ЭМШУИС-ийн харьяа Дорноговь, Говь- Алтай, Дархан – Уул аймгийн анагаах ухааны салбар сургууль, ЭМШУИС-ийн Эрүүл

мэндийн Технологийн сургууль зэрэг улсын 5 сургууль, Этүгэн, Ач, Монос зэрэг хувийн хэвшлийн анагаахын 3, нийт 8 сургуулийг сонгон хийв. Судалгаанд оролцох оюутнуудыг тухайн сургуулиудын 2012 онд төгсөх ангийн болон хөтөлбөрт хамрагдсан байх бусад ангийн оюутнуудыг энгийн санамсаргүй түүвэрлэлтийн аргаар сонгов. Тооны болон чанарын арганд үндэслэн хөтөлбөрийн агуулгын талаарх мэдээллийг сургуулиудын удирдах ажилтнууд, багш нартай 6 төрлийн чиглүүлэх асуултаар 8 удаа бага бүлгийн ярилцлагыг нийт 31 багштай хийж, эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын талаарх мэдлэгийг

533 оюутнуудаас 21 асуулт бүхий асуумж авч судалгааны мэдээллийг цуглуулсан. Судалгааны мэдээ, мэдээллийг EPI info программ ашиглан боловсруулалт хийв. Чанарын үнэлгээний мэдээллийг багш нартай хийсэн бага бүлгийн ярилцлагын үнэлгээний зорилго, зорилттой уялдуулан гар аргаар кодолж, бүх үг, өгүүлбэрт анализ, дүгнэлт хийв.

**Үр дүн:**

Анагаах ухааны сургуулиуд эх хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын (ХӨЦМ, дархлаажуулалт, Эсэн мэнд амаржихуй, нөхөн үржихүй, Хүүхдийн хоол (бичил) тэжээл) талаарх хичээлийг 100% сургалтын хөтөлбөртөө тусган зааж байгаа нь оюутнаас авсан асуумжийн хариултаас харагдаж байна. ХӨЦМ-ийн талаар судалгаанд оролцогчдын 61.2% нь амьсгал саадтай хүүхдийг үнэлж ангилахыг, 68.8% нь цээж хонхолзох шинжийг, 63.4% нь амьсгал авахад гарч буй эмгэг чимээ, шуугиант амьсгалыг, 72.0% нь хүндрэлгүй, уушгины цочмог үрэвслийн үед 6 сараас дээш насанд пенициллин хэрэглэх тунг, 77.9% нь нэг хүртэлх насны хүүхдийн шингэн алдсан шинжийг, 72.4% нь цочмог суулгалт өвчний үед биемахбодийн алдсан усыг нөхөх давсыг, 69.8% нь суулгалт өвчин эхэлмэгц гэрээр эмчлэхийг, 66.0% нь суулгалт өвчний үед судсанд тариа хийх эмчилгээний заалтыг, 83.3% нь хүүхдийг нэмэлт хоолонд оруулах хугацааг тус тус зөв хариулсанаас харахад эх хүүхдийн тусламж, үйлчилгээг багцаар хүргэх талаар дунд зэргийн мэдлэгтэй байна.

Судалгаанд оролцсон оюутнууд 5 хүртэл насны хүүхдийн идэвхтэй эргэлтийг өрхийн эмч, сувилагч нар хэдийд хийх талаарх асуултын 11.7-36.5%д нь зөв хариулсан нь хангалтгүй байна.

Засгийн газрын тогтоолоор баталсан Заавал хийх үндэсний товлолын вакцины нэрсийг оюутнуудын 64.9-83.7% нь зөв хариулж, дархлаажуулалтын талаар мэдлэгтэй байна.

Жирэмсний хяналтын тухай 91.7% нь зөв хариулж, хаана төрөх талаар 33,4% нь сумын эмнэлэгт, 3.2% нь, гэртээ, 4.7% нь мэдэхгүй гэж хариулсан нь хангалтгүй байна. Эхийг сумын эмнэлэгт төрүүлэхгүй байх талаар гарсан Эрүүл мэндийн сайдын тушаалын талаарх мэдлэг хангалтгүй байна. Судалгаанд оролцогчдын 78.2% нь

хүүхдийг төрөнгүүт 30 минутын дотор ангир уургаар амлуулах талаар мэдэж байна. Витминжуулалтын талаар хүүхдэд А аминдэмийг 58.3% нь 6 сараас -59 сартайд нь хүүхдэд жил бүрийн 5 ба 10 дугаар сард уулгахыг, Д аминдэмийг 67.4% нь 1-23 сартай хүүхдэд намар, өвөл, хаврын улиралд сар бүр уулгах талаар мэдэж байна. Олон найрлагат бичил тэжээлийн талаар судалгаанд оролцогч оюутнууд 64.0% нь мэдэж байгаа боловч, хүүхдэд хэдэн насанд нь яаж өгөх талаарх асуумжинд 22.1% нь зөв хариулсанаас харахад олон найрлагат бичил тэжээлийн талаарх мэдлэг хангалтгүй байна.

Эрүүл мэндийн яамнаас шинэ гарсан аливаа тушаал, зааврууд Анагаахын сургуулиудад ирдэггүй, ирсэн тохиолдолд ямар нэг шийдвэр хүлээхгүйгээр хичээлийн агуулгад оруулж оюутнуудад зааж, мэдээлэл өгөх бүрэн боломжтой гэж бага ярилцлагын үеэрх багш нарын хариултаас тодорхой харагдаж байна.

Өрхийн болон нэгдсэн эмнэлгийн эмч нар оюутны дадлагыг удирдаж байгаа боловч ихэнх цагаа үзлэгт зарцуулдаг, зарим нь дадлагын оюутныг гарын үзүүрт зарж, туслуулдаг нь дадлагын үнэ цэнийг муутгах хүчин зүйл болзошгүй байна. Аливаа тушаал, заавар боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх сургалт, семинарт улс хувийн хэвшлийн анагаахын сургуулийн багш нарыг оролцуулдаггүй нь багшаар нь дамжуулж оюутанд мэдлэг олгох үйл ажиллагааг анхаарах шаардлагатай байгаа нь ажиглагдлаа.

**Дүгнэлт:**

1. Анагаах ухааны сургуулиудад эх хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаарх хичээлийг сургалтын хөтөлбөртөө тусган зааж байгаа нь сайшаалтай боловч оюутны мэдлэгийн түвшин дунд зэрэг байна.
2. ЭМЯ-наас гаргаж байгаа тушаал, зааврыг анагаах ухааны сургуулиудад хүргэж байх цахим сүлжээний тогтолцоог буй болгох, улс хувийн хэвшлийн анагаахын чиглэлийн сургуулийн багш нарыг эрүүл мэндийн тусламж үйлчилгээтэй холбоотой бодлогын баримт бичиг боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд татан оролцуулах ажил хангалтгүй байна.
3. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцын талаар сум, өрхийн эмч, багийн эмч нарт зориулсан төгсөлтийн дараах



сургалт, зайны сургалт, сургалтын материал (телевизийн хичээл, видео хичээлийг тогтмол явуулах, CD, DVD) нэгжид төдийлөн хүрэхгүй байна.

4. Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний талаар сум,

өрхийн эмнэлэгт зохион байгуулагддаг дадлагын хичээлийн чанарыг сайжруулах хөшүүрэг ашиглах талаар улс, хувийн хэвшлийн анагаахын сургуулиуд анхаарч ажиллах нь зүйтэй байна.

## МЭС ЗАСЛЫН ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭЛТЭД ПОВИДОН ИОДЫН (ТАМЕДИН®) БЭЛДМЭЛИЙГ ХЭРЭГЛЭСЭН ТУРШИЛТЫН НЭГДСЭН ДҮНГЭЭС / 2000 -2009 ОН/

О.Сэргэлэн<sup>1</sup>, Б.Гоош<sup>1</sup>, Г.Нарангуа<sup>1</sup>, С.Эрдэнэ<sup>1</sup>, С.Амарсайхан<sup>1</sup>, Давааням<sup>1</sup>, Г.Нямхүү<sup>2</sup>,  
П.Батчулуун<sup>2</sup>, Б.Төмөрбаатар<sup>2</sup>, Б.Нарантуяа<sup>2</sup>, Б.Бямбадорж<sup>2</sup>,  
Д.Нямсүрэн<sup>2</sup>, Д.Мягмар<sup>2</sup>,  
Э.Батөлзий<sup>2</sup>, Д.Даш<sup>2</sup>, Л.Өлзийбат<sup>2</sup>, С.Оюунгэрэл<sup>2</sup>, Д.Дэмбэрэлнямба<sup>3</sup>, М.Ариунаа<sup>3</sup>,  
Г.Өлзийжаргал<sup>3</sup>, Б.Мөнхцэцэг<sup>4</sup>, Л.Лхагвасүрэн<sup>5</sup>

<sup>1</sup>Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль

<sup>2</sup>Улсын клиникийн төв эмнэлэг,

<sup>3</sup>Монхимо ЭШТТ,

<sup>4</sup>Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн,

<sup>5</sup>Халдварт өвчин судлалын үндэсний төв

**Үндэслэл:** Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвшөөрөгдсөн, хөгжингүй орнуудад нийтлэг хэрэглэгдэж байгаа антисептик бүтээгдэхүүнийг мэс заслын практикт өргөн хэрэглэх шаардлагатай боловч гадаад орнуудын дэмжлэг тусламжийн хүрээнд хааяа ирдэг, олдоц ховор байсан. “Повидон иодын бэлдмэл”-ийг ШУУ-ийн Монхимо компанийн Эрдэм шинжилгээ туршилтын төвд 2000 оноос эхлэн “Тамедин” нэрээр цуврал бэлдмэлийг үйлдвэрлэх технологи, стандартыг боловсруулан, үйлдвэрлэлд шилжүүлж, улсын бүртгэлд бүртгүүлснээр “Үндэсний антисептик” бүтээгдэхүүнтэй болсон.

**Зорилго:** Олон улсын мэс заслын халдвар хамгааллын стандартыг өөрийн орны мэс заслын практикт нэвтрүүлэн өдөр тутмын хэрэглээ болгож, эмнэлгээс шалтгаалах халдварыг бууруулах, ариутгал халдваргүйтгэлийн чанарыг шинэ түвшинд хүргэх

**Материал, арга зүй:** Монхимо эмийн үйлдвэрийн бүтээгдэхүүн Тамедин® нэрийн повидон иодын цуврал бэлдмэлийг мэс заслын халдваргүйтгэлд хэрэглэх арга, тунг тогтоох туршилт судалгааг 2002-2009 онд клиникийн болон нян судлалын шинжилгээгээр гүйцэтгэв. УКТЭ-ийн ХНТ-ийн 36 мэс засалч эмч, 14 хагалгааны сувилагчийн гарын халдваргүйтгэлийг мэс заслын

өмнө тамедин 7,5%-ийн шингэн савангаар 220-иод удаа туршилтыг стандарт технологийн /өмнөх судалгааны дүнд гарган авсан/ дагуу үйлдлийг гүйцэтгүүлсэн. Санамсаргүй байдлаар 15 эмч, 7 сувилагчаас /нийт 22/ судалгаанд оролцохын өмнө болон дараа асуумж судалгаа авсан.

**Үр дүн:** Асуумжийн судалгааны дүнгээс үзэхэд судалгаанд хамрагдсан 22 хүн уламжлалт гар угаах аргаас 100% татгалзаж, тамедин шингэн савангаар угаах стандартыг дэмжсэн байна. Судалгаанд оролцогсдын 22,7% (5/22) хувь нь мэргэжлийн онцлогоос хамаарсан харшилтай гэсэн хариулт өгсөн бөгөөд тамедин шингэн савангаар угаасны дараа харшил хөдлөөгүй гэсэн байна. Нян судлалын шинжилгээгээр тамедин шингэн савангаар гар угаасны дараа нянгийн ургалт илрээгүй байна.

Мэс заслын талбайг тамедины цуврал бэлдмэлүүдээр халдваргүйжүүлсний дараах нян судлалын шинжилгээгээр нянгийн бохирдол илрээгүй. Хяналтын бүлгийн 20 өвчтний анхан болон давтан боолтын өмнөх нян судлалын шинжилгээний хоёрт (2/20) нянгийн ургалт илэрсэн бөгөөд 1.2-аар хувилбарын боолтын дараа нянгийн ургалт дахин илэрсэн ч (1/13) халдваргүйжүүлэх боолтын дараах шинжилгээнд нянгийн бохирдол илрээгүй байна.

Үндсэн бүлгийн өвчтний анхан болон давтан боолтын өмнөх 68 нян судлалын шинжилгээний тавд (5/68) нянгийн ургалт илэрсэн бөгөөд “Тамедин” цуврал бэлдмэлээр халдваргүйжүүлэлт хийсэн аль ч хувилбарын дараа нянгийн ургалт илрээгүй байна.

**Дүгнэлт:**

1. Мэс заслын гар, талбайн халдваргүйтгэлийн туршилтын технологийн зөв горимын талаар мэс засалч эмч, сувилагч нарт сургалт, семинарыг зохион байгуулалттайгаар явуулснаар “Тамедин” цуврал бэлдмэлийг мэс заслын практикт бүрэн нэвтрүүлсэн гэж үзэж байна.
2. Тамедин /повидон иод/ цуврал

бүтээгдэхүүнүүд иж бүрдлээр / нам болон өндөр концентрацын уусмал, тосон түрхэц, линимент, ам зайлагч, шингэн саван / гарч байгаа бөгөөд дээрх бэлдмэлүүдийг хавсран хэрэглэснээр эмчилгээний чанарт ахиц гарч, шарх богино хугацаанд эдгэрч байна.

3. Мэс засалчийн гар халдваргүйтгэлийн шинэ технологийг практикт нэвтрүүлэхийн тулд мэс заслын гар угаах орчин үеийн ариун цэвэр техникийн хэрэгсэл, бусад зориулалтын тоноглолыг /шингэн савангийн сав, ус шүүгч, мэдрэгчтэй крант, тосгуур г.м/ суурилуулах, хангах төсөв зардлыг гаргах, захиалах ажлыг холбогдох дээд байгууллагуудад санал болгож байна.

\_\_\_\_\_

**БИОТЕРРОРИЗМ БА БИОАЮУЛГҮЙН АСУУДАЛД**

Д.Отгонбаатар, Д.Ганболд, Д.Цэрэнноров  
Зоонозын өвчин судлалын үндэсний төв

Биотерроризмын тухай ойлголт нь хүйтэн дайны үеэс бидний сайн мэдэх болсон бактериологийн (биологийн) зэвсэгтэй холбоотой юм.

Биологийн зэвсгийг эртнээс хэд хэдэн шалтгааны улмаас сонирхон судалсаар байгаа билээ. Учир нь энэ зэвсэг химийн болон цөмийн зэвсгийг бодвол үнэ өртөг хямдтай, хэрэглэхэд хялбар зэрэг давуу талтай. Хүн амын дунд дэгдэлт байдлаар тархах чадвартай халдварт өвчний үүсгэгчдийг биологийн зэвсэг болгон ашигладаг.

1346 онд Монгол Алтан ордны улсын цэргүүд Европын Каффа гэгч хотыг эзлэн авахын тулд тарваган тахлаар үхсэн цэргийнхээ цогцсыг хотын хэрмийн дээгүүр давуулан шидэж хотын хүн амыг өвчлүүлэн сүйрүүлсэн гэж түүхэнд тэмдэглэгдсэн бодит баримт байдаг[1].

Дэлхийн 2-р дайны үед АНУ-д биологийн зэвсэг бүтээх судалгаа явуулж, Мэрилэнд муж улсын Форд-Детрикт энэ судалгааны анхны томоохон төвийг байгуулж, хээрийн туршилт нь Миссисипи муж улсын Хорн-Айлендад хийгдэж байжээ. Мөн дэлхийн 2-р дайны үед бактериологийн зэвсгийг бүтээх, бэлтгэх, түүнийг үй олноор хөнөөх зэвсгийн нэг гол төрөл болгон ашиглахтай холбоотойгоор Японы милитаристууд зүүн хойд Ази, түүний дотор Монгол улсад өдүүлсэн дайндаа бактериологийн зэвсэг хэрэглэхээр манай улсын хилийн ойролцоо уг зэвсгийг бэлтгэх, хэрэглэх зориулалт бүхий тусгай анги байгуулан байршуулж, хүмүүс дээр туршилт хийж байсан түүхтэй. 1929 онд Токиод тусгай лаборатори, 1930 онд Харбинд бактериологийн зэвсэг бүтээх төвийг байгуулж, энэ нь хожмоо “Манжуурын 731-р отряд” гэж нэрлэгдсэн юм. Энэ отрядад тарваган тахал, холер, гэдэсний балнад, боом, хийт үхжил зэрэг өвчнүүдийн нянг их хэмжээгээр өсгөвөрлөж, халдвар тараах зорилгоор харх, бүүрэг зэргийг халдварлуулан хүмүүс дээр туршилт хийж байжээ.

Нацист Германд бактериологийн зэвсгийн судалгаа 1943 оноос идэвхижиж

“Бактериологийн дайн” гэсэн тусгай бүлэг байгуулж Познанд тусгай лабораторид өвчин үүсгэгч нянгуудыг өсгөвөрлүүлэн хүмүүс дээр туршилт хийж байсан хэдий ч дайны ажиллагаанд биологийн зэвсэг хэрэглээгүй байна.

Ийнхүү Дэлхийн 2-р дайнд татагдан орсон томоохон орнууд биологийн зэвсэг бүтээх, турших ажил хийж, судалгаа туршилт нь дайнаас хойш ч үргэлжилж, хүйтэн дайны ид үед ч сөргөлдөгч талууд биологийн зэвсгээр хөөцөлдөх ажил бүрэн зогсоогүй юм.

2001 онд АНУ-д боомын нянг (*Bacillus anthracis*) захидлын дугтуйд хийж тараасан биотеррорист үйлдлийн ганцхан жишээг дурьдахад хангалттай. Энэ үйлдлийн уршигаар 23 хүн уушгины хэлбэрийн боомоор өвчилж, 5 хүн нас барсан [2].

1948 онд Нэгдсэн Үндэсний Байгууллагаас биологийн зэвсгийг хүн амыг үй олноор устгах зэвсгийн төрөлд багтаасан. Сарины 300кг хий нь 200-3000 хүнийг хөнөөх чадвартай байдаг бол *Bacillus anthracis*-ын 50кг өсгөвөр нь 36000-100000 хүнд халдварлаж, 24000-100000 хүнийг үхүүлдэг [3].

1971 онд НҮБ-ын ерөнхий ассамблейн 26-р чуулганаар “Бактериологийн болон хорт нянгийн зэвсэг боловсруулах, үйлдвэрлэх, нөөцлөхийг хориглох, устгах тухай” конвенц батлагдснаар түүнд нэгдэн орсон орнууд биологийн агент, түүний хорыг урьдчилан сэргийлэх болон хамгаалах хэрэгцээнээс илүү төрөл хэмжээгээр боловсруулахгүй байх, үйлдвэрлэх, хуримтлуулах, олж авах, хадгалахгүй байх үүрэг хүлээсэн. Монгол улс энэ конвенцэд 1972 онд нэгдэн орсон.

Амьсгал боох, суулгуулах хий болон бактериологийн зэвсгийг дайны зорилгоор хэрэглэхийг хориглосон Женевийн гэрээнд 130 гаруй улс нэгдэж, гарын үсэг зурсан байна.

Орчин үед биологийн зэвсгийг цэрэг дайны болон биотерроризмын гэсэн үндсэн хоёр зорилгоор хэрэглэж байна [3] (Хүснэгт 1) .

**Хүснэгт 1.** Цэрэг дайны болон биотерроризмын зорилгоор хэрэглэгдэж болзошгүй нянгуудын төрөл зүйл

Нянгийн төрөл, зүйлүүд	
Дайны зорилгоор хэрэглэх нянгийн төрлүүд	Биотерроризмд хэрэглэх
<i>B.suis</i> <i>F.tularensis</i> Цагаан цэцэг Энцефалитын үүсгэгч Энтеротоксин В	<i>R.prowazeki</i> <i>S.typhimurium</i> <i>Shigella spp</i> Шар чичрэг ДОХ Сахуугийн хор
	<i>Bac.anthraxis</i> <i>C.burnetii</i> <i>V.cholerae</i> <i>Y.pestis</i> <i>Ebola virus</i>

**Биологийн эмгэгтөрөгч агентуудын зэрэглэл**

Мэргэжилтэнүүдийн судалгаа тооцоогоор орчин үед биологийн зэвсгийн санд байж болох эмгэг төрөгч биологийн агентуудын зэрэглэлийг (рейтинг) дараах байдлаар тодорхойлж байна. (Хүснэгт 2)

**Хүснэгт 2.** Эмгэгтөрөгч агентуудын биологийн зэвсэг болгон хэрэглэгдэх магадлалын зэрэглэл

1-р бүлэг: Өндөр магадлалтай (рейтинг>15)		2-р бүлэг: Хэрэглэж болох (рейтинг10-14)		3-р бүлэг: хэрэглэх магадлал бага (рейтинг<10)	
Тарваган тахал	23	Бруцеллөз	13	Галзуу	8
Боом	21	Япон энцефалит	13	Гэдэсний хижиг	7
Ботулизм	20	Холер	13	Цусан суулга	6
Хулгана тахал	18	Татран	13	Стафилококкт халдвар	5
Ку чичрэг	18	Сахуу	12	ДОХ-ын вирус	5
Марбург чичрэг	18				
Томуу	17				
Шүлжий	17				
Бөөсний хижиг	15				

Энэ мэтчилэн биотеррорист зорилгоор хэрэглэж болох эмгэг төрөгч биологийн агентуудын олон янзын ангилал, жагсаалт байдаг бөгөөд үүнээс хамгийн өндөр зэрэг, магадлалтайд боом, тарваган тахлын нян, вируст цусархаг чичрэгийн

үүсгэгчид тооцогдож байгаа юм.

Биологийн хөнөөгч агентуудыг ашиглан террорист үйлдэл хийхдээ хүний амьдрах орчин тухайлбал агаар, ус, хүнсний зүйлс, хэрэглээний эд зүйлсийг халдварлуулах, ялангуяа агаар дуслын замын тархах механизмыг ашиглах, ус, хүнсний зүйлийг ашиглан хоол боловсруулах замаар тархах замыг ашиглах магадлал өндөр байна. Түүнчлэн халдварлуулсан үе хөлтөн амьтныг ашиглах боломж байдаг бөгөөд энэ нь арбовирусууд, тахлын нянг ашиглан биотеррорист үйлдэл хийхэд хамаарна.

Биотерроризм нь хэд хэдэн үндсэн шинжтэй:

- Гарсан эсэхийг таних тодорхой тэмдэг байхгүй
- Нас баралт, өвчний эх уурхай, халдваргүйтгэлийн арга хэмжээг холбоход төвөгтэй
- Халдварт өвчин дэгдэлт байдлаар тархах
- Эмнэлэг, эрчимт эмчилгээний тасагт тодорхойгүй өвчтэй хүмүүс олноор ирэх
- Түүнийг байгал дээр гарсан өвчний дэгдэлтээс ялгахад төвөгтэй

Биотерроризмын үед гарсан дэгдэлтийг богино хугацааны дотор оношлох чадвартай лаборатори болон халдварын эх сурвалжийг халдваргүйтгэх, урьдчилан сэргийлэх болон эмчлэх чадвартай эмнэлгийн мэргэжлийн алба чухал шаардлагатай.

Дэлхийн улс орнуудад биотерроризмын талаар дараах арга хэмжээнүүдийг авч явуулж байна. Үүнд:

- Ихэсч буй халдварыг тандах болон оношлох лабораторитой байх
- Эмнэлгийн ажиллагсдад тусгай сургалт явуулж, урьд нь илэрч байгаагүй тохиолдлыг мэдээлэх тогтолцоотой байх
- Эмнэлгийн тусламж үйлчилгээний тогтолцоог сайжруулах (олноор нас барах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүн амын дунд зохион байгуулах)
- Яаралтай эмчлэх, сэргийлэх бэлдмэлийг богино хугацаанд тараах тогтолцоотой байх

Америкийн өвчний хяналт, сэргийлэлтийн төвийн шинэ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 21-р зууны стратеги-д биотерроризмын хариу үйлдэлд авах арга хэмжээ, хийх



үйл ажиллагаа, зорилтуудыг тусган хэрэгжүүлдэг тусгай хөтөлбөрийг тодорхойлсон байдаг [4].

Америкийн өвчний хяналт, сэргийлэлтийн төв нь дайны зэвсэг болон эмгэг үүсгэгчийн үл мэдэгдэх шалтгааныг, ер бусын үзэгдлүүдийг хурдан тодорхойлох шинэ аргаар шинжлэн судалж, алан хядлагыг номхотгох чиглэлээр ажилладаг. Энд өнөөдөр гарсан шинэ халдварт өвчнөөс маргааш яаж урьдчилан сэргийлэхийг тодорхойлж, төлөвлөх зорилгоор доорхи зорилтуудыг тавьжээ. Үүнд:

- Биотерроризмын довтолгоонд бэлэн байх, урьдчилан сэргийлэх, ажиглах
- Дэгдэлтийн үед авах арга хэмжээ, ажиллагааны тестийг боловсронгуй болгох
- Лабораторийн хүчин чадал, эм вакциныг хүрэлцээтэй байлгах
- Өвчний хяналт, эмчилгээний талаархи сургалт зохион байгуулах зэрэг болно.

Боомын нянг биотерроризмын зорилгоор ашиглахад хялбар тохиромжтой хэд хэдэн шалтгаан бий. Үүнд:

- Нян судлалын энгийн лабораторид ч хамгийн хялбар аргаар нян өсгөвөрлөн үржүүлж их хэмжээгээр гаргаж чаддаг.
- Шинжлэх ухааны орчин үеийн түвшинд хүн, малд адилхан өндөр хоруу чанар, гадаад орчинд түүний хуяглаагүй хэлбэр нь “байгалийн” омгоос илүү удаан амьд байх чадвартай нянгийн тийм омгийг тусгай лабораторид гаргаж чадсан [5].


Манай орны хувьд биотерроризмын шинжтэй үйлдэл гарахаас сэрэмжлэхэд тусгайлан анхаарах нөхцөл шалтгаан байна. Үүнд:

Хүн болоод нийгэмд аюул учруулах зэрэглэлийн хувьд нэгдүгээрт ордог тарваган тахал, биотеррорист үйлдлийн хэрэглэгдэхүүн болох хамгийн өндөр магадлалтай нян болох боом өвчний байгалийн голомт манай орны нутаг дэвсгэрт өргөн тархмал, идэвхижил өндөр байдаг, эдгээр өвчний хүн, малын өвчлөлийн тохиолдол жил бүр гарч, сүүлийн жилүүдэд өсөх хандлага ажиглагдаж байна.

Боомын байгалийн голомт манай улсын 19 аймгийн 157 сум, 1 хотын 3 дүүрэгт бүртгэгдсэн [6].

Боомын хүний өвчлөлийг Монгол улсад 1964 онд албан ёсоор бүртгэж

эхэлсэнээс хойш 2011 оны 3-р сар хүртэл нийт 271 тохиолдол бүртгэгдэж, нас баралтын хувь 7.01% (19) байна [7].



Зураг 1. Боомын хүний өвчлөлийн тархалт

Боомын хүний өвчлөлийн нас баралтыг 5 жилээр харьцуулан үзэхэд 1987-1991 онд 14.3%, 1992-1996 онд 25%, 1997-2001 онд 8.8%, 2002-2006 онд 4.4%, 2007-2011 онд 8.7% байж нас баралтын дундаж сүүлийн жилүүдэд нэмэгдсэн байна [8]. (Хүснэгт 3)

**Боомын хүний өвчлөл (1977-2011)**

Хүснэгт 3

Он	Өвчлөлийн тохиолдол	Нас баралтын тохиолдол	Хувь	Нас баралтын дундаж
1977-1981	6	0	0	0
1982-1986	4	0	0	0
1987-1991	7	1	14.3	0.2
1992-1996	4	1	25.0	0.2
1997-2001	34	3	8.8	0.6
2002-2006	91	4	4.4	0.8
2007-2011	103	9	8.7	1.8
	<b>249</b>	<b>18</b>	<b>61.2</b>	<b>3.6</b>

Зоонозын халдварт өвчин судлалын үндэсний төвийн хариуцан ажилладаг байгалийн голомтот, зоонозын халдварын үүсгэгчдийн ихэнхи нь биологийн аюулын өндөр зэрэглэлд багтдаг, тэдгээрийн 43.3% нь биологийн зэвсэг болгон ашиглах хамгийн их магадлалтай ангилалд тооцогддог[9].

Хүний өвчлөлийг улсын бүртгэл оруулсан (1926 онд тарваган тахал, 1952 онд боом, 1972 онд галзуу, 1996 онд холер, 2005 онд хачигт энцефалит, хачигт боррелиоз, 2006 онд хачигт риккетсиоз) үеэс эхлэн өвчлөлийн голомт, хариу

арга хэмжээнд лабораторийн онош зүйн тусламж үйлчилгээг үзүүлж байна [9].

Анх 1928 онд тарваганаас өсгөвөр (*Y.pestis*) ялгаснаар тарваган тахлын байгалийн голомтыг лабораторид суурилсан тандалтаар хянах эхлэл тавигдаж, 1969 онд ийлдэс судлалын шинжилгээнд улаан эст оношлуурыг хэрэглээнд нэвтрүүлсэн нь олон хэлбэрээр тандах боломжтой болсон. Түүнээс хойш молекул биологийн оношлогоонд полимеразын гинжин урвалыг 1996 оноос хэрэглээ болгож, фермент холбох урвал, хурдавчилсан сорил, дархан туяарах урвал, иммуноблотингийн урвалыг нэвтрүүлж сүүлийн 5 жилд зоонозын халдварууд ялангуяа хачгаар дамжин халдварладаг өвчнүүдийн тархалтыг хүн амын дундах тандах ажиллагаанд өргөн ашиглаж байна [9].

АНУ-д 2001 оны 9 –р сарын 11-нд болсон террорист үйл явдлын дараагаас дэлхийн улс орнууд химийн бодис, хор, халдварт өвчний нян, вирусыг ашиглан биологийн зэвсгийг хэрэглэх боломжтой тухай яригдаж байна. АНУ зэрэг зарим оронд боомын нянг захидлаар тараасан тохиолдлууд гарсан. Тус төвийн лабораторид 2008-2011 онд биологийн аюултай байж болзошгүй захидлын бүрэлдэхүүнийг шинжлүүлэхээр Тагнуулын ерөнхий газраас 8 удаа ирүүлсэн. Уг сорьц, материалыг хүлээн авч нян судлал, ийлдэс судлал, биологи, молекул биологийн аргуудаар шинжлэхэд 2 тохиолдолд боом өвчний үүсгэгч *Bacillus anthracis* –ийг илрүүлэн баталгаажуулсан. Хэдийгээр тухайн нөхцөл байдалд манай төв эдгээр шинжилгээг хийсэн боловч Монгол улсад ийм төрлийн биотерроризмын сэжигтэй материалыг хүлээн авах, шинжлэх, баталгаажуулах тогтолцоо бүрдээгүй байгаа нь эдгээр тохиолдлуудад ажиглагдсан ба тус төвийн ажилтнуудад ч эрсдэлтэй байж болзошгүй байсан.

#### Дүгнэлт:

Биотерроризмын ажиллагаанд нөлөөлж болох эмгэг төрөгч бичил биетнийг судлах асуудлыг Монгол улсад бодит ажил болгон хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Нөхцөл байдлын үнэлгээ хийж дүгнэлт

өгөх

- Шаардлагатай судалгааг холбогдох байгууллагууд хамтран гүйцэтгэх
- Оношлох, шинжлэх, судлах, эмчлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм, оношлуур урвалж, бодисын хангалтын тогтолцоог бүрдүүлж лабораторийг бэхжүүлэн тайван цагийн байдлаас болзошгүй эрсдлийн үед ажиллахад бэлэн байлгах
- Олон нийтэд шаардлагатай мэдээлэл өгөх
- Биотерроризмын аливаа эрсдэлтэй тохиолдолд хариу арга хэмжээ авах, бэлэн байх нөхцлийг бүрдүүлэх

#### Ашигласан ном зүй:

1. Нямдаваа.П, “Вакцин” хэмээх ээлтэй үхэржин, 2004.Улаанбаатар. Х. 9
2. “АНУ-д гарсан боомын өвчлөлийн талаар” БГХӨСҮТ, Мэдээлэл-37/2002 он
3. Эрдэнэчимэг.Л, “Биотерроризм” Хүрээлэн буй орчны эрүүл мэнд-зоонозын халдвар. 2003. Улаанбаатар. Х. 91-94
4. “Биотерроризмийн тухай” Мэдээлэл, 34/2000 он
5. Оюунгэрэл.Л, Дэлгэр.Т нар “Боом” Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл-2008 №1 [20] Улаанбаатар; Х. 15
6. Бурмаа.Х, Дармаа.М нар “Байгалийн голомтот зарим халдварт өвчний тархалт” Хүрэл тогоот-2011 Улаанбаатар; 2011, Х. 46-50
7. Уянга.Б, Долгорханд.А нар “Монгол дах боомын эрсдэлийн судалгаа” Хүрэл тогоот-2011 Улаанбаатар; 2011, Х. 109-113
8. Уянга Б., Солонго Ч., Долгорханд А. нар “Боом өвчний эрсдэлийн үнэлгээний дүнгээс, 1964-2011, Монгол улс” Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл-2012 №2 [45] Улаанбаатар; Х. 2-10
9. Дуламжав.Ж, Мягмар.Ж нар “Зоонозын халдварт өвчний оношлогооны лабораторийн үйл ажиллагааны өнөөгийн байдал” Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл-2011 №5 [42] Улаанбаатар; Х. 15-18

Уншиж танилцан,  
нийтлэхийг зөвшөөрсөн  
АУ-ны доктор, дэд профессор  
Р.Оюунгэрэл

## ТАМЕДИН® (ПОВИДОН ИОД) ЦУВРАЛ БЭЛДМЭЛИЙГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

Монхимо ЭШТТ

Мэсзасалчийнгарынхалдваргүйтгэлд, Мэс засал, хатгалт, тарилгын талбай бэлтгэх, Мэс заслын болон гэмтлийн бүх төрлийн шархны халдваргүйтгэлд, нүд/ чихний дусаалга хэлбэрээр, амны хөндий, шүд, буйлны үрэвсэл, ангина, хамрын хөндийн шархлаа, үрэвсэл, гаморойт, томуу, томуу төст өвчний үед, үтрээний үрэвсэл, ба халдваргүйтгэлд, арьсны нянгийн гаралтай идээт үрэвсэл, батга, хатиг, мундас, мөөгөнцөр, үлд, хагжилт зэрэг арьс салстын бүх төрлийн халдваргүйтгэлд угаах, зайлах, арчих, шавших, тампон тавих, боолт тавих хэлбэрээр Тамедин цуврал бэлдмэлийг сонголтоор хэрэглэнэ.

**Гарын халдваргүйтгэл:** Мэс заслын болон түүнтэй дүйх ажилбарын өмнө ба хойно Тамедин 7.5% шингэн саванг гарын халдваргүйтгэлд хэрэглэнэ. Хэрэглэх арга: Мэс заслын гарын халдваргүйтгэлд 5мл шингэн саванг ариун сархинцаг, пролонд шингээж, цагаан хөөс үүстэл, мэс заслын гарын халдваргүйтгэлийн ерөнхий дүрэм, аргачлалыг баримтлан, 3 минутад угаана. Харин амбулоторийн гар угаалгыг 1-2мл шингэн савангаар 1 минутын хугацаанд гүйцэтгэнэ.

**Мэс заслын талбай бэлтгэх:** Мэс мэс ажилбар хийх талбайд дараах 2 аргын тухайн үеийн нөөцийн боломжтой хэлбэрийг сонгож хэрэглэнэ.

1. Мэс ажилбар хийх талбайд Тамедин 7.5% эсвэл Тамедин 10% уусмалын аль нэгийг сонгож, хөвөн бөмбөлөгт шингээж, 20см<sup>2</sup>-талбайд 3 мл хэмжээтэй уусмал ноогдохоор тооцож мэс заслын талбай бэлтгэх дүрмийн дагуу 2 удаа түрхэж, арчих ба 3 минутын дараа мэс ажилбарыг эхлэнэ.

2. Өвчтөний биеийн хэсэг газрыг ариутгасан нэрмэл ус эсвэл 0.9% натрий хлоридын уусмалаар арчиж, биеийн арьсан дээр усан бөмбөлөг мөр үүсгэнэ. Дараа нь Тамедин 7.5% шингэн саванг үл мэдэг чийгтэй, ариун сархинцаг, пролонд шингээж, мэс ажилбар хийх талбайн хэсгийг цагаан хөөс үүстэл 3 минутын хугацаанд сайтар угааж халдваргүйтгэсний дараа ариун самбай, материалаар хөөсийг арилгана. Дараа 20см<sup>2</sup>-талбайд 3 мл хэмжээтэй уусмал

ноогдохоор тооцож Тамедин 5% уусмалыг түрхэх ба 3 минутын дараа мэс ажилбарыг эхлэнэ.

**Нүдний мэс заслын талбай бэлтгэх:** Зөвхөн нүдний мэс засалд тусгайлан бэлтгэсэн Тамедин 5% нүдний дусаалгыг хэрэглэнэ. Нүдний мэс заслын талбайг бэлтгэхдээ эхлээд зовхи, хөмсөг хэсгийн арьсыг эхэлж халдваргүйтгэж бэлтгэсний дараа нүдэнд 3 дуслаар дусааж 3 минутын дараа ариун нэрмэл усаар гадагш урсган зайлж, мэс ажилбар эхэлнэ.

**Хатгалтын талбай бэлтгэх:** Хатгалт хийх талбайг эхлээд ариун нэрмэл ус эсвэл 0.9% натрий хлоридын уусмал шингээсэн самбайгаар арчиж, арьсыг чийгшүүлсний дараа Тамедин 5% уусмалыг 20см<sup>2</sup> талбайд 3мл тунгаар тооцож, самбайнд шингээж, 2 удаа давтан арчиж, халдваргүйтгэснээс хойш 3 мин дараа ариун нэрмэл ус эсвэл 0.9% натрий хлоридын уусмал шингээсэн самбайгаар иодын үлдэгдэл мөрийг шингэрүүлж, арчсаны дараа хатгалтыг эхлэнэ.

**Тарилгын талбай бэлтгэх:** Тамедин 5% уусмалыг 1мл тунгаар тооцож ариун самбай, бөмбөлөгт шингээж, тарилгын талбай бэлтгэх ерөнхий дүрмийн дагуу 15-20сек хугацаанд сайтар арчиж, халдваргүйтгэсний дараа тарилгыг хийнэ.

**Шархны халдваргүйтгэл:** Мэс заслын болон гэмтлийн шархны халдваргүйтгэлд Тамедин цуврал бэлдмэлийг хэрэглэх ба шархны байдал, төрөл, эмзэг байдлаас шалтгаалж хэргэлэх заалт, хэлбэрийн сонголт өөр байдаг.

**Хөнгөн хэлбэрийн шархыг халдваргүйтгэх:** Энэ хэсэгт мэс заслын анхдагчаар эдгэрч буй шарх болон түлэнхийн I, II -р зэрэгт хамаарагдах шарх, зулгарсан, зүсэгдсэн зэрэг гэмтлийн шинэ шарх хамаарах ба Тамедин нам конц. бүлгийн 0.7%, 1% уусмалыг ил шархыг халдвараас урьдчилан сэргийлэх, идээлсэн, үрэвссэн шархыг эмчлэх, халдваргүйжүүлэх зорилгоор цэвэрлэх, угаах, шавших, боолт хийх байдлаар хэрэглэх нь тохиромжтой. **Тамедин нам концентрацит уусмал болон линиментийг хэрэглэхийн учир нь:**

- Эрүүл, гэмтэл аваагүй арьсанд Повидон иодын найрлага дахь иодын

задрал удаан явагддаг бол гэмтсэн арьс болон салстын орчинд иодын чөлөөлөгдөх хэмжээ ихсэж, өндөр тунгаар, удаан хугацаагаар хэрэглэсэн тохиолдолд иодын кумилияци үүсэх магадлал өндөр байдаг.

-Повидон иодын нам конц. уусмалын нэгж хугацаанд чөлөөлөгдөх иодын хэмжээ, задралын хурд өндөр концентрацит уусмалаас их байдаг.

-Тамедин нам концентрацит уусмал болон линимент нь үрэвслийн эсрэг үйлчлэлээр өндөр концентрацит уусмалаас (24 % / 60 ) онцын ялгаагүй болох нь ЭМШУИС-ийн Эм судлалын тэнхмийн лабораторид /2206-2007он/ хулгана, туулайд явуулсан фармокологийн судалгаагаар тогтоогдсон.

**2. Хүнд хэлбэрийн, ужигарсан идээт шархыг халдваргүйтгэх:** Энэ хэсэгт мэс заслын халдварласан шарх, болон түлэнхийн 3, 4-р зэрэгт хамаарагдах шарх, хөхний идээт үрэвсэл, ясны идээт үрэвсэл, хатиг, буглаа, шамбарам, холголт, цооролтын шарх хамаарна. Дараахь 3 аргаар шархны цэгцэлгээг явуулна.

-Тамедин 2.5 % -5% уусмалаар дангаар хэрэглэж, шархыг угаах, шавших, боолт хийх

- Эхлээд шархыг нэрмэл усаар юмуу, 0.9 давсны уусмалаар норгосны дараагаар Тамедин шингэн саванг ариун салфеткад шингээж, шархтай хэсгийг 3 минут цагаан хөөс үүстэл, даралттай бус хөдөлгөөнөөр хөөсөртөл угааж, 0.7%-ийн тамедин уусмалаар зайлна. Хэрэв шарх үнэртэй, их хэмжээний идээ, үхжиллийн голомттой, ужигарсан шархыг 2-3 удаа угаах бөгөөд угаалга бүрийн дараа хөөсийг усаар зайлна. Харин сүүлийн угаалгын төгсгөлд Тамедин нам конц. уусмалаар зайлсны дараа уг уусмалаар

эсвэл Тамедин линимент, тосон түрхлэг аль нэгээр боолт хийнэ.

-Шархны байдлаас шалтгаалж Тамедин 2.5% -10% уусмалын аль нэгийг сонгон авч, устөрөгчийн хэт ислийн 3% уусмалтай 1:1 холимог уусмал бэлтгэн шархыг угаах, шавших, тампон тавих аргаар халдваргүйтгэнэ. Энэ холимог уусмалыг хэрэглэх үед индикатор шинжээр шархны цэвэршилтийг таних боломжтой ба шүршиж угаагаад, хөөсрөлтийн байдал, өнгө хувиралыг харна. Хэрвээ уусмалын хүрэн өнгө алдагдах, шаргал эсвэл цайвар өнгөтэй хөөс үүсч байвал шарх идээт үрэвсэл ихтэй болохыг харуулна. Эхний угаалга, цэвэрлэгээгээр дээрхи шинж илэрч байвал угаалгыг хэд хэдэн удаа давтан хийж, уусмалын хүрэн өнгө алдагдахгүй, хөөс үүсэхгүй болтол үргэлжлүүлэн давтан угаана. Мөн тампон тавьж болох ба 1 удаагийн чихээс хийх хугацаа 3 минут үргэлжлэнэ.


**Тамедин: устөрөгчийн хэт ислийн холимог уусмалаар халдваргүйжүүлэх:** Энэ арга нь шархыг цэвэршүүлэх, үнэр дарах, эдгэрэлтийг түргэсэх сайн арга бөгөөд зөвхөн шарх угаах тэр үед л шууд бэлтгэж хэрэглэнэ. Хэрвээ холимог уусмалын үлдэгдэл байвал таглаатай саванд хадгалж болохгүй. Хадгалсан тохиолдолд 100 минутын дараа онгойлгоход тэсрэх аюултай тул үлдэглийг хадгалж болохгүй.

**Гэмтлийн шархны яаралтай тусламжийн халдваргүйтгэлд:** Эмч, эмнэлгийн ажилтнууд, халдвартай материалтай ажилладаг лабораторын ажилтнууд зүсэгдэх, зулгарах, хатгагдах зэрэг гэмтэл авах үед, болон ахуйн ослоор зүсэгдэх, зулгарах зэрэг шарх үүссэн тохиолдолд Тамедин 5% уусмал-багстай түрхлэгээр шархыг цэвэрлэж боолт хийнэ.



### 007. ЛЕЙШМАНИАЗ (LEISHMANIASIS)

Лейшманиаз өвчин нь *Leishmania* бүлгийн хэд хэдэн зүйлийн эгэл биетнээр үүсгэгддэг арьсны (*cutaneous and mucosal Leishmaniasis*) дотор эрхтний (*visceral Leishmaniasis*, Кала-азар-хар өвчин, халуун орны спленомегалия (*tropical splenomegaly anaemia splenica infantum*), Сернарийн өвчин, Сагибагийн өвчин, Бардвен халуурал (*Burdivan*), Дум-Дум халуурал (*Dum-dum fever*) хоёр янзын хэлбэр байдаг [1]. Шотландын эмгэг анатомич, Английн цэргийн эмнэлгийн дэслэгч генерал Уильям Буг Лейшманы (*William Boog Leishman*, 1865 —1926 он) нэрээр нэрлэсэн эпоним нэр томъёо юм. *Leishmania* бүлгийн эгэл биетнүүд нь хүн болон бусад сүүн тэжээлтний эс дотор шимэгчлэн амьдардаг. Халдвар хадгалагч амьтныг хазсан цус сорогч эм шумуулаар дамжин тархана.




Зураг 3. Лейшманиазын дотрын ба арьсны хэлбэр

Эм шумуул халдвар авсан сүүн тэжээлт амьтны цусыг сорсны дараа хөдөлгөөнтэй промастиготууд шумуулын гэдсэн дотор үржиж олширно. 8-20 хоногийн дараа халдварлуулах чадвар бүхий шимэгч болон бие гүйцээд шумуул дахин өөр амьтныг хазгах үед түүний цус руу орно. Хүн болон бусад сүүн тэжээлтний цусанд орсон шимэгч макрофагт залгигдан амастигот хэлбэрт шилжинэ. Улмаар эс дотор үржиж олшроод, эсийг гэмтээн задалж, дараагийн макрофаг эс рүү ордог байна. Мөн эмийн бэлдмэлийг судсаар хууль бус хэрэглэдэг лейшманиаз ба ХДХВ-ийн хавсарсан халдвартай хүмүүс тариураа дундаа хэрэглэснээс болж халдвар хүнээс хүнд дамждаг. Хавсарсан халдвартай өвчтөн шумуулыг халдварлуулдаг учраас зооноз халдварын голомтонд хүн халдвар хадгалагч болдог ажээ [2].

**Арьсны хэлбэр:** Өвчин эхлэхдээ арьсан дээр толбо гарч улмаар гүвдрүү болтлоо томроод нянгийн халдвар хавсрахгүй бол хөндүүргүй яр болон хувирна.

**Дотор эрхтний хэлбэр:** Системийн архаг өвчин. Халуурах, элэг дэлүү томрох, тунгалгийн булчирхай цочих, цус багадах, цагаан эсийн тоо цөөрөх, тромбоцитопени, эцэж турах, ядарч сульдах шинжүүд илэрнэ. Эмнэлзүйн илрэл бүхий тохиолдлыг эмчлэхгүй бол үхэлд хүргэнэ. Халууралт нь аажим, эсвэл гэнэт эхэлж болно. Байнга, эсвэл үе үе халуурна, хоногт 2 удаа халууралт дээд цэгтээ хүрээд бусад үед халуунгүй, эсвэл бага зэргийн халуунтай байна. Системийн өвчнийг эмчилсний дараа Кала-азарын дараах арьсны эмгэг үүсэх явдал Судан улсад (дотор эрхтний лейшманиазын 50 хүртэл хувь) түгээмэл



Зураг 1. Лейшманиазын үүсгэгч эгэл биетэн



Зураг 2. Лейшманиазыг дамжуулагч шумуул

тохиолддог. Лейшманиаз, ХДХВ-ийн хавсарсан халдвар өмнөд Европод нилээд их байдаг бөгөөд сүүлийн үед Ази болон Зүүн Африкт хавсарсан халдвар сэргэж байна.

Арьсны хэлбэрийн үүсгэгч – Дэлхийн зүүн тал бөмбөрцгийн газар нутагт *Leishmania tropica*, *L. major*, *L.aethiopica*, баруун тал бөмбөрцгийн газар нутагт *L. braziliensis* ба *L. Mexicana* бүрдэл. *L. braziliensis* бүрдлийн гишүүд нь салстын, *L. tropica* нь арьсны лейшманиазыг тус тус үүсгэнэ. *L. donovani* бүрдлийн гишүүд дэлхийн зүүн тал, *L. infantum/chagasi* – баруун тал бөмбөрцгийн газар нутагт тус тус дотор эрхтэний лейшманиаз үүсгэнэ. Тэрхүү хоёр зүйл хоёулаа дотор эрхтэнийг гэмтээлгүйгээр арьсны лейшманиаз ч бас үүсгэх нь бий [3-4].

Арьсны хэлбэрийн тархалт: Жилд 2 сая шинэ тохиолдол бүртгэгддэг: Хятад (саяхнаас), Энэтхэг, Пакистан; Афганистан, Иран зэрэг баруун өмнөд Азийн орнууд; Хуучин Зөвлөлт Холбоот Улсын өмнөд мужууд; Газрын дундад тэнгис; Африкийн Сахаарын халуун бүс нутаг ба Судан, Этиоп, Кени, Намибын уулархаг газар нутаг; Доминикан улс, Мексик (ялангуяа Юкатан), Төв ба өмнөд Техас; Төв Америк; Чили ба Уругвайгаас бусад өмнөд Америкийн бүх улс орнууд. Австралийн имжээс лейшманиа илэрсэн тухай саяхны мэдээлэл байдаг. *L.infantum/chagasi*-гээр үүсгэгдэх арьсны хэвшинжит бус лейшманиазын өвчлөл сүүлийн жилүүдэд төв Америк тэр дотроо Хондурас, Никарагуад нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Мексик болон Доминикан улсад арьсны тархмал лейшманиазын олон тохиолдол бүртгэгдэж байжээ.

Дотор эрхтний хэлбэрийн тархалт: Дэлхийн 62 оронд бүртгэгдсэн бөгөөд жилд 500 000 хүн өвчилдөг, 120 сая хүн өвчлөх эрсдэлтэй ажээ. Бангладеш, Хятад, Энэтхэг, Балба, Пакистан, хуучин ЗХУ-ын өмнөд мужууд, Дундад Дорнод (Турк), Газар дундын тэнгис, Мексик, төв болон өмнөд Америк (Бразил)-ийн голомт, Этиоп, Кени, Судан, Уганда болон Африкийн сахаар орчмын газар нутагт тус тус өвчин тохиолдоно. Өвчлөл бүртгэгддэг газар нутагт нярай, бага болон өсвөр насны хүүхдүүд алаг цоог хэлбэрээр, зарим үед эпидеми маягаар өвчилдөг. Хумхаатай тэмцэх зорилгоор шавьж устгалын бодис хэрэглэсэн. Цас ороход өвчлөл багасч байжээ. Золбин

нохойн тоо цөөрөхөд Хятадад хүний өвчлөл дагаад буурч байжээ.

Паразитологийн оношлогоо нь: Биопсийн материал, соруулж авсан шингэнээс үүсгэгч организмыг өсгөвөрлөн гаргаж авах, эсвэл ясны чөмөг, дэлүү, элэг, тунгалгийн булчирхай, цуснаас бэлдсэн түрхцэнд эс доторх амастиготыг илрүүлэн харах аргууд дээр үндэслэнэ. ХДХВ-ийн хавсарсан халдвартай тохиолдолд цусыг шинжлэх нь илүү үр дүнтэй байна. ПГУ нь хамгийн мэдрэг боловч өртөг өндөртэй арга юм. Мөн Монтенегрогийн арьсны сорил тавьдаг. Энэхүү сорил нь идэвхгүйжүүлсэн үүсгэгчийг арьсан дор тарьхад эсрэг бие үүсэн бие махбодид харшлын урвал өгдөг. Сорил тавьснаас нэг хоногийн дараа бугалганд 1 см ихэвчлэн 5-6 см хэмжээтэй арьс улайж хавагнадаг. Мөн зарим хүнд 1-2 хоног 38-39 хэм хүртэл халуурч, толгой өвдөх, бөөлжис цутгах, бие эвгүйрэх шинж тэмдэг илрэдэг байна [5].

Арьсны хэлбэрийн нууц үе: Доод тал нь долоо хоног. Хэдэн сар ч үргэлжилж болно. Дотор эрхтний хэлбэрийн нууц үе: Дунджаар 2-6 сар, 10 хоногоос хэдэн жил хүртэл хугацаанд хэлбэлзэж болно.

Халдвартай байх хугацаа – Хүнээс хүнд шууд халдварлахгүй хэдий ч өвчтэй хүнийг эмчлээгүй үед гэмтсэн арьс салстан дээр шумуул суух боломжтой хугацааны туршид буюу хэдэн сараас 2 жил хүртэлх хугацааны туршид халдварыг бусдад тараах эрсдэлтэй. Ихэнх тохиолдолд яр аажимдаа өөрөө хатдаг. *L.amazonensis*, *L.aethiopica*-гийн халдвар авсан цөөн өвчтөний гэмтсэн арьсанд олон тооны лейшманиаз байршдаг учраас яр өөрөө хатдаггүй. *L.braziliensis* бүрдлээр үүсгэгдсэн яр ихэвчлэн аажимдаа өөрөө хатдаг боловч маш цөөхөн (3-5%) хувь нь хэдэн сар жилийн дараа салстын лейшманиаз болдог.

Өртөмтгий байдал – Арьс, дотор эрхтний хэлбэрээр бүх хүн өвчлөх боломжтой. *L.tropica* ба *L. major*-оор үүсгэгдсэн яр хатсаны дараа насан туршийн дархлаа тогтох боловч тэр нь бусад зүйлийн лейшманиазын халдвараас хамгаалахгүй. Өвчин эдгэрэхдээ арьс салст зэрэмдэг болгоход нөлөөлдөг хүчин зүйлсийг бүрэн судлаагүй байна. Анх халдвар авснаас хойш хэдэн жил өнгөрсөн ч гэсэн нууц халдвар дахин сэргээж болно. Дархлаанд эсийн дархлааны хариу

урвал голлох үүрэгтэй.

Дотор эрхтний хэлбэр: Кала-Азараар өвдсөний дараа удаан хугацааны дархлал тогтоно. Шинж тэмдгийн илрэлгүй, эсвэл бүдэг балархай хэлбэрээр өвчлөх нь түгээмэл. ДОХ-той өвчтөнд лейшманиаз өвчний шинж тэмдэг тод илэрдэг нь далд халдвар идэвхжсэнтэй холбоотой байж болно [2].



**Зураг 4.** Баруун гараас: Дэслэгч генерал Уильям Буг Лейшман, Ч

Уг өвчний үүсгэгчийг 1901 онд Уильям Буг Лейшман “Кала-азар”-аар нас барсан өвчтний нойр булчирхайг судалж байгаад “Зууван-дугуй” эсийг илрүүлж 1903 онд энэ тухайгаа эрдэм шинжилгээний бүтээлд хэвлүүлжээ. Мөн Италын эмч Ч Лейшманаас хамаарахгүйгээр мөн “Кала-азар”-аар өвчилсөн хүнээс илрүүлсэн байна. Иймээс Лейшман-Донованын эгэл биет гэж нэрлэдэг байна. Лейшмана-Донованын эгэл биетнээр үүсгэгддэг өвчнүүдийг Лейшманиаз гэж ерөнхийд нь нэрлэдэг ажээ [6].



Халуун хумхаа өвчний шалтгаан үүсгэгч, дамжуулагчийг анхтодорхойлсон, анагаах ухааны чиглэлээр 1902 онд Нобелын шагнал хүртсэн Английн эрдэмтэн Энэтхэгийн Алморе (Балба)-д Английн армийн офицерын гэр бүлд төрсөн Рональд Росс (1857-1932) тодорхойлж Уильям Буг Лейшманы нэрээр нэрлэсэн байна. Лейшманы Кала-азараар нас барсан өвчтнөөс тодорхойлсон “Зууван-дугуй” эгэл биетний талаар

бичсэн эрдэм шинжилгээний өгүүллэг нь уг өвчнийг түүний нэрээр нэрлэх үндэс болжээ [7; 8].

Дэслэгч генерал Уильям Буг Лейшман 1865 онд Г хотод төрж Вестминстерскийн дунд сургууль, Г хотын их сургууль төгсч Хааны армийн цэргийн хороонд ажиллаж Энэтхэгт алба хаажээ. Тэнд балнад, Кыыг судалсан байна. 1897 онд Англид эргэн ирж Н хот дахь Викторийн эмнэлэгт ажиллав. 1900 онд Цэргийн эмнэлгийн сургуулийн эмгэг судлалын профессорын туслахаар ажиллах хугацаандаа хумхаа өвчний плазмод бусад шимэгчээр дамжин үүсгэгддэг өвчнүүдийг будаж **Зураг 5. Нобелын шагналт Рональд Росс** олох аргуудыг тодорхойлж байв. М э Романовскийн будгийн хувилбар нь олонд «Лейшманы будаг» гэж нэрлэгдсэн байна. Лейшман Африканскийн хачигт халуурал өвчнийг үүсгэгч *Spirochaeta duttoni*-ийн амьдралын мөчлөгийг судалсан мөн Арын хамт балнадын вакцин бүтээсэн байна. 1923-1926 онд Английн армийн эмнэлэг албаны даргаар ажиллаж байгаад нас баржээ [7].

Монгол Улсын Зэвсэгт хүчний офицерууд 2002 оноос цэргийн ажиглагчийн үүргийг, Цэргийн багууд 2003 оноос НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаа болон олон улсын цэргийн ажиллагаанд амжилттай оролцож ирлээ [9; 10]. Монгол цэрэг Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон 10 жилийн хугацаанд 5800 шахам цэргийн алба хаагчид халуун орны халдварт өвчнүүдийн голомтот нутагт алба хаасан бөгөөд халуун хумхаа өвчнөөр өвчилсөн тохиолдол ч бүртгэгдсэн байна. Одоо Өмнөд Судан улсад явагдаж буй НҮБ-ын Энхийг дэмжих ажиллагаанд 850 хүнтэй Цэргийн томоохон баг ажиллаж байгаа бөгөөд Өмнөд Судан нь “Кала-азар” өвчний голомтот нутаг бөгөөд манай цэргийн болон халдвартын эмч мэргэжилтнүүд даярчлалын зуунд халуун орны халдварт өвчнөөс сэргийлэх, оношлох, эмчлэх мэдлэгээ нэмэгдүүлэх нь нэн шаардлагатай үе боллоо.

#### Ашигласан бүтээл

[www.doctoribolit.ru/?go=Tropical/Tropical](http://www.doctoribolit.ru/?go=Tropical/Tropical)

1. “Халдварт өвчний хяналтын лавлах” Арваннайм дахь хэвлэл (2010); Редактор: Дэйвид Л.Хэйманн Монгол

- хэл дээрхи анхны хэвлэл. Орчуулгын редактор: Махбал овогт П.Нямдаваа. Америкийн Нийгмийн Эрүүл Мэндийн Холбоо, Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Монголын Анагаах Ухааны Академи. Улаанбаатар хот. 268-272 тал.
2. Д.Содбаяр, Л. Энхбаатар (2004); Шимэгчдээр үүсгэгдэх халдварын тархвар зүй, хяналтын дэлхий дахины өнөөгийн төрх байдал *Халдварт Өвчин судлал сэтгүүл №1*
  3. Л.Энхбаатар (2007); “Анагаах ухааны паразит судлалын товч түүх” Редактор: Д.Галбадрах. Улаанбаатар хот, “ADMON” хэвлэлийн газар
  4. [www.encyclo.co.uk/define/Montenegro%20test](http://www.encyclo.co.uk/define/Montenegro%20test)
  5. <http://ru.wikipedia.org/wiki>
  6. <http://www.nobeliat.ru/laureat.php?id=224>
  7. <http://www.calendar.ru/person/2218/>
  8. <http://www.mongolnews.mn/i/29255>
  9. <http://gsmaf.gov.mn/2012-04-02-10-52-58/108-өмнөд-суданыг>

Сэтгүүлийн эрхэлсэн  
нарийн бичгийн дарга,  
АУ-ны доктор Л.Энхбаатар



*Монголын эрүүл ахуйн шинжлэх ухааныг үндэслэгч  
Ч.Чүлтэмдоржын мэндэлсний 85 насны ойд зориулав.*

## МОНГОЛЫН ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖЛЭХ УХААНЫГ ҮНДЭСЛЭГЧ Ч.ЧҮЛТЭМДОРЖ



Монголын анагаах ухаанд зайлшгүй тэмдэглэгдэн үлдэх хүн бол манай эрүүл ахуйн шинжлэх ухааны анхны эрдэмтэн Чүлтэмийн Чүлтэмдорж билээ. Ч.Чүлтэмдорж нь 1928 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Ивэнгийн голд

Амарбаясгалан хийдэд шавилан сууж байсан лам Найдангийн хүү болон мэндлээд Хушаат сумын Чүлтэмийнд үрчлэгдэн өсчээ. Түүний төрсөн Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумаас анагаах ухааны их сургуулийн анхны ректор, гавъяат багш, шинжлэх ухааны доктор, профессор Д.Балдандорж, академич Б. Дэмбэрэл, П.Нямдаваа, профессор А.Гүрдорж, их эмч П.Очирбат зэрэг томоохон эрдэмтэд төрсөн түүхтэй [1]. Ч.Чүлтэмдорж бага сургуулиа төгсөөд 1942 онд Улаанбаатар хотноо шилжин ирж жанжин Сүхбаатарын нэрэмжит цэргийн дунд сургуульд орж 1949 онд төгсчээ.



**Офицерын сургуулийнхан МУИС-ын анагаах ухааны факультетын оюутнууд болов.** Баруун гараас: Ирээдүйн анагаах ухааны доктор Ч.Чүлтэмдорж, төрийн соёрхолт ардын уран зохиолч С.Эрдэнэ, анагаах ухааны доктор А.Дамдинсүрэн нар. Сонсогч Ч.Чүлтэмдорж

Офицерын сургууль бол 1943 онд маршал Х.Чойбалсангийн санаачлагаар Оросын Суворовын нэрэмжит цэргийн сургуулийн туршлагаар байгуулагдсан, ерөнхий боловсролоос гадна цэргийн эрдэм, бие бялдрын хүмүүжил, хатуужил гэсвэр, зориг самбаа, эх оронч хүмүүжлийг эзэмшүүлсэн Хувьсгалч армийн залуу халааг бэлтгэх 10 жилийн сургууль байжээ [2]. Ч.Чүлтэмдорж офицерын сургуульд сурч байхдаа орос хэл, шугам зурагт сайн, өндөр гуалиг биетэй, өтгөн хар хөмсөг, дөлгөөн харцтай, том алаг нүдтэй, цэвэрхэн хувцасладаг, зураг зурдаг, гитар, гармони, баян хуур хөгжим тоглодог, хүнтэй танилцахдаа амархан, яриа хөөрөөтэй орос хэлийг гаргууд эзэмшсэн, дэлхийн сонгодог зохиолуудыг унших дуртай үе тэнгийн охидууд их л сонирхон гүйлддэг залуу байсан гэдэг [3]. Тэр үед домогт офицерын сургуулийг төгсөгчид эх орны батлан хамгаалах, хөдөө аж ахуй, соёл урлаг, зам тээвэр, үйлдвэр, эрүүлийг хамгаалах салбаруудад тэргүүний манлайлагчид болон хүмүүжжээ. Тухайлбал: Цэрэг армийн шилдэг офицерүүд дэслэгч генерал Л.Моломжамц, Ч.Пүрэвдорж, хошууч генерал Д.Гэндэнпил, Д.Бямбаа, С.Гомбосүрэн, С.Гангааням, С.Санжмятав, хурандаа Л.Жамъян, Б.Тавхай, Б.Арслан, Л.Намдаг шинжлэх ухаан, урлаг соёлын салбараас нэрт гүн ухаанч, академич Ч.Жүгдэр, Д.Давгадорж, төрийн соёрхолт доктор Х.Тумбаа, эдийн засгийн ухааны доктор Б.Бирваа, Н.Чулуундорж, гавъяат жүжигчин С.Цэрэндаш, Р.Батсайхан, урлагийн гавъяат жүжигчин Б.Равсал, гавъяат багш Ц.Лантуу, Монгол улсын урлагийн гавъяат зүтгэлтэн төрийн соёрхолт, хөгжмийн зохиолч Г.Бирваа, П.Хаянхирваа, бүжиг дэглэгч Б.Жамъяндавга, М.Цэрэндорж, гавъяат тамирчин, багш Р.Зориг, Л.Чимэддорж, Б.Даш хөдөлмөрийн баатар Г.Мандах, Ц.Чойжил, О.Гүндсамбуу, гавъяат тээвэрчин Д.Банзрагч, нисгэгч Д.Чодин, онц бүрэн эрхт элчин сайд Г.Дашдаваа,

Г.Нямдоо, хүний гавьяат эмч, доктор профессор Н.Гэндэнжамц, Ч.Бадарч, Ж.Аминдаваа, П.Шагж, Р.Гүр, Б.Од, С.Сүндэв, ардын уран зохиолч, төрийн соёрхолт С.Эрдэнэ, эрүүл мэндийн сайд, ардын эмч, гавьяат багш, доктор, профессор Ч.Цэрэннадмид, гавьяат багш, профессор Т.Батсүх, шинжлэх ухааны доктор, профессор А.Өлзийхутаг, ардын эмч, төрийн соёрхолт Ж.Хайруулла, Г.Лхагважав, гавьяат эмч Б.Бумбага, Д.Цэнд-Аюуш, гавьяат багш, профессор Ц.Цэрэндагва, эрүүл мэндийн яамны орлогч сайд М.Шагдарсүрэн, эрүүлийг хамгаалахын дэд сайд, эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, доктор Г.Дашзэвэг, эрүүл мэндийн орлогч сайд, доктор Ш.Жигжидсүрэн гээд дурьдаад байвал маш олон алдартныг дурьдаж болно [4].



**МУИС-ын анагаах ухааны факультетын нэг ангийнхан.** Дээд эгнээнд: Баруун гараас Ж.Лхан-Аажав (эм зүйч, багш), Майяа, ....., Н.Гэндэнжамц (хүний гавьяат эмч, доктор профессор, хожим Эх Хүүхдийн Эрдэм Шинжилгээний төв түүний нэрэмжит болжээ). Доод эгнээнд зүүн гараас: Ч.Чүлтэмдорж (Монголын эрүүл ахуйн анхны эрдэмтэн), А.Дамдинсүрэн (анагаах ухааны доктор), С.Эрдэнэ (ардын уран зохиолч, төрийн соёрхолт), Ц.Хайдав (уламжлалт анагаах ухааны эрдэмтэн, академич, доктор профессор).

Ч.Чүлтэмдорж офицерын сургуулийг төгсөөд Монгол Улсын их сургуулийн Хүн эмнэлгийн факультетэд суралцан 1954 онд төгсчээ. Энэ үед Монгол Улсын эрүүлийг хамгаалах салбарт хүн амыг арьс өнгөний халдварт өвчнөөс эрүүлжүүлэх ажил тулгамдсан асуудлын нэг болж байв. Залуухан эмч Ч.Чүлтэмдоржийг энэ ажил албанд Хөвсгөл, Сэлэнгэ хоёр аймгийг хариуцсан отрядын ерөнхий эмчээр тохоож,

улмаар аймгийн Эрүүлийг хамгаалах хэлтсийн даргаар томилон ажиллуулсан нь эмчийн болон зохион байгуулах ажлын арга барилд суралцах, дадлага туршлага хуримтлуулахад нь ихээхэн тус нэмэр болсон байна. Ажил үүргээ амжилттай биелүүлсэн түүнийг 1956 онд ЗХУ-ын Москва хотод эрүүл ахуйчийн мэргэжил эзэмших дамжаанд эмнэлэг гэгээрлийн болон хүүхэд багачуудын эрүүл ахуйн хос мэргэжлээр суралцуулахаар томилон явуулсан нь эрүүлийг хамгаалахын эмнэлэг гэгээрлийн албыг өргөжүүлэх, хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн салбарт судалгааны ажлыг эхлүүлэн хөгжүүлэх, залуу судлаачдыг сурган бэлтгэхэд үр өгөөжөө өгсөн үйл хэрэг болсон юм. БНМАУ-ын ЭХЯ гадаадад мэргэжил дээшлүүлээд ирсэн их эмчийг Яамны харьяа Улсын ариун цэвэр, гэгээрлийн ордны даргаар томилж, МУИС-ийн Хүн эмнэлгийн факультетийн оюутанд ерөнхий эрүүл ахуй, эрүүлийг хамгаалахын зохион байгуулалт, анагаах ухааны статистикийн хичээл заах багшаар давхар томилон ажиллуулсан байдаг [5]. Тэр үеийн оюутнуудийн дурсамжаас Чүлтэмдорж багш бол инээмсэглэл наадсан баясгалантай царайтай, эргэлдсэн том алаг нүдтэй, бадриун чийрэг биетэй, үргэлж цэвэр цэмцгэр, дэгжин хувцасладаг жинхэнэ жентельмен хүн байсан гэдэг. Мөн маш ойлгомжтой тод сайхан ярьдаг, усан будгаар сайхан зурдаг, монгол болон орос яруу найрагчдын олон шүлгийг чээжээр сайхан уншдаг, эвлүүлэн бичих гарамгай чадвартай, орос хэлэнд гарамгай хүн байсан. Тиймээс оюутнуудын оюун ухаанд цэвэр цэмцгэр, жинхэнэ эр хүн байхын үлгэр дууриал болон үлджээ гэж академич П.Нямдаваа, доктор Л.Галцог нар дурссан байдаг [6;7]. Чүлтэмдорж багшийн удирдсан Эмнэлэг Гэгээрлийн ордноос гаргасан гарын авлага, зөвлөмжүүд цаг үеийн хэрэгцээ байжээ. “Ариун цэвэр-гэгээрлийн ажлыг зохиох арга”, “Ариун цэврийн анхны мэдэгдэхүүн”, “Өвчлөлийг зогсоож, урт наслаж болно”, “Сурагчдын эцэг эхэд өгөх зөвлөлгөө”, “Хортон устгая” зэрэг олон зөвлөмж ярианы сэдвүүдийг боловсруулан хэвлэж, Эмнэлэг гэгээрлийн ордоноос түгээдэг байсан нь орон нутгийн эмч нар, эмнэлгийн ажилчдад гарын авлага болж байжээ. Тэрээр хүн амын дунд зохиох ариун цэвэр гэгээрлийн ажлын үр өгөөжид онцгой анхаарч,

хамралтын хүрээ, далайц, чанарыг дээшлүүлэхэд бодит үлгэр дууриалалт амьд сурталчилгааны хэлбэрийг сонгон авч, өргөн ашигласан нь шинэхэн бөгөөд шилдэг арга барилын нэгэн болох нь харагдсан байна[5]. Ч.Чүлтэмдорж багшийн оролцоотойгоор Ариун цэвэр халдвар судлалын ажлын талаар нам, засгийн хэд хэдэн чухал тогтоол шийдвэр гарч хэрэгжсэн.



**Багш, судлаач Ч.Чүлтэмдорж**

Тухайлбал 1958, 1963 онд МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын СнЗ-ийн “Ариун цэвэр урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах арга хэмжээний тухай “тогтоолууд гарч эдгээр тогтоолоор аймгуудад Ариун цэвэр халдвар судлалын станц, Анагаах ухааны дээд, дунд сургуулиудад эрүүл ахуйн анги байгуулах зэрэг чухал асуудлууд тусгагдан 1958-1960 онд 18 аймагт АЦХС-ын станц байгуулагдаж, 1968 онд АУДЭС-ийн эрүүл ахуйн ангийг анхны эрүүл ахуйч эмч 32 хүн төгсөж, аймаг, хотод хуваарилагдан ажилласан нь АЦХС-ын хяналтын ажлыг шинэ шатанд гаргахад чухал үүрэг гүйцэтгэсэн болно[8]. ЭХЯ-ны харъяанд 1966 онд Ариун цэвэр, халдвар судлалын төв станц, 1968 онд эрүүл ахуй, халдвар, нян судлалын улсын институтийг байгуулахад Ч.Чүлтэмдорж багш идэвхитэй оролцож үнэтэй санал, зөвлөгөө өгч байсан байна. Мөн Ч.Чүлтэмдорж багш зөвхөн хүүхдийн бие бялдрын хөгжилтийн талаар судалгаа хийгээд зогсоогүй, хөдөлмөрийн эрүүл

ахуйн талаар судалгаа хийж, мэргэжлээс шалтгаалах болон хөдөлмөрийн чадвар түр алдалт өвчин, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх талаар хэд хэдэн чухал өгүүлэл хэвлүүлж, санал зөвлөмж боловсруулсан нь зохих үр дүнгээ өгсөн юм [8]. Энэ их ажлын сацуу Их сургуульд эрүүл ахуйн хичээлийг тасралтгүй зааж бас залуу үеийн эмч эрүүл ахуйч их эмч Н.Тарваа, Д.Батчулуун, С. Манлай, Д. Цэнд, Б. Дагвасүрэн, Г.Цэрэнжигмэд нарыг дагуулан сургаж эрдмийн зэрэг хамгаалах ажлыг удирдахын завсар 1959 оноос ЗХУ-ын Москвагийн Хүүхэд багачуудын Эрдэм шинжилгээний хүрээлэнд эчнээ аспирант болж, сургуулийн сурагчдын дунд антропометрийн олон тооны шинжилгээ, судалгааг уйгагүй явуулж, дүнг нэгтгэн 1963 онд “БНМАУ-ын сургуулийн насны хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжилт” сэдвээр эрдэм шинжилгээний бүтээл туурвиж, анагаах ухааны докторын зэргийг амжилттай хамгаалсан нь тухайн үедээ эрдмийн зэрэг цолтой, хуруу даран тоологдох багш нарын нэг байжээ. Багш, судлаач Ч.Чүлтэмдорж судалгааны ажлаа үргэлжлүүлэн улам гүнзгийрүүлэхийн тулд 1970-1971 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын цалинтан болж, БНСРУ, ОХУ-д ажиллаж нийгмийн эрүүл ахуйчийн мэргэшил эзэмшив. “БНМАУ-ын хүүхэд багачуудын бие бялдрын өсөлт хөгжилтийн хөдлөл зүй” сэдвээр анагаахын шинжлэх ухааны докторын зэрэг горилох томоохон ажлыг хийж гүйцэтгэж байв. Тэрээр ийнхүү Монгол улсын өсвөр үе, хүн амын ирээдүй рүү чиглэсэн суурь судалгааг тууштай явуулснаараа эрүүл ахуйн ухааны анхны эрдэмтний хүндтэй нэр алдраар мөнхөрсөн юм. 1960 оноос Эрүүлийг хамгаалах яамны Эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, “Эрүүл мэнд” сэтгүүлийн болон Анагаах ухааны Эрдмийн цол зэрэг олгох зөвлөлийн гишүүнээр ажиллаж байлаа [5]. БНМАУ-ын СнЗ-ийн 1960 оны 342-р тогтоолоор батлагдсан “Эмнэлгийн сайчуул” өнөөгийн Эмнэлгийн тэргүүний ажилтан тэмдгийн 8 дахь шагнагдагч болсон бөгөөд уг тэмдгийн анхны загварыг гаргаж Улсын галавлетээр батлуулж олны хүртээл болгожээ [9]. Ч.Чүлтэмдорж багш олон мянган оюутны багш, монголын анхны эрүүл ахуйч эрдэмтэн байснаас гадна сайн эцэг, сайн хань байжээ. Түүний хүмүүжүүлсэн гурван хүүхдийн



хоёр охин нь эрдэмтэн, хүү нь аавыгаа дуриасан хөгжимчин болсон юм. Том охин Ч.Тунгалаг Биологийн шинжлэх ухааны доктор, профессор Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шинжээч, ХААИС-ын тэнхимийн эрхлэгч, бага охин Ч.Цолмон аавынхаа мэргэжлийг залгамжлан анагаах ухааны доктор, профессор Монголын анагаах ухааны академийн гишүүн, академич, зээ охин М.Мөнхзаяа “Монгол сурагчдын өсөлт хөгжилтийн онцлог акцелерацийн асуудалд”, ач охин Т.Хулан “Сургуулийн орчинд хийсэн эрүүл ахуйн үнэлгээ” сэдвүүдээр анагаах ухааны магистрын зэрэг хамгаалан эрдмийн ажлыг нь үргэлжлүүлж байна[10]. Эрүүл мэндийн байгууллагын ахмад зүтгэлтэн, зохион байгуулагч, эрүүл ахуйн шинжлэх ухааны манай улсад үндэслэгч, анагаах ухааны доктор, нэрт сурган хүмүүжүүлэгч Чүлтэмийн Чүлтэмдоржийн алдар гавьяа, нэр төр үеийн үед эгнэгт дуурсагдах болно.

#### Ашигласан бүтээл

1. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть “Монгол Улсын эрүүл ахуйн шинжлэх ухааны анхны эрдэмтэн Ч.Чүлтэмдорж багш” 4 тал. Улаанбаатар хот. 2012 он. “ADMON ПРИНТ” ХХК хэвлэлийн газар.
2. Сүхбаатарын сургуулийн элсэлт ба хичээлийн материалууд БХЯ-ны архив Фонд 3, данс 5, хөмрөг 5.
3. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть “Сайн нөхрөө дурсахуй” Ардын эмч, Эрүүлийг хамгаалахын гавъяат ажилтан, профессор Ч.Цэрэннадмид. 17 тал. Улаанбаатар хот. 2012 он. “ADMON ПРИНТ” ХХК хэвлэлийн газар.
4. “Алдарт офицерийн сургууль” 2003 он, Зохиогч, эмхэтгэгч “Алдарт офицерийн сургууль” 2003 он, Зохиогч, эмхэтгэгч С.Гомбосүрэн, О.Отгонжаргал, Л.Намсрайнайдан. 21-126 тал. Улаанбаатар хот
5. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть ЧҮЛТЭМИЙН ЧҮЛТЭМДОРЖ – ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖЛЭХ УХААНЫ АНХНЫ МОНГОЛ ЭРДЭМТЭН. Анагаах ухааны доктор, профессор Ц. Г. Жамба. 23-24 тал. Улаанбаатар хот. 2012 он. “ADMON ПРИНТ” ХХК хэвлэлийн газар.
6. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть “ЖЕНТЕЛЬМЕН БАГШ” Эрүүлийн хамгаалахын гавъяат ажилтан, Академич, АШУ-ын доктор, профессор П.Нямдаваа. 25 тал. Улаанбаатар хот. 2012 он. “ADMON ПРИНТ” ХХК хэвлэлийн газар.
7. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть “ЧҮЛТЭМДОРЖ” Анагаах ухааны доктор, профессор Л. Галцог. 53-54 тал. Улаанбаатар хот. 2012 он. “ADMON ПРИНТ” ХХК хэвлэлийн газар.
8. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть “Ч.ЧҮЛТЭМДОРЖ МОНГОЛЫН АНХНЫ ЭРҮҮЛ АХУЙЧ ЭРДЭМТЭН”, НЭМХ-ийн зөвлөх, Анагаах ухааны доктор Ж.Купул. 56 тал. Улаанбаатар хот. 2012 он. “ADMON ПРИНТ” ХХК хэвлэлийн газар.
9. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть “СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧ, ЖУРМЫН АНД НӨХРӨӨ НӨХӨН ДУРСАХЫН УЧИР” Төрийн шагналт, профессор Д.Дандий. 49 тал. Улаанбаатар хот. 2012 он. “ADMON ПРИНТ” ХХК хэвлэлийн газар.
10. Монголын анагаах ухааны мэргэд, XVI боть. “Удам залгамжилсан эрүүл ахуйч эмч нар” 223-241 тал.

*Сэтгүүлийн эрхэлсэн  
нарийн бичгийн дарга,  
АУ-ны доктор Л.Энхбаатар*



**“Халдварт өвчин судлалын Монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл**

<b>Ерөнхий эрхлэгч:</b>	<b>П.Нямдаваа</b> , ХӨТМҮХ-ны тэргүүн, анагаахын шинжлэх ухааны доктор, профессор академич, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, 99112306, nyamadawa@gmail.com	
<b>Дэд эрхлэгчид:</b>	<b>М.Алтанхүү</b> , Монголын вирус судлалын нийгэмлэгийн гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор, 99092337, amurd@magicnet.com <b>Г.Батбаатар</b> , Монголын дархлаа, нян судлалын нийгэмлэгийн тэргүүн, анагаах ухааны доктор, профессор, 99102212 gobi_bat@yahoo.com <b>Ч.Мөнхцэцэг</b> , Монголын тархвар судлаач эмч нарийн нийгэмлэгийн тэргүүн, ХӨТМҮХ-ны гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор, 99136244, munkh828@yahoo.com <b>Н.Наранбат</b> , Монголын сүрьеэтэй тэмцэх холбооны гүйцэтгэх захирал, “Гялс” анагаах ухааны төвийн гүйцэтгэх захирал, анагаах ухааны доктор, 99099471, naranbat@gyals.mn <b>Д.Нямхүү</b> , ХӨСҮТ-ийн ерөнхий захирал, Анагаах ухааны доктор, профессор, 99100155 <b>Д.Отгонбаатар</b> , БГХӨСҮТ-ын ерөнхий захирал, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99113549,632859 <b>Р.Оюунгэрэл</b> , Монголын халдвартын эмч нарын холбооны тэргүүн, ХӨСҮТ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, анагаах ухааны доктор, gavjiroyun@yahoo.com	
<b>Эрхэлсэн нарийн бичгийн дарга:</b>	<b>Л.Энхбаатар</b> , Анагаах ухааны доктор, 99780134, cmb1691@yahoo.com	
<b>Хүндэт гишүүд:</b>	хүрээлэнгийн Настан судлалын институтын Дархлал судлалын лабораторийн тэргүүлэх судлаач, биологийн ухааны доктор, biragina@mail.nih.gov <b>О.Баатархүү</b> , ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, дэд профессор 99188386, baatarkhuu65@yahoo.com <b>Ж.Багаа</b> , ХӨСҮТ-ийн Зоонозын халдварын тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 96012505 <b>Д.Даваалхам</b> , ЭМШУИС-ийн Эпидемиологи-биостастикийн тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, дэд профессор 91990560, dawaalkham@hsum.edu.mn <b>Я.Дагвадорж</b> , ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, профессор, 91180537, dahg-wah@yahoo.com <b>Б.Дармаа</b> , ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99754821 <b>Т.Дэлгэр</b> , ХӨСҮТ-ийн зөвлөх эмч, клиникийн профессор, хүний гавьяат эмч, 99170153 <b>Ж.Оюунбилэг</b> , НЭМХ-ийн захирал, биологийн шинжлэх ухааны доктор, профессор, 99762000, jobileg@magicnet.mn <b>Р.Туул</b> ,	ХӨСҮТ-ийн Улаан бурхны лавлагаа лабораторийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99093674, r_tuul@yahoo.com <b>Н.Хоролсүрэн</b> , ЭМШУИС-ийн халдвартын тэнхимийн багш, анагаах ухааны доктор, 99189309, khorolnran@yahoo.com <b>Ж.Хулан</b> , МУИС-ын Биотехнологийн сургуулийн багш, биологийн ухааны доктор, 99501489 <b>Н.Хүрэлбаатар</b> , Эрүүл мэндийн сайд, анагаах ухааны доктор, профессор, 99196665, khurel@nccd.gov.mn <b>Б.Цацралт-од</b> , ХӨСҮТ-ийн эрдэм шинжилгээ эрхэлсэн дэд захирал, анагаах ухааны доктор, 88031009 <b>С.Цогтсайхан</b> , ЭМШУИС-ийн Бичил амь-дархлаа судлалын тэнхимийн эрхлэгч, анагаах ухааны доктор, профессор, 91918246, tsogt_san@yahoo.com <b>Н.Цэнд</b> , ХӨСҮТ-ийн зөвлөх, анагаах ухааны доктор, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан 88858929 <b>Д.Цэрэнноров</b> , БГХӨЭСГ-ын дэд захирал, биологийн ухааны доктор, 99883159, 99069998 dno-gov_99@yahoo.com <b>Ч.Эрдэнэчимэг</b> , ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-тай тэмцэх албаны тасгийн эрхлэгч, анагаах ухааны доктор, 99263767, ch_erdenechmg@yahoo.com
<b>Д.Дандий</b> , Биологийн ухааны доктор, төрийн шагналт, 99881009 <b>Ч.Долгор</b> , ЭМШУИС-ийн зөвлөх багш, анагаах ухааны доктор, профессор, ардын эмч, 99725670 <b>Н.Дондог</b> , “Эрүүл мэнд- дархлаажуулалт” төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал, клиникийн профессор, 99948695 <b>Г.Жамба</b> , ЭМШУИС-ийн захирлын зөвлөх, анагаах ухааны доктор, профессор, гавьяат багш, 458010 <b>Гишүүд:</b> <b>Д.Абмэд</b> , ХӨСҮТ-ийн паразитологийн тасгийн эрхлэгч, биологийн ухааны доктор, 99778211, 454188 abmed99@yahoo.com <b>З. Адьяасүрэн</b> , БГХӨЭСГ-ын зөвлөх, анагаах ухааны доктор, клиникийн профессор, 99166676, adiyas_z@yahoo.com <b>Д.Анхлан</b> , ХБНГУ-ын Мюнстерийн Их сургуулийн Үрэвслийн молекул биологийн төвийн Молекул вирусологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, анагаах ухааны доктор, (45)-251-83-52214, anhlan@uni-munster.te <b>Б.Арьяа</b> , АНУ-ын Үндэсний эрүүл мэндийн		

Редакцийн хаяг:  
Улаанбаатар, Төв шуудан ш/х 119,  
“Халдварт өвчин судлалын монголын сэтгүүл”-ийн редакцийн зөвлөл  
Эрхэлсэн нарийн бичгийн дарга Л.Энхбаатар, ХӨСҮТ, Захиргааны байр,  
Амьсгалын замын вирус судлалын лаборатори  
E-mail: cmb1691@yahoo.com; Утас:455847

Хэвлэлийн дизайнер: Г. Мөнхтөр  
Цаасны хэмжээ: А4  
Хэвлэсэн тоо: 200ш  
“Оргилпресс” ХХК-д хэвлэв.